

Лиахона

Судруудаас баяр
баяслыг олж сурахуй,
х.14, 16, 20

Хажуу тийшээ биш, харин
дээшээ хар, х.42

Номлолд үйлчлэх хүмүүст
зориулсан захиас, х.48

Хүүхдүүд ээ, энэ жил Мормоны
Номтой нөхөрлөөрэй, х.60



ХУЛБАРЛАЖ БОЛОХГҮЙ

Амьдралын мод, Вилсон Ж.Онг

1 Нифай 8-д Лихай амьдралын модны тухай үзэгдэл харснаа

өгүүлсэн байдаг. Тэрбээр ийн хэлжээ:

“Би Их Эзэнд хандан залбирсны эцэст уудам болоод цэлгэр талбарыг ажиглав.

Мөнхүү улиран тохиох дор хүртсэн нэгнийг жаргалтай болгох

дур булаам жимстэй нэгэн модыг би харсан бөлгөө.

Мөнхүү улиран тохиох дор би урагшлан түүний жимснээс хүртэв; мөн энэ нь

урьд өмнө миний амсаж асан бүхнээс дээгүүр тэргүүн амтат байсныг би болгоосон

бөлгөө. Тийм ээ, мөн түүний жимс нь цагаан, урьд өмнө миний үзсэн бүхнээс

үлэмж цагаан байсныг би болгоов.” . . .

Мөн би төмөр бариулыг харав, мөн энэ нь голын эргийн дагуу сунан үргэлжилсэн бөгөөд

дэргэд нь миний зогсох тэр модны зүг удирдсан авай (1 Нифай 8:9–11, 19).



ЗАХИАСУУД

4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Элбэг хангалуун амьдрах нь

Ерөнхийлөгч Томас С.Монсон

7 Айлчлагч багшийн захиас бичиг: Айлчлагч багшийн үйл ажиллагаагаар дамжуулан анхаарал халамж тавьж, үйлчлэх нь

ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

16 Мормоны Номноос хариуг олох нь

Сара Д.Смит

Мормоны Ном амьдралыг нь хэрхэн өөрчилсөн тухай зургаан гишүүн хуваалцаж байна.

ХАВТСАН ДЭЭР
Жефф Уордын
уран зураг.



20 Дэлхийн гайхамшгийг дахин нээх ба . . . сүнсийг мэдрэхгүй байхийн аюулаас зайлсхийх нь

Адам К.Өүлсон

Мачю Пичюгийн тухай маш их зүйлийг мэдсэн судлаачид лугаа адил бид сайн мэдээг судлах тусам үүний тухай улам ихийг мэдэх болно.

24 Өдөр бүр авдаг адислалуудаа Бурханы мутрыг хүлээн зөвшөөрөхүй

Ахлагч Д.Тодд Кристоферсон

“Өдөр бүрийн талхаа” Бурханы мутраас гуйх нь Түүнд итгэж сурахын амин чухал хэсэг мөн.

32 Жорж Альберт Смит: Тэрбээр сургадаг байсныхаа дагуу амьдардаг байлаа

Тед Барнес

Мелхизедек санваартнууд болон Нийгмийн Халамжийн Бүлгийн энэ жилийн судлах цуврал хичээлийн оршил.

ХЭСГҮҮД

8 10-р сарын Чуулганы тэмдэглэлийн дэвтэр

10 Сүмд үйлчилсэн нь: Их Эзэний замаар удирдах нь
Крейг Мерилл

12 Бид Христийн тухай ярьж байна: Айлчлагч багш нар намайг Есүс Христ өөд хөтөлсөн юм.

Жейн Р.Бауэрс

14 Бидний гэр орон, гэр бүл: Мормоны Номонд дуртай болоход нь хүүхдүүдэд хэрхэн туслах вэ?

Клайд Ж.Виллямс

38 Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой

74 Сүмийн мэдээ

79 Гэр бүлийн үдшийн санаанууд

80 Биднийг дахин уулзтал: Мэргэжилтнээс суралцсан нь
Жорж К.Робинзон



42 Тэд бидэнд хандан ярив: Дээшээ хар

Ахлагч Карл Б.Кук

Бусад хүмүүс биднийг юу гэх бол гэж хэжүү тийшээ харахын оронд Бурхан юу гэх бол хэмээн биднийг дээш харахад юу тохиолддог вэ?



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Санаа: Номхон Далайг гатлахад луужсин ашигла.



46 Нүдээ олсон хариулт

48 Гэрээнүүдээ сахиуyl: Номлолд үйлчлэх хүмүүст зориулсан захиас

Ахлагч Жеффри Р.Холланд

Номлогчид бидэнд бурханлаг чанарын хүчтэй байх нэгэн чухал түлхүүр бий.

52 2012 оны Мючелийн сэдэв

Залуу эмэгтэйчүүд, Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлүүд

“Та нарын гэрэл үндэстнүүдийн хувьд жишиг байж болохын тулд босч мөн урагш гэрэлтүүл” (С ба Г 115:5).

54 Үзүүлэн: Хурцаар гэрэлт

55 Шат шатаар: Сургаал ба Гэрээ 115:5

56 Номлолын талбараас: Бурхан хоёр залбиралд хоёуланд нь хариулсан юм

Карлос Иван Гармендия Пачеко


57 Итгэлтэй бай

Ахлагч Жеральд Кауссе

Би нэгэн чухал ярилцлагын үеэр итгэлдээ үнэнч хэвээр үлдэх үү гэдгээ нэн даруй шийдэх хэрэгтэй болж билээ.



52



58 Чулуу, сум ба цасан бөмбөг

Давид Л.Фришнехт

Би хэрхэн суманд оногдохгүй байж чадах вэ? Яг л лемен хүн Самуел шиг.

60 Мормоны Номын найр

Та нар Мормоны Номыг уншсан долоо хоног бүрийг энэ хүснэгт дээр будаж тэмдэглэ.

63 Онцгой гэрч: Би зорилгодоо хэрхэн хүрч чадах вэ?

Ахлагч М.Рассел Баллард

64 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Сонгох эрх бол өөрсдийнхөө төлөө сонгох бэлэг юм

66 Есүсийн тухай түүхүүд:

Мормоны Ном Есүс Христийн тухай заадаг

Диане Л.Мангум

68 Номхон Далайн чанадад найз нөхөдтэй болсон нь

Жейн Хансен Лассетер

Юта, Тонгагийн Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд бие биенээ мэддэг болжээ.

69 Тэр Тэнгэрт байдаг

Роземари М.Виксом

Тэнгэрлэг Эцэг хүүхэд бүрийн залбирлыг сонсож, хариулдаг.

70 Бага насны хүүхдүүдэд зориулав

2012 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН ДУГААР ЛИАХОНА 10481 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Боид К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Фукс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристофферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Пол Б.Пайпер

Зөвлөхүүд: Кейт Р.Эдвардс, Кристоффел Голден Бага,
Пер Ж.Малм

Гүйцэтгэх захирал: Давид Л.Фричнхет

Редакцийн захирал: Винсент А. Вон

Зургийн дарга: Аллан Р.Лоиборг

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх туслах редактор: Женифер Л.Грийнвүүд,
Адам К.Өлсөн

Туслах редактор: Сюзан Баррет, Раян Карр

редакцийн ажилтнууд: Бриттани Бийти, Давид А.
Эдвардс, Маттью Д.Флиттон, Ларина Портер Гаунт,
Карри Кастен, Женнифер Медди, Ли МакКаллахан,
Меллиса Меррил, Майкл Р.Моррис, Салли Ж.Өдкөрж,
Жошуа Ж.Перки, Чад И.Фарес, Жан Пинбороу, Паул
ВанДенберг, Марисса А.Виддисон, Мелиса Зентено

Гүйцэтгэх Зургийн захирал: Ж.Скотт Нудсен

Зургийн захирал: Скот Ван Кампен

Уран бүтээлийн менежер: Жейн Анн Петерс

Ахлах дизайнерууд: К. Кимбалл Ботт, Томас С.

Чайльд, Коллеен Хинкли, Эрик П.Хонсен,
Скотт М.Моо

Уран бүтээлийн ажилтнууд: Коллетт Небекер

Аун, Ховард Ж.Браун, Жюли Бердетт, Режиналд

Ж.Крисченсен, Ким Фенстермейкер, Брайн В.Жижи,

Катлийн Ховард, Денис Көрби, Жинни Ж.Нилсон

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жефф Л.Мартин

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен,
Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга
болон үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн
төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо
барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вебсайт
liahona.lds.org руу; шуудангаар **Liahona, Rm. 2420,**
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024,
USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch
.org хаягаар ирүүлнэ үү.

Лиакхона нь (Мормоны Номон дахь утгаараа бол
"луужин" буюу "залагч") албани, англи, армен,
бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани,
индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати,
латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд,
норвеги, орос, польш, португали, румын, самоа,
себуано, солонгос, тагало, тай, тахити, тонга, украин,
унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад,
чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд
нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2012 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх
хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиакхона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон
гэрт ашиглахын тулд хувиулж болно. Урлагийн
бүтээлийг хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг
хувиулал олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн
талаарх асуултаа Intellectual Property Office, 50 E.
North Temple St., Salt Lake City, UT 84150, USA хаягаар;
эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@
ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:


January 2012 Vol. 13 No. 1. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a
year (January, April, June, July, October, and December)
by The Church of Jesus Christ of Latter-day Saints,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA
subscription price is \$5.00 per year; Canada, \$6.00
plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt
Lake City, Utah. Sixty days' notice required for change
of address. Include address label from a recent issue;
old and new address *must* be included. Send USA and
Canadian subscriptions to Salt Lake Distribution Center
at address below. Subscription help line: 1-800-537-
5971. Credit card orders (Visa, MasterCard, American
Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake
Distribution Center, Church Magazines, PO Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368.

Дэлгэрэнгүй мэдээллийг

онлайнаас үзэж болно

Liahona.lds.org



ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиакхона болон Сүмийн бусад материа-
луудыг олон хэлээр www.languages.lds.org
.org—аас үзэж болно.

НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛАВ

Энэ дугаарын нэлээд хэдэн өгүүлэл
судруудын тухай, ялангуяа Мормоны
Номын тухай өгүүлж байна (хуудас 14,
16, 20-ийг үз). Ахлагч Давид Б.Беднар
2010 оны Дөрөвдүгээр сарын ерөнхий
чуулган дээр Мормоны Номыг судлах нь
гэр бүлүүдийг хэрхэн бэхжүүлдэг тухай
ярьсан юм. Түүний хэлсэн үгийг унших
буюу сонсохын тулд [lds.org/general-](http://lds.org/general-conference/2010/04/watching-with-all-perseverance)
[conference/2010/04/watching-with-all-](http://lds.org/general-conference/2010/04/watching-with-all-perseverance)
[perseverance](http://lds.org/general-conference/2010/04/watching-with-all-perseverance)-т орж үз.

Мачю Пичю уруу хийх аялал сайн
мэдээг судлах гурван зөвлөмжийг өгч
байна (хуудас 20-ийг үз). Дэлхийн энэхүү
гайхамшгийн тухай өөр зарим зургийг
liahona.lds.org -аас үзнэ үү.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Номлолд үйлчлэх хүмүүст өгсөн Ах-
лагч Холландын зөвлөгөөг уншсаны
дараа та [http://lds.org/study/topics/](http://lds.org/study/topics/missionary-work)
[missionary-work](http://lds.org/study/topics/missionary-work)-өөс номлолын
ажлын тухай илүү олон өгүүлэл,
мэдээллийг олж үзэх болно.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг
зааж байгаа болно.

**Бошиглогчид (эш
үзүүлэгчид), 32**

Гэр бүл, 14, 16, 79

Гэрээнүүд, 48

Донтолт, 16

**Есүс Христ, 24, 40,
66, 80**

**Залбирал, 8, 24, 38,
42, 55, 58, 69**

**Ижил хүйстэнд
сэтгэл татагдах,
47**

Итгэл, 24, 57, 63

**Мормоны Ном, 14,
16, 20, 40, 60, 66**

Мючел, 52, 54, 55

Наманчлал, 16

**Номлолын ажил,
8, 32, 39, 41, 46,
48, 56, 70, 72**

**Смит Жорж
Альберт, 32**

Сонгох эрх, 24, 64

**Судар судлах, 14,
16, 20, 40, 55, 60**

Сүмийн түүх, 32

**Сүнсийг дагах
нь, 41**

**Хүнд сорилтууд,
24, 40**

**Хөрвөлт,
хөрвүүлэг, 16**

Энэрэл, 7, 12, 32

**айлчлагч багшийн
заалт, 7, 12**

**гэрийн
багшлалт, 10
зан авир, 4, 42,
52, 63**

зориг, 4, 8, 57

зорилго, 63

найдвар, 4, 16

нөхөрлөл, 47, 68

сургалт, 14, 80

тэнгэр элчүүд, 47

удирдлага, 10

**Үйлчлэл, 10, 12, 24,
32, 38, 46**

**Үлгэр дууриал, 52,
54, 57, 70, 72**

Ерөнхийлөгч
Томас С.Монсон



Элбэг хангалуун АМЬДРАХ НЬ

Шинэ онтой золгож байгаа энэ мөчид би элбэг хангалуун амьдрал хэмээн нэрлэж байгаа амжилт бүтээл, сайн сайхан байдал, адислааар дүүрэн амьдралын төлөө хүн бүр нөр хичээнгүй эрэл хайгуул хийхийг газар бүрийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдээс уриалан хүсч байна. Бид сургуульд үндсэн суурь мэдлэг эзэмшдэг шиг, элбэг хангалуун амьдрахад бидэнд туслах өөрийн үндсэн зарчмын тухай өгүүлье.

Аливаад өөдрөг үзлээр хандаж бай.

Эхний зарчим нь зан төлөв. Америкийн анхны сэтгэл судлаач, философич Виллям Жеймс, “Манай үеийнхэнд тохиосон хамгийн агуу хувьсгал бол дотоод зан төлөвөө өөрчилснөөр амьдралынхаа гадаад талыг өөрчилж чадна гэдгийг хүмүүн төрөлхтөн нээсэн явдал мөн” гэж бичжээ.¹

Амьдралд өдий төдий зүйл бидний зан төлөвөөс шалтгаалдаг. Юмсыг ойлгохоор бидний сонгосон арга, бусад хүмүүстэй

харилцах бидний харилцаа юм бүхэнд нөлөөлдөг. Хэрэв бид чадах бүхнээ хийж, байгаа нөхцөлдөө аз жаргалтай байхаар сонгох юм бол амьдралын нөхцөл нь ямар ч байлаа гэсэн аз жаргал, сэтгэл ханамжийг авчрах болно.

Зохиолч, соён гэгээрүүлэгч, Христийн шашны пастор Чарльз Свиндол: “Зан төлөв нь миний хувьд өнгөрсөн үе болон мөнгө төгрөг, амьдралын нөхцөл байдал, азгүйтэл, амжилт ололт, бусад хүмүүсийн юу гэж бодох, юу гэж хэлэхээс илүү чухал. Энэ нь гадаад байдал, авьяас бэлэг буюу ур чадвараас илүү чухал юм. Энэ нь компани, сүм, гэр орныг үүсгэн бий болгох буюу эвдэн бусниулж чадна. Бид ямархуу байдалтай байх талаараа өдөр бүр сонголт хийдэг нь үнэхээр гайхалтай зүйл юм.”²

Бид хүрээлэн байгаа дэлхийд хяналт тавьж чадахгүй. Гэвч бид дэлхийтэй харилцан ажиллахад хяналт тавьж чадна. Аз жаргал, амар амгалан сэтгэл хангалуун байхын төлөө аливаа зүйлд өөдрөг үзлээр ханддаг байцгаая.



Өөртөө итгэ

Хоёр дахь зарчим бол өөртөө, эргэн тойрныхоо хүмүүст түүнчлэн мөнхийн зарчмуудад итгэх итгэл юм.

Өөртөө болон өрөөл бусдад мөн Тэнгэрлэг Эцэгтээ үнэнч шударга бай. Бурханд шударга бус хандсанаа засч залруулахад нэгэнт оройтсон хүн бол ширээт лам Уолси байлаа. Шекспирийн өгүүлснээр тэрбээр урт удаан амьдралаа гурван хаанд үйлчлэхэд зориулж, эд хөрөнгө, эрх мэдлээр бялхаж явсан аж. Эцэстээ, тавтиргүй нэгэн хаан түүний эрх мэдэл, эд хөрөнгийг булаан авсан гэнэ. Ширээт лам гашуун нулимс урсган:

*Ганицхан Бурхандаа л зүрх
сэтгэлээ зориулан үйлчилсэн ч болоосой*

*Би хаандаа үйлчилсэн. Тэр
миний насны хүн биш байлаа*

*Намайг дайснуудад минь гар
нүцгэн тавьж өглөө хэмээн
уйлсан гэдэг.*³

17-р зууны үед амьдарч асан, Английн шашны зүтгэлтэн, түүхч Томас Фуллер: “Итгэлийнхээ дагуу амьдардаггүй хүнд жинхэнэ итгэл байдаггүй” гэсэн энэхүү үнэнийг тэрлэжээ.⁴

Өөрийгөө бүү хазаарла. Чи хийж чаддагаасаа илүүт хийж чадахгүй гэж ятгах боломжийг бусдад бүү олго. Өөртөө итгэлтэй байж, боломж бүхнээ дайчлан амьдар.

Тэгвэл чи чадна гэж өөрийнхөө итгэсэн тэр зүйлд хүрч чадна. Итгэл, бишрэлтэй бай.

Сорилт бэрхшээлийг зоригоор даван туул

Эрийн ёсоор амь насаа зориулахад бэлэн байх төдийгүй, зохистой амьдрах шийдвэр төгс байсан үед зориг нь үнэ цэнэтэй, утга учиртай хүч болдог билээ.

Америкийн нийтлэлч, яруу найрагч Ральф Вальдо Эмерсон ийн хэлсэн байдаг. “Юуг ч хийлээ гэсэн танд зориг хэрэгтэй. Таныг ямар нэг юм хийхээр сонгох үед энэ нь буруу байвал, буруу байна шүү гэдгийг хэлж өгөх хүн ямагт бэлэн байдаг. Намайг шүүмжилсэн хүмүүсийн зөв юм байна гэдэгт итгэх уруу таталтын үе ч бас байдаг. Явах замаа тодорхойлж, үүнийг эцсээ хүртэл дагах нь цэрэг хүнд байдагтай адил зоригийг шаарддаг. Амар амгалан нь зоригтой эрчүүд, эмэгтэйчүүдийг ялалтанд хүргэдэг.”⁵

Айж бэргэн, урам хугарах үе танд тохиолдох болно. Өнгөрч дээ гэж бодох үе ч ирж мэднэ. Ялалтанд хүрэх нь санаанд оромгүй, сэтгэл догдлом байж магадгүй. Зарим үед танд Голиаттай тулалдах гэж байгаа Давид шиг санагдаж болно. Гэвч санагтун—Давид *ялсан* шүү дээ!

Хүслэн болсон зорилгодоо хүрэхийн төлөө эхний алхмыг хийхэд зориг шаардагддаг. Гэвч хүн бүдэрч, зорилгодоо хүрэхийн төлөө дахин хүч чармайлт гаргаж байгаа үед бүр ч илүү зориг шаардагддаг.

Хүч чармайлтаа дайчилж

ажиллахын төлөө тууштай бай.

Зөв зорилгын төлөө нэгэн үзүүрт сэтгэл гарган ажилласан үед зориг нь зайлшгүй ирэх сорилт бэрхшээлийг даван туулах төдийгүй, дахин хүч чармайлт гаргахад ч шаардлагатай юм. “Зарим үед зориг нь өдөр дуусахад ‘Маргааш дахин оролдоод үзье дээ’ гэх намуухан дуу хоолой байдаг.”⁶

Ирж байгаа шинэ ондоо аливаад өөдрөг сэтгэлээр хандан, зорилго, амлалтдаа хүрч чадна гэдэгт итгэлтэй байж, замдаа тохиолдож болох ямар ч сорилт бэрхшээлийг даван туулах зоригтой байцгаая. Тэгвэл элбэг хангалуун амьдрал биднийх байх болно. ■

ЭШЛЭЛ

1. Виллям Жеймс, Ллойд Альберт Жонсоны эмхтгэл, *A Toolbox for Humanity: More Than 9000 Years of Thought* (2003), 127.
2. Чарльз Свиндол, Daniel H. Johnston, *Lessons for Living* (2001), 29.
3. Виллям Шекспир, *King Henry the Eighth*, 3-р бүлэг, 2-р үзэгдэл, бадаг 456–58.
4. Thomas Fuller, H. L. Mencken, хянан тохиолдуулсан. *A New Dictionary of Quotations* (1942), 96.
5. Ralph Waldo Emerson, Roy B. Zuck, *The Speaker's Quote Book* (2009), 113.
6. Мэри Анн Радмакер, *Courage Doesn't Always Roar* (2009).

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Өөрсдөдөө итгэж, ямар нэг зүйлд өөдрөг сэтгэлээр хандсан эсвэл зориг хэрхэн тусалсан талаар хувийнх нь туршлагыг гэр бүлийн гишүүдээр хуваалцуулахад анхаар. Эсвэл эдгээр гурван зарчмын жишээг судруудаас олохыг тэднээс хүс. Судруудын тухай болон өөрийнхөө туршлагын талаар залбирч бодон, заахдаа бэлтгэж болно.

Шуургыг сөрсөн зориг Маддисон Морли

Манай гадасны Залуу Эмэгтэйчүүдийн аялал-зугаалгын хоёр дахь шөнө аадар бороо шаагин орж, хар салхи хөдлөв. Манай тойргийн 24 залуу эмэгтэй хоёр удирдагчтайгаа аялал-зугаалгаар явж байлаа. Бид хамгаалалт эрж бүгдээрээ хоёр жижиг модон байшингийн нэгэнд нь багтан толгой хоргодлоо. Бороо хувингаар цутгасан юм шиг орж, салхи улам ширүүсэв. Манай гадасны ерөнхийлөгчийн хэлсэн аюулгүй байдлын залбирлыг би байнга санасаар байлаа. Бид бүлгээрээ жижиг модон байшин дотроо залбирал хэлэхэд би ч хувийн залбирлаа хийлээ.

Олон охин айж байлаа. Энэ ч бас аргагүй байв. Манай байшин тийм ч бат бөх бишээс гадна бид голын дэргэд байлаа. 20 минут орчмын дараа шуурга улам ширүүсэхэд, гадас бүхлээрээ тойргийнхоо жижиг байшингаас гарч, илүү өндөр газарт байгаа зөвлөхүүдийн байшин уруу гүйлдэв. Гадасны ерөнхийлөгч маань дахиад нэг залбирахад бид өөрсдийгөө тайвшруулахын тулд дуулал, Хүүхдийн Хэсгийн дуу, аяллын дуунууд дууллаа. Үнэндээ бид айж байсан ч, бүх юм хэвийн болно гэдгийг мэдэрч байлаа. Хагас цагийн дараа байдал дээрдэж, бид тойргийнхоо байшингуудад буцаж очив.

Шуурга яагаад намдсаныг бид хожим нь мэдэж билээ. Хар салхи хоёр хуваагдаж, нэг нь бидний баруун талаар, нөгөө нь зүүн талаар өнгөрсөн байв. Бидний байсан газраар өнгөрсөн хар шуурга тийм ч их хүчтэй биш байжээ!

Тэр шөнө Бурхан бидний залбирлыг сонссоныг, Тэрээр биднийг хамгийн хүчтэй хар салхинаас хамгаалсныг би мэднэ. Бурханд хэрэгтэй байгаагүй бол хар салхи яагаад хоёр хуваагдах билээ? Бид амьдралын шуурганд Тэнгэрлэг Эцэгтээ хандан үргэлж залбирдаг бөгөөд Тэрээр сонсож хариулан биднийг зоригжуулж, бидэнд хэрэгтэй аюулгүй байдлын хамгаалалтыг өгдөг билээ.

Ахмад Моронай

Ахмад Моронай хүнд сорилтуудтай тулгарсан Аүедээ Тэрбээр үнэн, эрх чөлөө, итгэл бишрэлийг ямагт эрхэмлэн дээдэлж хайрладаг байв. Тэрээр нифайчуудад эрх чөлөөгөө хадгалан үлдэхэд туслахын төлөө амь биеэ зориулсан юм. Та нар өөрсдөдөө тохиолдсон сорилт бэрхшээлийг зоригоор даван туулснаар Ахмад Моронайтай адилхан байж чадна. Та нар өөрсдөдөө болон гэр бүлдээ чухал зүйлүүдийг доор эсвэл цаасан дээр тусад нь бичсэнээр өөрсдийнхөө эрх чөлөөний тугийг хийж болно.

Хаанаас илүү их мэдээлэл олж үзэж болох вэ?

Алма 46:11-27: Эрх чөлөөний туг

Алма 48:11-13: Моронайн зан чанар



Энэ материалыг судалж, гэрээр нь очиж заадаг эгч нартай аль болох тохиромжтой арга замаар ярилц. Эгч нарын итгэлийг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.



Айлчлагч багшийн үйл ажиллагаагаар дамжуулан анхаарал халамж тавьж, үйлчлэх нь

“Энэрэл гэдэг бол ач буяны мэдэрмжээс хавьгүй илүү зүйл юм. Энэрэл нь Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээс бий болдог бөгөөд Түүний Цагаатгалын үр дүн мөн” гэж Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хенри Б.Айринг сургажээ.¹ Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нарын хувьд айлчлагч багшийн үйл ажиллагаа нь Аврагчид итгэх итгэлээ хөгжүүлэн ашиглах чухал арга зам мөн.

Бид айлчлагч багшийн үйл ажиллагаагаар дамжуулан эгч бүртэй холбоотой байж, сайн мэдээний захиасыг хуваалцан, түүний өөрийнх нь болон гэр бүлийнх нь хэрэгцээг мэдэхийг хичээдэг. “Бидний анхаарал тоон дээр биш, хүмүүс дээр төвлөрсөн үед айлчлагч багшийн үйл ажиллагаа Их Эзэний ажил болдог. Чухамдаа, айлчлагч багшийн үйл ажиллагаанд эцэс төгсгөл гэж ерөөсөө байдаггүй. Энэ бол ажил үүрэг гэхээс илүү амьдралын хэв маяг юм. Айлчлагч багшаар итгэлтэй үйлчлэх нь бидний хувьд шавь байхын нотолгоо мөн” гэж Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч Жюли Б.Бек тайлбарлажээ.²

Бид байнга залбирч, анхаарал халамж тавьсан үед эгч нар болон тэдний гэр бүлийн хэрэгцээг хамгийн сайнаар шийдвэрлэж, тэдэнд тусалж чадна. Үйлчлэл олон хэлбэртэй, зарим нь өргөн хүрээтэй, зарим нь жижигхэн байж болно. “Хэн нэгний гэр бүлийн талаар санаа тавьж асуух, урам хайрласан ганц хоёр үг хэлэх, чин сэтгэлээсээ магтаал, талархал илэрхийлж утсаар товчхон ярих зэрэг үйлчлэлийн



жижигхэн үйлдлүүд нь хүний сэтгэл санааг өргөж, түүнийг адислах нь олонтоо тохиолддог. Хэрэв бид сонор соргог, ажигламтгай байж, өөртөө ирдэг сүнсний өдөөлтүүдийн дагуу үйлдэх юм бол сайн сайхан үйлс олныг бүтээж чадна. . . . Нийгмийн Халамжийн Бүлгийн айлчлагч багш нарын агуу армийн үзүүдэг үйлчлэл тоо томшгүй олон юм” гэж Ерөнхийлөгч Томас С.Монсон сургасан билээ.³

Судруудаас

Иохан 13:15, 34–35; 21:15; Мозая 2:17; Сургаал ба Гэрээ 81:5; Мосе 1:39

Би юу хийж чадах вэ?

1. Тэдний төлөө санаа тавьж, тэднийг хайрладаг үнэнч найз гэдгээ эгч нарт мэдрүүлэхийн тулд би юу хийх ёстой вэ?

2. Би бусдад хэрхэн илүү сайн анхаарал халамж тавьж чаддаг болох вэ?

Итгэл, Гэр бүл,
Халамж

Бидний түүхээс

1843 онд Иллинойн Науву дахь Сүмийн гишүүд дөрвөн тойрогт хуваагджээ. Тэр жилийн 7-р сард Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид дөрвөн эгчээс бүрдсэн айлчлагч багшийн хороог тойрог бүрт томилжээ. Айлчлагч хороодын үүрэгт эгч нар болон тэдний гэр бүлийн хэрэгцээг тодорхойлж, хандив цуглуулах ажил ордог байжээ. Нийгмийн Халамжийн Бүлэг цуглуулсан хандивыг тусламж хэрэгтэй хүмүүст олгодог байв.⁴

Айлчлагч багш нар хандив цуглуулахаа больсон ч, эгч нарын сүнсний болон материаллаг хэрэгцээг тодорхойлж, тэдгээр хэрэгцээг шийдвэрлэхийн төлөө ажиллах үүрэг нь хэвээр үлдсэн ажээ. Нийгмийн Халамжийн Бүлгийн хоёр дахь ерөнхий ерөнхийлөгч Элиза Р.Снөү (1804–87) тайлбарласан нь: “Багш хүн . . . хэн нэгний гэрт орохдоо тэнд ямар сүнс тэй тулгарахаа мэдэхүйц тийм хэмжээгээр Их Эзэний Сүнс тэй байх ёстой.” . . . Тухайн айлд ямар сүнс ноёрхдогийг мэдэж, тэр дагуу үйлдэх боломжтой байхын тулд . . . мөн амар амгалан болон тайтгарлын үгсийг ярихын тулд [Сүнс тэй] байхын төлөө Бурхан, Ариун Сүнс хоёроос гуй. Хэрэв та тухайн эгчийн сэтгэл санаа тааруухан байгааг мэдвэл, хүүхдийг эх нь энхрийлэн цээжиндээ тэвэрдэг шиг сэтгэлийг нь бүлээцүүлж урам хайрла.”⁵

Эшлэл

1. Хенри Б.Айринг, “The Enduring Legacy of Relief Society,” *Ауахона*, 2009 оны 11-р сар, 121.
2. Жюли Б.Бек, “Relief Society: A Sacred Work,” *Ауахона*, 2009 оны 11-р сар, 114.
3. Томас С.Монсон, “Three Goals to Guide You,” *Ауахона*, 2007 оны арваннэгдүгээр сар, 120–21.
4. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 105-ыг үз.
5. Элиза Р.Снөү, *Daughters in My Kingdom*, 108.

Нэмэлт мэдээллийг www.reliefsociety.lds.org-аас үзнэ үү.

10-р сарын Чуулганы ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭР

"Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно"
(С ба Г 1:38).

2011 оны 10-р сарын ерөнхий чуулганы талаар эргэн санахын тулд амьд бошиглогч, төлөөлөгчдийн сүүлийн үед заасан зүйлсээс сурч, амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд та нар эдгээр хуудсуудыг (мөн дараагийн дугаарууд дахь Чуулганы тэмдэглэлүүдийг) ашиглаж болно.



ЧУУЛГАНЫ ЯРИАНААС

Ганцаар зогсох зоригтой бай

Дэлхийн 2-р дайны дараахан Нэгдсэн Улсын усан цэрэгт алба хааж байхад итгэлийнхээ төлөө зориг гарган зогсох шаардлага анх удаа тулгарсан юм. . . .

Би эхний долоо хоногийн ням гарагийг ямагт санадаг. Бид ахлах офицероос баяртай мэдээ дуулсан билээ. Калифорнийн сэрүүн салхинд сургалтынхаа талбайд жагсан зогссоны дараа ахлагч маань: "Өнөөдөр надаас бусад нь бүгдээрээ сүмд явах болно. Харин би амарна!" хэмээн тушаав. Тэгээд тэр "Бүх католикчууд Декатурын лагерьт цуглана. Тэндээсээ гурван цаг болтол эргэж ирж болохгүй. Урагшаа алхаад, марш!" гэж хашгирав. Ихэнх цэргүүд түүний тушаалаар хөдлөв. Тэр дахин чангаар, "Та нарын дундах еврейчүүд Хенригийн лагерьт цуглана. Тэндээсээ гурван цаг болтол эргэж ирж болохгүй. Урагшаа алхаад, марш!" хэмээн бархирав. Хэдэн хүмүүс алхан одов. Тэгээд тэр, "Үлдсэн про-тистантчуудаа, та нар Фаррагутын лагерийн бага танхимд цуглаарах болно. Гурван цаг болтол эргэж ирэх хэрэггүй. Урагшаа алхаад, марш!" гэв.

Тэр даруй миний бодол санаанд, "Монсон, чи бол католик биш, чи еврей ч биш, чи мөн про-тистант ч биш. Чи бол Мормон, тиймээс яг эндээ

Тэр мөчийг хүртэл миний ард хүн зогсож байсныг би мэдээгүй байсан юм.



зогсоод үлдээрэй!" гэсэн бодол орж ирлээ. Надад гав ганцаараа юм шиг санагдаж байсан гэдгийг би та нарт батлан хэлж чадна. Тиймээ, эр зоригтой, шийдэмгий гэвч ганцаараа.

Тэгж байтал би ахлах офицероос сайхан үг сонсох нь тэр. Тэр миний зүг хараад, "За та нар чинь ингэхэд хэн гэдэг нь билээ?" хэмээн асуув. Тэр мөчийг болтол би сургалтын талбай дээр өөрийнхөө ард өөр хэн нэгэн байгааг огт анзаараагүй байсан юм. Бид бараг нэг зэрэг "Мормончууд!" хэмээн хариулсан билээ. Өөрийнхөө ард зогсох хуруу дарамхан усан цэргийг харахад зүрх сэтгэл минь ямар их баяраар дүүрснийг дүрслэн хэлэхийн аргагүй юм.

Тэгтэл бүрэн бус эрхэт ахлах офицер толгойгоо маажин таавар тааж ядан байх мэт бодож байснаа эцэст нь, "За яахав, уулзах газраа өөрсдөө олцгоо. Тэгээд гурван цаг болтол бүү эргэж ирээрэй. Урагшаа алхаад, марш!" гэв. . . .

Хэдийгээр нөхцөл байдал санаснаас өөрөөр эргэсэн ч, би хэрэгтэй болвол ганцаар зогсохдоо бэлэн байсан юм.

Энэ явдлын дараа ч гэсэн миний ард зогсох хэн нэгэн үгүй байх үе олонтоо тохиолдсон бөгөөд тэр бүхэнд би ганцаараа зогсож байсан билээ. Би олон жилийн тэртээ итгэлдээ үнэнч хүчтэйгээр үлдэж, хэрэгтэй бол шашныхаа төлөө тэмцэхэд байнгын бэлтгэлтэй байя хэмээн шийдсэндээ ямар талархалтай байна вэ.

Ерөнхийлөгч Томас С.Монсон "Ганцаар зогсох зоригтой бай" *Лиахона*, 2011 оны 11-р сар, 61–62.

Бодож тунгаах асуултууд:

- Итгэлтэй, зоригтойгоор зогсох нь бусдад хэрхэн нөлөөлдөг вэ?
- Танд өөрийн итгэл болон зориггоо харуулах үе тохиолдож байсан уу? Тэр үед та юу хийсэн бэ?
- Итгэлтэй зоригтой зогсохын тулд бид хэрхэн бэлтгэж чадах вэ?

Өөрийн бодол санааг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, энэ талаар бусад харилцан ярилц.

Энэ сэдвээр нэмэлт материалууд: Guide to the Scriptures, "Courage, Courageous"; Томас С.Монсоны "The Call for Courage," *Лиахона*, 2004 оны 5-р сар, 54–57; Study by Topic on LDS.org, "Peer Pressure"; *For the Strength of Youth*, "Go Forward with Faith."

Ерөнхий чуулганы үгсийг conference.lds.org-оос уншиж, үзэж мөн сонсох боломжтой.

Урагш явж бас хий

Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын Ахлагч Л.Том
Перри Сүмийн тухай ойл-
голтыг сайжруулахад бид юу
хийх хэрэгтэйг заасан:

“Төгс хайр нь айдсыг хөөн зай-
луулдаг” *Лиахона* 2011 оны 11-р
сар, 42–43.



1. “Есүс Христийг тунхаг-
лахдаа зоригтой байна.
Түүнийг бүх хүн төрөлхт-
ний түүхийн хамгийн чухал
Хүн байсан гэдэгт итгэдэг
гэдгээ бусдад мэдүүлэхийг
хүсэх хэрэгтэй.



2. Бусдад зөв шударга
байдлын жишээ бол. . . .
Дэлхийд Түүний жишээг
харуулахыг хичээхийн тулд
бидний амьдрал сайн сай-
хан бөгөөд ариун бүхний
жишээ болж байх ёстой.



3. Сүмийг сайшаан ил тод
ярьж бай. Бид итгэлийнхээ
талаар бусадтай хуваалцах
олон боломжоор адислагд-
сан байдаг.

Бошиглогд- сон амлалт

“Тэнгэр дэх Эцэгтэйгээ
залбирлаар дам-
жуулан холбогдоогүй нэг
ч өдөр гэж надад үгүй
билээ. Тэнгэрлэг Эцэгтэй-
гээ харилцалгүйгээр би
төөрөлдөх байсан учраас
энэ харилцаагаа дээдлэн
хайрладаг. Хэрэв та нар
Тэнгэр дэх Эцэгтэйгээ
ийм харилцаа холбоо
тогтоогоогүй бол би та
нарыг өмнөө зорилт тавин,
ажиллаж эхлээсэй хэмээн
хүсч байна. Ингэж чадваас
аяллынхаа туршид сүнсээ
хадгалан үлдэхэд туслах
Түүний урам хийгээд удир-
дамжийг хүртэх эрхтэй
болох болно. Ийм сүнслэг
байдал, урам дэмжлэг нь
биднийг эрэлхийлсэн үед
л харамгүйгээр өгөгддөг
бэлэг юм.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон
“Ариун газруудад зогсогтун”
Лиахона, 2011 оны 11-р сар, 84.

ХООСОН ОРХЬСОН ЗАЙГ БӨГЛӨӨРӨЙ

1. Залбиралтайгаар суралцсанаар _____ Эцэг Бурхан болон
Түүний Хайрт Хүү хийгээд сайн мэдээнд итгэх итгэлийг өс-
гөдөг. Энэ ном эрт эдүгээгийн Бурханы бошиглогчдын тухай
таны итгэлийг батжуулах болно. Энэ ном таныг өөр ямар ч
номноос илүүтэйгээр Бурханд ойртуулах болно. Мөн таны
амьдралыг сайн сайхан болгоно.” (Хенри Б.Айринг “Гэрч”
Лиахона 2011 оны 11-р сар, 70.)
2. А _____ цаг хугацаа өнгөрсөн ч хагацашгүй үнэнч анд
болдог.” (Ричард Ж.Скотт “Судрын хүч,” *Лиахона* 2011 оны
11-р сар, 6.)
3. Туулж байгаа зовлонгоо шударга бус зүйл гэж үзэж байгаа
хүмүүсийн хувьд _____ амьдралын бүх шударга
бус зүйлийн өр төлөөсийг төлдөг. (Квентин А.Кук “Тэдний
дуулж чадаагүй дуунууд” *Лиахона* 2011 оны 11-р сар, 106.)
4. “Бидэнд бололцоо байх үед _____ бид тусламж хэ-
рэгтэй хүмүүст хариу нэхэлгүйгээр тусалж, үйлчлэхэд бэлэн
байдаг. (Силвия Х.Аллред “Энэрэл хэзээ ч дуусдаггүй” *Ли-
хона* 2011 оны 11-р сар, 115.)

Харуулгач: 1. Мормоны Ном; 2. цээжст-
лэ сурдаг; 3. Цаацагч; 4. эцэгтэй.

ИХ ЭЗЭНИЙ ЗАМААР УДИРДАХ НЬ

Крейг Мерилл БЯИС-ийн Бизнесийн
удирдлагын хөтөлбөрийн магистр, захирал

*Бид ямар дуудлагатай нь
хамаагүй, Их Эзэний замаар
үйлчилж, удирдсан үед өөрс-
дөө ч адислагдаж, өрөөл
бусдыг ч адислах болно.*

Жонс ах хүүтэйгээ Виллямынхны гэр бүлд гэрийн багшаар томилогдоод сар бүр тэднийд очдог болжээ. Виллямын охин Ким гэрийн багш нар нь өөрийнх нь төлөө анхаарал халамж тавьж байгааг тэдний айлчлалтаас мэдсэн гэнэ. Тэр охин сайн мэдээний тухай олон асуулт асуудаг байсан бөгөөд тэдэнтэй ярилцахдаа дуртай байлаа.

Нэг зун Ким өөрт нь гэрчлэл байгаа эсэхийг мэдэх гэж чармайж байсан үед Жонс ах болон өөр нэг Мелкизедек санваартан Залуу Эмэгтэйчүүдийн аялал зугаалганд хамт хариуцаж явахаар болжээ. Аялал зугаалгын үеэр гэрийн багштайгаа хамт байсан нь маш сайхан байлаа хэмээн Ким хожим нь дурсчээ. Жонс ах өөр нэг Мелкизедек санваартны хамт зугаалгын үеэр өөрийнх нь хүсэлтээр түүнд санваарын адислал өгсөн үед Аврагчийн тухай гэрчлэлтэй болсон гэж тэр гэр бүлдээ ярьсан ажээ.

Гэрийн багш нар нь Виллямын гэр бүлийн жинхэнэ анд найзууд болсон гэнэ. Тэдний нөлөө Ким, түүний эцэг эх болон Их Эзэний хувьд чухал учир холбогдолтой байлаа.

Удирдлага ба дуудлага

Өнөөгийн дэлхийд хүний хувийн өсөлт хөгжилт, амжилт бүтээлийг хэр зэрэг өндөр албан тушаал хашдаг эсвэл хэр зэрэг их цалин

авдаг нь хэмжих явдал нийтлэг болжээ. Бид ажил албан тушаалыг нийгэмд оруулдаг тухайн хүний хувь нэмрийн чухал үзүүлэлт гэж үзэх нь олонтаа тохиолддог. Сүнс-лэг байдлын өсөлт хөгжилтөө хэрхэн хэмжихийг мэдэхийн төлөө олон хүн хичээн чармайдаг нь гайхмаар зүйл биш.

Олон Хожмын Үеийн Гэгээнтэн Сүмд удирдах албан тушаалуудад дуудагдаагүй учраас өөрсдийн өсөлт хөгжилтийн талаар эргэлздэг тухай би сонссон. Гэвч бидний өсөлт хөгжилтийг удирдлагын дуудлагуудаар хэмжиж болно гэж үү?

Хэрэг дээрээ бол удирдах арга барилд дуудлага шаардлагагүй юм. Зарим хүмүүс дуудлага буюу албан тушаалгүйгээр жинхэнэ удирдлагын үлгэр жишээг харуулж, сэтгэл санааг өргөн, урам дэм хайрлагч нөлөө үзүүлдэг. Сургаал ба Гэрээний 121-р хэсэгт удирдлагын тухай чухал сургамжийг заасан байдаг:

“Тэд бага ч гэсэн эрх мэдэлтэй боллоо хэмээн өөрсдөө бодмогцоо тэр даруй шударга бусаар эзэгнэж эхлэх болно гэдэг нь бараг бүх хүний мөн чанар хийгээд авир төрх юм гэдгийг бид гашуун туршлагаар мэдэж авлаа.

Иймээс олон нь дуудагдааг хэдий ч, цөөхөн нь сонгогддог болой.

Хүч буюу нөлөө нь санваарын ариун журмаар төдийгүй гагцхүү

сэнхрүүлээр, тэсвэр тэвчээрээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр тэтгэгдэж чадах буюу байх ёстой ажгуу;

Нинжин сэтгэл, мөн цэвэр мэдлэгээр энэ нь зусардалтгүйгээр мөн заль мэхгүйгээр оюун санааг агуу ихээр өргөжүүлэн тэлдэг буюу” (шүлэг 39–42)

Удирдлагыг хүмүүст юу хийхийг нь хэлж өгөхтэй хольж хутгах нь нийтлэг тохиолддог. Энэ нь буруугаар нөлөөлөхөд хөтөлж болно. “Би ингэж хэлж байгаа учраас” (Би санваартан учраас, эсвэл санваарын эрх мэдлээр дуудагдсан учраас) чи үүнийг хийх ёстой гэж хэлэх нь зохимжгүй. Хэсэг 121 дэх нэг чухал сургамж бол жинхэнэ удирдагч хүн удирдамж өгдөггүй, харин албан тушаалынх нь улмаас хүмүүс түүнийг зүгээр л дагахыг хүсэн хүлээдэг нь 121-р хэсэг дэх чухал сургамж юм. Ийнхүү, санваартны удирдлага нь урилга юм. Цэвэр мэдлэг, чин сэтгэлийн хайр дээр үндэслэсэн найрсаг урилга нь “Би ингэж хэлж байгаа учраас” гэсэн үгсээс илүү агуу үр дүнтэй байх болно.

Тушаал буулгадаг удирдагчид их зүйлийг хийлгэж чаддаг нь үнэн л дээ. Гэвч тэд Их Эзэний илчилсэн арга замаар удирдаж чаддаггүй. Түүнчлэн тэд удирдаж байгаа хүмүүсийнх нь дунд байх ёстой бие даах чадвар, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлдэггүй.



Жинхэнэ удирдлага

Шүлэг 41, 42-т дуудлага буюу эрх мэдэл бүхий албан тушаалыг хүч буюу зохих нөлөө үзүүлэх арга зам гэж үзээгүй байна. Харин үүний оронд жинхэнэ удирдагчийн хүч буюу нөлөө нь сэнхрүүлэл, тэсвэр хатуужил, эелдэг дөлгөөн зан, чин сэтгэлийн хайр, нинжин сэтгэл, цэвэр мэдлэгээр дамжин илэрдэг. Жинхэнэ удирдагчийн эдгээр чанаруудыг дуудлага буюу албан тушаалаас хамааралгүйгээр бүх хүмүүс харуулж чадна.

Удирдлагын дуудлагууд нь унадаг дугуйны дасгалын дугуйтай маш төстэй юм. Дасгалын дугуй нь тэнцвэрээ олж суран, дугуйгаар итгэлтэй явж сурах боломжийг хүүхдэд олгодог. Удирдлагын дуудлага нь бусдыг хайрлах, тэвчээртэй байх, цэвэр мэдлэг болон нинжин сэтгэлээр дамжуулан сэнхрүүлэхэд хүмүүсийг сургадаг билээ. Хүний зан төлөвийг албадах аливаа оролдлого нь Сүнсний үгүй болгож, үр нөлөөг нь бууруулдгийг тэд бас мэднэ.

Бид дуудлагаас чөлөөлөгдсөний дараа дуудлагатай байсан үедээ

хэрхэн өсч хөгжин, юу сурч мэдсэнээ ойлгох болно. Дуудлага нь нөлөөлөх хүч болоогүй тохиолдолд бид бусдыг хайрлаж, тэдэнд үйлчилж сурсан уу? Бид сайн хүмүүс болсон учраас бусдад нөлөөлөх хүчтэйгээр үйлчилж сурсан уу?

Их Эзэн биднийг бүхэл амьдралын туршид дахин давтан уриалан дуудах болно. Тэрбээр бидний зүрх сэтгэлийг мэддэг. Түүнд бидний хүн нэг бүрийн үр чадвар, мэдлэг, Сүнсний мэдрэх чадвар хэрэгтэй болсон үед Тэрбээр биднийг дууддаг. Түүний дуу хоолойг сонсох бидний хүсэл болон Тэр биднийг хайрладгийн адилаар Түүнийг бид хэрхэн хайрладгийн дагуу Тэрбээр биднийг дуудах болно.

Бид Их Эзэний замаар бусдад хэрхэн сайн нөлөө үзүүлэхийг сурсан тохиолдолд өөрсдийн үлгэр жишээгээр бусдыг өргөн дэмждэг хүмүүс болно. Бусдад сайн нөлөө үзүүлэхэд дуудлага анхдагч шалтгаан болж чадахгүй. Гэсэн хэдий ч, биднээс хүссэн үед бид Сүмийн дуудлагадаа сайн үйлчлэх ёстой.

ИТГЭЛТЭЙ ШАВЬ БАЙХ НЬ

“Сүмийн бүх удирдагчид бусад хүмүүст ‘Есүс Христийн. . . үнэн дагалдагчид’ (Моронай 7:48) . . . болоход нь туслахаар дуудагддаг.

Удирдагчид бусад хүмүүст хэрхэн ‘үнэн дагалдагчид’ болохыг үлгэр жишээгээрээ хамгийн сайн зааж чадна. Итгэлтэй шавь болоход нь бусдад туслахын тулд өөрөө итгэлтэй шавь байх энэхүү загвар нь Сүм дэх дуудлага бүрийн цаадах зорилго юм.”

Гарын авлага 2: Сүмийг удирдах нь (2010), 3.1.

Бид Ням гарагийн хичээл болон залуучуудын хөтөлбөрүүдэд, эсвэл гэрийн болон айлчлагч багшаар, тэр ч байтугай, бишоп эсвэл Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчөөр үйлчилээ гэхэд бусдад үйлчилсэн бидний үйлчлэл Аврагчийг хайрлах бидний хайрын илрэл байх болно. Бид ямар дуудлагатай нь хамаагүй, Их Эзэний замаар үйлчилж, удирдсан үед өөрсдөө ч адислагдаж, өрөөл бусдыг ч адислах болно. ■

Айлчлагч багш нар НАМАЙГ ЕСҮС ХРИСТ ӨӨД ХӨТӨЛСӨН ЮМ

Жейн П.Бауэрс

“[Их Эзэн] [Петрт] гурав дахь удаагаа, Чи Намайг хайрладаг уу? гэхэд [Петр], Эзэн, Та бүх юмсыг мэддэг. Миний Танд хайртайг Та мэднэ гэв. Есүс түүнд, Миний хоньдыг хариул гэлээ” (Иохан 21:17).



АЙЛЧЛАГЧ БАГШ БАЙХААС ИРДЭГ АДИСЛАЛУУД

“Сүмийн үйл ажиллагаанд эргэж ирсний шалтгаан нь сар бүр гэрт нь ирж, тэдэнд үйлчлэн, хайрлаж, адислан, авралын ажил хийдэг, итгэлтэй айлчлагч багш нар байсан хэмээн олон эмэгтэйчүүд ярьдаг. . . .

“Та нарын айлчлалаас ирдэг хамгийн чухал адислал нь заримдаа зүгээр л сонсох явдал байх болно. Сонсох нь тайтгарал, ойлголт, эдгэрэлт авчирдаг. Заримдаа та нар уйлж байгаа хүүхдийг тайтгаруулахад нь туслахын тулд ханцуй шамлан, гэр оронд нь ажиллах хэрэгтэй болж мэднэ.”

Барбара Томпсон, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, “And of Some Have Compassion, Making a Difference,” Лиахона, 2010 оны 11-р сар, 120.

1970-аад оны сүүлчээр нэг найз маань Нийгмийн Халамжийн Бүлэгт өөртэйгөө хамт явахыг надаас хүсч билээ. “Тэр чинь юу юм бэ?” гэж би асуулаа. Найз маань, “Очоод үз л дээ” гэв. Хөөх! Бүр эхний мөчөөс л миний сэтгэл хөдөлсөн гээч!

Тэр зун оройхон Леанн манайд ирж, миний гэрийн багш гэдгээ хэллээ. Энэ нэг бодоход хачирхалтай, нэг бодоход гайхалтай юм шиг санагдав. Тэр тусмаа би Сүмийн гишүүн биш байхад шүү! Ингээд тэр сүнсдэг бодлоо надтай хуваалцахын тулд зав чөлөөгүй хуваариасаа цаг гаргаж, надад хэрхэн, юугаар тусалж болохыг шалгаж эхэллээ. Тэр үнэхээр чин сэтгэлээсээ хандаж байгааг би түүний санаа сэтгэлээс мэдэж байлаа. Би Леанныг болон надтай хуваалцдаг байсан захиасуудыг хэзээ ч мартахгүй.

Хоёр жил өнгөрсний дараа Францес манай тойрогт шилжиж ирлээ. Би хараахан гишүүн болоогүй байсан болохоор үнэндээ энэ нь “манай” тойрог байж чадахгүй байв. Гэвч би тэр тойргийг манай тойрог гэж боддог байлаа. Тэр үед би хоёр бяцхан охинтой байсан бөгөөд Сүмийн туслах бүлгүүд охидын минь амьдралыг хэрхэн

адисалсныг харсан юм. Бороотой ч байсан, нартай ч байсан, миний шинэ айлчлагч багш надад хичээл, сонирхолтой түүх зааж, инээд баясал бэлэглэн, туслагч гар болдог байлаа. Нэгэн завгүй үдээс хойш Францес манайд ирснийг би санадаг. Францес намайг ярьж, суух ч завгүй байгааг хараад охиндоо тусалж байх хооронд маань миний хийж байсан хоолыг хутгаж эхэллээ.

Олон жил өнгөрсний дараа би шилжив. Сүмийн нөхдөө орхиход би үнэхээр дургүй байсан ч удалгүй “шинэ” тойргийнхоо Нийгмийн Халамжийн Бүлэгт бат бөх гэрчлэлтэй, өгөөмөр уужуу сэтгэлтэй эгч нартай танилцлаа. Нийгмийн Халамжийн Бүлгийн нэг багш бидэнд чимэглэх хуудас өгч, дээд талд нь “Найрсаг бай” гэж өдөр бүр бичихийг дэмждэг байв. Миний дэргэд сууж байсан эгч нар болон би “Энэрэл хэзээ ч дуусдаггүй” (Моронай 7:46) гэсэн Нийгмийн Халамжийн Бүлгийн уриаг онцгойлон дэмжих нь агуу санаа гэж бодлоо.

Дараа нь би нэг анхдагч эмэгтэйн тухай түүх уншив. Тэр эмэгтэйг хүүхэд байхад алслагдсан бөглүү нутагт Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн сууринг байгуулахад туслахыг түүний гэр



бүлээс хүссэн гэнэ. Дүү нарынх нь нэг нь эндэж, тэдэнд уй гашуу тохиолджээ. Ээж нь санаа сэтгэлээр унаж, гэр бүл нь гүнзгий уй гашууд автав.

Нэг өдөр нөгөөх бяцхан охин цонхоор гадагш харж байж. Гэр бүлийнх нь даруухан байшингийн эргэн тойронд цас нэвсийтэл дарсныг охин харсан гэнэ. Хоёр хүн гэрийг нь чиглэн аажуухан алхан ирж байгааг бяцхан охин алсын бараа харагдах газраас харсан гэнэ. Аажуухан алхсаар ирж буй хоёр хүн нь ээжийнх нь айлчлагч багш нар болохыг охин таньжээ.

Энэ түүх надад сүнсэлэг нөлөө үзүүлсэн юм. Би 1983 онд баптисм хүртсэн. Би өөрөө айлчлагч багш болсон нь нэр хүндтэй хэрэг байлаа. “Эрдэнэсээс ч үнэтэй,” “арван хуруу тэгш” (Сургаалт Үгс 31:10) үлгэр жишээч олон эмэгтэйчүүдтэй харилцаатай байхдаа би дуртай. Түүнчлэн эелдэг уриалгахан байж, бие биеэ хайрлан, бусдыг Христэд авчрахыг хичээдэг эмэгтэйчүүдтэй хамт байх нь сайхан байдаг. ■

Айлчлагч багш нар сайн мэдээний захиасыг хуваалцдаг бөгөөд заримдаа туслагч гар болдог. Тэдний айлчлан очдог эгч нар, эелдэг уриалгахан байж, бие биеэ хайрлан, бусдыг Христэд авчрахыг хичээдэг эмэгтэйчүүдтэй хэлхээ холбоотой байснаар итгэл нь бат бөх болдог.

Нэмэлт мэдээллийг Жюли Б.Бек, “‘Daughters in My Kingdom’: The History and Work of Relief Society,” *Лиахона*, 2010 оны 11-р сар, 112; Хенри Б.Айринг, “The Enduring Legacy of Relief Society,” *Лиахона*, 2009 оны 11-р сар, 121.

АЙЛЧЛАГЧ БАГШ НАР ҮЙЛЧЛЭЛЭЭРЭЭ ХЭРХЭН АДИСЛАГДДАГ ВЭ?

Барбара Томпсон Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаан дээр хэлсэн “And of Some Have Compassion, Making a Difference” (*Лиахона*, 2010 оны 11-р сар, 120) гэсэн үгэндээ энэ асуултанд хариулахад тусалжээ:

“Би айлчлагч багшаар явдаг байхдаа сэтгэл санаа үргэлж сайхан байдаг байлаа. Сэтгэл санаа өөдрөг, бусдаар хайрлуулан, айлчилж очдог эгчээсээ илүү адислагддаг байлаа. Хайр минь, бас үйлчлэх хүсэл минь өсөн нэмэгдсэн. Бид бие биендээ хэрхэн анхаарал халамж тавих талаар Тэнгэрлэг Эцэг бидэнд зориулан гайхамшигтай арга зам төлөвлөснийг би харж чадсан юм.”

Айлчлагч болон гэрийн багшийн үйл ажиллагааны тухай гэрчлэлээ өдрийн тэмдэглэлдээ бич.

МОРМОНЫ НОМОНД ДУРТАЙ БОЛОХОД НЬ ХҮҮХДҮҮДЭД ХЭРХЭН ТУСЛАХ ВЭ?

Дор дурдсан арга хэрэгслүүд хүүхдүүдэд Мормоны Номноос заахад үр өгөөжтэй болохыг бид мэдсэн юм.

Клайд Ж.Виллямс

Зохицуулалтын хэлтэс

Эхнэр бид хоёр таван хүүхдээ өсгөж, гэр бүлээ төлөвшүүлэхэд хүүхдүүдээ Мормоны Номонд дуртай болгохыг туйлын их хүсдэг байлаа. Мужаанууд янз бүрийн багаж хэрэглэдэг шиг хүүхдүүдээ судруудыг хайрладаг байхыг зааж сургахад олон янзын арга ашиг тустай төдийгүй амин чухал болохыг бид мэдсэн юм. Хүүхдүүдээ заах арга хэрэгсэл буюу арга техниктэй байх нь нэг хэрэг харин тэдгээрийг хэрэглэх нь өөр хэрэг гэдгийг бид хоёр бас ойлгосон юм.

Түүнээс гадна Мормоны Номыг амьдралдаа хэрхэн хэрэглэх болон бидний аж төрж байгаа дэлхийтэй энэ ном хэрхэн холбоотой болохыг ойлгох нь бидэнд хэрэгтэйг бид мэдсэн юм. Хүүхдүүдээ туслахын тулд янз бүрийн аргыг хэрэглэх бидний чадвар нь судруудыг ойлгох бидний өөрсдийн ойлголт, судрууд үнэн болох тухай бидний гэрчлэл, урам зоригоос юуны өмнө хамааралтай юм.

Бага насны хүүхдүүдэд заах нь

Судруудын хэл ямар нэг хэмжээгээр нийтэд ойлгомжгүйн сацуу хүүхдийн үг хэллэг хязгаарлагдмал учраас Мормоны Номонд дуртай болохыг хүүхдүүдэд заахад сорилт бэрхшээл учирч

болно. Манай хүүхдүүд бага байхдаа анхаарлаа нэг зүйл дээр удаан төвлөрүүлж чаддаггүй байсан болохоор судар судлах бидний цаг мөн л богинохон байлаа. Бид гэр бүлийн судар судалгаандаа судрын зурагтай түүхүүдийг олонтоо ашигладаг байсан.


Хүүхдүүдийнхээ судраас уншиж, ойлгосон зарчмуудыг бататгахын тулд би судрын түүхүүдийг унтахаас нь өмнө ярьж өгдөг байлаа. Энэ нь их үр нөлөөтэй байсан тухай хожим нь манай охин дурсан ярьдаг байв. “Дахин дахин ярьж өгдөг байсан судрын түүхүүдэд бид дуртай болсон гэж би боддог. Та бидний орны дэргэд суугаад судрын түүхүүдийг хуваалцдаг байж билээ. Бид нас бага байсан болохоор судрын түүхүүдийн захиасын үзэл санааг мэдэрч чаддаггүй байсан ч судрын түүхүүдэд дуртай болж, тэдгээр түүхүүдэд итгэлтэй, эрэлхэг зоригтой хүмүүсийн тухай өгүүлдгийг мэддэг байсан учраас түүхүүдийг дахин дахин ярьж өгөхийг гуйдаг байлаа. Бид тэдэнтэй адилхан байхыг хүсдэг болсон юм” гэж охин минь ярьсан юм.

Хичээлүүдийг гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулах нь

Мэдээж хэрэг, хүүхдүүдээ өсч том болсон үед бид Мормоны Номноос шууд уншдаг болсон. Хэдийгээр манай зарим хүүхэд хөнжил дотроо нүдээ хагас аниастай байдаг ч, бид судруудаас өглөө бүр итгэлтэйгээр уншихыг хичээдэг байсан. Гэсэн ч тэд анхааралтай сонсож, үйл явдлуудыг санан, ирээдүйн үр суулгаж байснаа одоо ярьдаг.

Бид бас гэр бүлийн үдшийн үеэр судруудаа онцгой анхаарал хандуулдаг байлаа. Жишээ нь, гэр бүлийн зарим гишүүд судрын аль нэг түүхийг жүжиглэн тоглож, бусад нь уг түүхийг таадаг байсан судрын таавар мэт үйл ажиллагаануудыг бид гэр бүлийн үдэштээ олонтоо оруулдаг байлаа. Манай хүүхдүүд бас “Би хэн бэ?” гэдэг тоглоомоор тоглох дуртай байлаа. Бид энэ тоглоомоор Мормоны Номонд гардаг хүмүүсийг таах олон түлхүүр санааг хүүхдүүдэд өгдөг байсан. Хүүхдүүд маань өсөхийн хэрээр гэр бүлийн үдшийн хичээлүүдэд бэлтгэж, заахад оролцдог болсон.

Бид гэр бүлийн үдшээ гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулан, зарчмуудыг заахад туслахын



тулд Мормоны Номын түүх шастируудыг ашигладаг байлаа. Жишээ нь, бид ёс суртахуун болон порнографиас зайлсхийх тухай хичээлүүдийг Алма 39 дэх хүү Кориантондоо өгсөн Алмагийн зөвлөгөөнөөс заадаг байсан. Биен дээрээ элдэв шивээс хийлгэхээс зайлсхийх тухай сайн хичээлийг Алма 3-аас зааж болно.

Би Нифайн амьдралаас сэдэвлэн хүүхдүүдийн хоорондын зөрчил, сөргөлдөөнийг хэрхэн шийдвэрлэвэл зохих тухай хичээлийг бэлтгэж

Бид Мормоны Номын түүхүүдийг үдэш унтахынх нь өмнө ярьж өгөхөд олонтоо ашигладаг байлаа.

билээ (1 Нифай 7:20–21; 16:4–5), Иаков (2 Нифай 2:1–3) болон Кориантоныг үз (Алма 39:1, 10-ыг үз). Алма 14:12–28 дахь Алма, Амюлек нарын тухай сонирхолтой түүх нь гай зовлон тохиолдсон үед тэвчээртэй байх тухай заадаг. Эдгээр болон бусад олон асуудлаар бидний сурч мэдсэн нэг чухал зарчим бол тэдгээр асуудлууд хүүхдүүдийн минь амьдралд бодитой сорилт болохоос өмнө хүүхдүүдээ сэрэмжлүүлж, хор уршигийг нь ойлгуулах явдал мөн.

Асуултууд асуух нь

Бид хүүхдүүдтэйгээ хамт судруудыг уншдагаас гадна уншсан зүйлийнхээ утгыг ойлгоход нь хүүхдүүдээ туслах асуултуудыг асуух нь чухал болохыг бид ойлгосон юм. Асуултуудын хүнд хөнгөн нь хүүхдийн наснаас хамааралтай байх боловч тэдэнд заах гол зүйл нь Мормоны Номноос санаануудыг шинээр нээж олон, амьдралдаа хэрэглэхэд нь тэдэнд туслах явдал мөн.

Жишээ нь, Нифай яагаад “амьдралынхаа турш өчнөөн зүдгүүрийг туулсан” гэсэн атлаа дараагийн мөрөнд нь “Их Эзэний өндөр ээл хишгийг хүртсэн” (1 Нифай 1:1) хэмээн өмнөхөөсөө эсрэг зүйлийг хэлсэн гэж бодож байгааг нь би хүүхдүүдээсээ асууж билээ. Их Эзэн Нифайг зовлон зүдгүүрээс нь чөлөөлсний сацуу Өөрийн нууцуудын тухай агуу ойлголтыг Нифайд өгснийг манай хүүхдүүд бидний ярилцлагын явцад олж мэдсэн юм (1 Нифай 1:1, 20-ийг үз).

Үнэнүүдийг олж мэдэхэд нь туслахын тулд бид хүүхдүүдээ тусалсан үед хүүхэд, залуучууд юмсыг сан ойлгож мэддэг билээ. Тэд ингэснээр Мормоны Номонд дуртай болж, амьдралынхаа туршид уг номын үзэл санааг хэрэгжүүлэн, бусдад туслахын тулд үүнийг ашиглах хэрэгтэйг мэдрэх болно.

Мормоны Ном бодит хүмүүсийн бодит түүхийг агуулсныг бид мэдэж байсныг хүүхдүүд маань мэдсэн юм. Тэд Мормоны Номны тухай бидний харсан зүйлийг хардаг, мэддэг зүйлийг мэддэг, мэдэрдэг зүйлийг мэдэрдэг болсон билээ. Энэ нь тэдний итгэлийг бэхжүүлж, Мормоны Номонд дуртай болоход нь тусалж, мөн өөрсдийнхөө хүүхдүүдийг ийм болгоход удирдан хөтөлдөг. ■



МОРМОНЫ НОМООС ХАРИУТ ОЛОХ НЬ

Сара Д.Смит

Дэлхий дээрх бидний аялал сорилт бэрхшээлүүдтэй тулгарч болох ч хайрт Тэнгэрлэг Эцэг биднийг асуудал бэрхшээлээ ганцаараа шийдвэрлэг хэмээн дэлхийд илгээгээгүй юм. Бидэнд өгсөн Түүний агуу тусламжуудын нэг нь Мормоны Ном юм. Энэ ном зөвхөн сайн мэдээний бүрэн байдлыг заадаг төдийгүй бас бидэнд тохиолддог асуудал сорилтуудын дундуур биднийг удирддаг билээ. Бид Мормоны Номыг судлах юм бол асуудал бэрхшээлүүдийн хариут олоход Сүнс бидэнд туслах болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Расселл Баллард ийн гэрчилжээ: “Мормоны Ном миний мэддэг бүх номноос илүүтээр бидний хувьд амьдралын асуудал сорилтуудад хариут олох хамгийн агуу эх сурвалж юм. . . .

Асуудал сорилтуудтай тэмцэж байгаа хүмүүс Мормоны Номыг уншсан үед амар амгалан амьдралд нь хэчнээн удаа ирсэн бол! Энэ номноос үүдэлтэй сүнслэг удирдамжийн жишээ тоолох аргагүй олон юм.”¹

Гишүүд эрж байсан хариугаа Мормоны Номноос хэрхэн олсон тухай дараах шастуруудад хуваалцаж байна.

Зүрх сэтгэлийн өөрчлөлтийг биеэрээ мэдэрсэн нь

АНУ-ын Калифорнийн Грег Ларсен (нэрийг өөрчлөв) бага байхдаа сайн мэдээний тухай мэдсэн ч хожим нь сүмийг орхисон аж. Тэрээр мансууруулах бодисонд орж, удалгүй шоронд хоригджээ. Тэр амьдралаа хэвийн болгож өөрчлөхийг хүссэн ч чухам яаж гэдгээ мэдэхгүй байжээ.

“Орон нутгийн тойргийн эрчүүд шоронд ирж ням гарагийн хичээл заадаг байсан. Хэрэв би Мормоны Номыг уншвал амьдрал минь дээрдэх болно гэж тэдний нэг нь надад хэлсэн. Тиймээс би энэ номыг уншдаг байлаа.

Шоронгоос гараад сүмдээ эргэж очсон ч нөгөөх муу зуршилдаа эргэж орсон. Мормоны Номыг цааш уншсанаар Хаан Лемонайн хүмүүсийн ‘зүрх сэтгэл өөрчлөгдөж, тэд хилэнцийг үйлдэх хүсэлгүй болсныг’ Алма19:33 мэдсэн билээ. Зүрх сэтгэлийн ийм өөрчлөлтийн төлөө би залбирч эхэлсэн” гэж Грег бичжээ.

“Зүрх сэтгэлийн өөрчлөлтийг авчрах тэрхүү итгэл хийгээд наманчлалын” тухай заадаг Хиламан 15:7-аас Грег залбирлынхаа хариут олсон ажээ.

“Эдгээр үгсийг уншихад нүүрийг минь даган нулимс урсаж билээ. Тэнгэрлэг Эцэг миний надад хайртай бөгөөд надад туслах болно гэдгийг Сүнс надад гэрчилсэн юм. Хэрэв бишоптойгоо ярилцах хангалттай итгэл надад байсан бол дажгүй л байх байсан гэж би боддог. Би нүглээ Аврагчийн хөлд тавьснаар жинхэнэ зүрх сэтгэлийн өөрчлөлтөд хүрсэн билээ.”

Замаа олсон нь

АНУ-ын Айдахогийн Лора Свенсон нэг өдөр санаагаар унаж, нулимс урсгасаар гэртээ иржээ. Лора гэрлээгүй бөгөөд коллежид орж, ажлын гараагаа эхлэх төлөвлөгөө болон мөрөөдөл нь нуран унасан ажээ. “Бүр хаашаа явахдаа ч мэдэхгүй байлаа” гэж тэр бичжээ.

“Мормоны Номонд хандахаар сүнсээр өдөөгдөв. 1 Нифай 18-аас би асуудлынхаа хариут олсон юм. Дээрх шүлгүүдэд гэр



Хаан Лемонайн хүмүүсийн ‘зүрх сэтгэл өөрчлөгдөж, тэд хилэнцийг үйлдэх хүсэлгүй болсныг’ Алма 19:33-аас би мэдсэн билээ. Зүрх сэтгэлийн ийм өөрчлөлтийн төлөө би залбирч эхэлсэн юм.”



ХУВИЙН АСУУДЛУУДАА ШИЙД

“[Мормоны Ном] хувийн асуудлуудад нэн бодитой арга замаар тусалж чадна. Муу зуршлаасаа салахыг хүсч байна уу? Гэр бүлийнхээ доторх харилцааг сайжруулахыг хүсдэг үү? Сүнснийхээ хүч чадлыг дээшлүүлэхийг хүсдэг үү? Мормоны Номыг унш!”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон, “Мормоны Номын тухай гэрчлэл,”
Лиахона, 2000 оны 1-р сар, 85.

бүлээ амлагдсан нутаг уруу авч явахаар Нифайн барьсан усан хөлөг онгоцны тухай өгүүлдэг. Уг усан онгоцыг ‘нямбайлан урнаар дархалсан’ бөгөөд ‘хүмүүсээр сургагдсан тэр маягаар (шүлэг 1–2) бэлтгэсэнгүй; харин Их Эзэн үзүүлсэн тэр маягаар барьсан билээ.’ Нифай усан онгоц барьж байхдаа Их Эзэнтэй байнга зөвлөж байв. Усан онгоц дуусахад ‘энэ нь сайн болсон мөн . . . үүний ур хийц үлэмж сайн байлаа’ (шүлэг 4).

“Миний хувийн аялал ‘өвөрмөц сонин’ байсныг ойлголоо. Энэ нь хүмүүнд асуудал тохиолдоход ямар байдагтай адилгүй харин Их Эзэний удирдамжийг эрэлхийлэхийн тулд хаашаа явах хэрэгтэйг надад харуулсан юм. Дээрх шүлгүүд харанхуйд надад гэрэлт цамхаг болсон билээ. Миний асуудлууд нэг шөнийн дотор нэг тийш болсонгүй, харин би өөртөө хэрэгтэй хэтийн төлөвийг олж мэдсэн юм. Эдүгээ би хэзээ ч төлөвлөж байгаагүй тийм их урам хайрлагч ажилтай байна.”

Бас нэгэн гэрээг илрүүлж мэдсэн нь

Гондурас залуу Адриан Раз Замбрано Библи яагаад зөвхөн Иерусалимын эргэн тойрон дахь нутгийн тухай өгүүлдэгт мөн Есүс Христ бусад үндэстнүүдэд айлчилж очсон гэдэгт эргэлзэж гайхдаг байжээ.

“Түүнээс хойш олон жилийн дараа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хоёр номлогч манайд хүрч ирлээ” гэж Адриан бичжээ. Тэд надад Мормоны Номыг үзүүлж, Христ Америк

тивд айлчилсан тухай 3 Нифайг уншихад намайг урив.

Уншаад үзтэл, бага байхад надад тулгардаг байсан асуултууд энд байлаа. Асуултуудын хариуг ч олов. Би Мормоны Номын ачаар Есүс Христ Амиалтынхаа дараа Америк тивд айлчилсныг мэдсэн юм. Бурхан бүх хүүхдээ хаана байдаг ямар нөхцөлд амьдардгийг үл харгалзан хайрладгийг би мэдсэн ураас баяр хөөрөөр дүүрэн байлаа.

Адриан эхнэртэйгээ хамт Сүм үнэн үү гэдгийг мэдэхийн тулд хамт залбирч, хоёул гэрчлэлтэй болсон гэнэ. Тэд баптисм хүртэж, гишүүнээр батлагдан, нэг жилийн дараа гэр бүл нь ариун сүмд лацдан холбуулжээ.

Гэр бүлээ тэжээсэн нь

АНУ-ын Нью Мексикийн Эрик Жеймс 30-тайдаа бөөрний өвчтэй болох нь оношлогдсон аж. Залуу эцэг тэрээр гэр бүлээ тэжээж чадах болов уу хэмээн санаа сэтгэлээр унаж, аргаа баржээ.

Мормоны Номыг уншаад Нифай сайн чанарын гангаар хийсэн нумаа хугалсан үед мөн ингэж бодож байсныг мэдлээ. Гэвч Нифай модоор нум хийсний дараа гэр бүлээ тэжээх боломжтой болсон аж. (1 Нифай 16:18–32-ыг үз.)

“Нифайн түүх гялбах гэрэл лүгээ адил сэтгэл санааг минь өргөж, Нифайн ган нумтай адил болоод байсан эрүүл мэнд минь бүр сайжирсан гээч. Эрүүл мэнд минь муудсан үед миний нум хугарсан юм шиг санагдаж билээ. Харин Их Эзэн бөөр шилжүүлэн суулгах мэс заслаар дамжуулан намайг модон нумаар адисалсныг би ойлгосон. Бөөр шилжүүлэн суулгах мэс засал гэр бүлээ тэтгэх хүч чадлыг бас итгэл найдварыг надад өгсөн юм. Эдүгээ бараг 10 жилийн дараа би гэр бүлээ тэжээхийн хамт чадах чинээгээрээ Их Эзэнд үйлчилсээр байна.”

Дуулгавартай байдлыг хүүхдүүдэд заах нь

Аргентины Хуан Хосе Резанович хүүхдүүдээ бага байхад тэдэнд хэрхэн зааж,

өсгөн хүмүүжүүлэх асуудалтай тулгарсан үедээ Мормоны Номонд хандсан гэнэ. “Эхнэр бид хоёр хүүхдүүддээ сүнслэг нөлөө үзүүлэх судруудыг эрсээр хариуг нь үргэлж олдог байлаа.”

Резановичийнхэн 1 Нифай 3:5–6 дахь Нифайн үлгэр жишээг тэдэнд харуулах замаар хүүхдүүддээ дуулгавартай байдлыг заадаг байлаа:

“Ах нар чинь бувтналдаж, тэднээс миний шаардсан зүйлийг хүнд бэрх гэцгээв; гэвч болгоогтун, тэднээс үүнийг шаардсан нь би биш, харин энэ бол Их Эзэний зарлиг.

Тиймийн тул яв, хүү минь, мөн чи дургүйцээгүй учир Их Эзэний адислалыг ч хүртэх болно.”

“Нифай дэлхийн эцэг эхээ болон Бурханы юмст хүндэтгэлтэй ханддаг байсныг бид хүүхдүүддээ заадаг байлаа” гэж Хуан бичжээ. “Бид Нифайн дуулгавартай, хүндэтгэлтэй ханддаг зан төлөвийг гэр бүлийнхээ зорилго болгосон юм.

Манай бүх хүүхэд номлолд үйлчилсэн. Бид хүүхдүүдээ номлолд үйлчлэх ёстой гэж шахаж шаардаагүй. Тэд сайн оюутан, сайн найз нөхөд, сайн хүүхдүүд болсон юм. Манай гэр бүл төгөлдөржиж, зорилгодоо хүрэхэд Мормоны Ном маш их тусалсан билээ.”

Донтолтын хүлээснээс зайлсхийх нь

АНУ-ын Ютагийн Сюзан Лант хоолны хэнхэг болж донтсон үедээ тусламж гуйн залбирсан гэнэ. Тэрээр Мормоны Номонд хандаж, ах нар нь гар хөлийг хүлсэн хүлээснээс чөлөөлөгдсөн тухай уншжээ.

“Ай Их Эзэн Танд итгэх миний итгэлийн улмаас та намайг ах нарын минь гараас зайлуулаач; тийм ээ, намайг хүлсэн энэ хүлээсийг тасар татах хүчийг надад өгөөч.

Мөнхүү улиран тохиох дор . . . хүлээс алдуурав” (1 Нифай 7:17–18).

“Энэ судар намайг донтолтын хүлээсэнд байх үед санаа сэтгэл минь ямар байсныг яг дүрсэлсэн байлаа. Нифайн гар, хөлний хүлээс чөлөөлөлтийг гуйсан

даруйд тайлагдсан юм” гэж Сюзан бичжээ. Миний хүлээс олс дээс биш байсан ч тухайн үед донтолтыг даван туулж чадахгүй байсан ч дээрх үгсийг уншаад дотор сэтгэлдээ ямар нэг зүйлийг мэдэрч билээ. Миний зүрх сэтгэл, оюун ухаан, биеийг минь хүлсэн хүлээс тайлагдсаныг мэдэрч, донтолтыг даван туулж чадсанаа мэдэж билээ.

Тэрээр Мормоны Номноос олсон сүнслэг нөлөөнийхөө ачаар өөрийг нь хүлсэн муу зуршил, уур уцаар, аминч үзэл, бардамналыг ялж, үлэмж өсөлт дэвшил гаргаж чадсан ажээ. “Мормоны Ном бол Бурханы үг гэдгийг, амьдралын аливаа асуудлуудын хариуг энэ номноос олж болно гэдгийг би мэднэ.” ■

Эшлэл

1. М. Рассел Баллард, “We Add Our Witness,” *Tambuli*, 1989 оны 12-р сар, 13.

МОРМОНЫ НОМЫН ХАРИУ

- Одоо би дараа нь амьдралдаа юу хийх вэ? (1 Нифай 4:6; Алма 37:36-г үз.)
- Гэр бүлийн амьдралаа хэрхэн улам сайжруулах вэ? (1 Нифай 5:1–9-ийг үз.)
- Юуны учир би тэмдэглэл хөтлөх хэрэгтэй вэ? (Иаков 1:2–4; Алма 37:2–4; Хиламан 3:13–15-ыг үз.)
- Би яаж улам илүү сайн найз байж чадах вэ? (Алма 15:18-ыг үз.)
- Дуудлагаа хэрхэн сайн биелүүлж болох вэ? (Алма 17:2–12-ыг үз.)
- Юуны төлөө залбирах ёстой вэ? (Алма 34:17–27-г үз.)
- Наманчлах болон өөрчлөгдөхөд Цагаатгал надад хэрхэн тусалж болох вэ? (Алма 36-г үз.)
- Хүн надад найрсаг бус хандсан үед би яах ёстой вэ? (Алма 60–62-ыг үз.)
- Гэр бүлээ дэлхийн нүгэл хилэнцээс хэрхэн хамгаалах вэ? (Хиламан 5:12; Моронай 8:2–3-ыг үз.)
- Би яагаад сүмд явах ёстой юм бэ? (Моронай 6:5–9-ийг үз.)

Судар судлах зөвлөмж: Өөртөө тулгардаг асуултуудын жагсаалт хийж, судруудыг судлахдаа залбирч, хариуг нь хүлээ.

*Мэдэмхийрэх нь “тэнгэрээс
ирэх аливаа тэмдэг эсвээс
гайхамшигт улам багаар цо-
чирдон гайхах болж эхлэхэд”
биднийг хөтөлж мэднэ.*



Адам К.Өүлсон

Сүмийн сэтгүүлүүд



ДЭЛХИЙН ГАЙХАМШГИЙГ дахин нээх ба . . . сүнслэг байдал сулрах аюулаас зайлсхийх нь

Сиро Виллавиценцио Перугийн Суско нутагт жуулчны хөтчөөр ажилласан эхний гурван жилд инкчүүдийн “хаягдсан хот” хэмээн нэрд гарсан Мачю Пикчю уруу бараг 400 жуулчныг аваачсан ажээ. Тэрээр олон удаа энд ирснээс хойш ч, энэ газарт дэлхийн олон янзын гайхамшиг байгаа бөгөөд түүний хувьд энэ газар гайхамшгаа алдаагүй ажээ.

“Энд мэдвэл зохих ямар нэг зүйл үргэлж байдаг” гэж тэр хэллээ. Хэсэг жуулчдыг Мачю Пикчюгаар аялуулахад хэдэн цаг зарцуулах нь Сиругийн хувьд ердийн зүйл юм. Гэвч тэрхүү гайхамшигийг алдах нь хэчнээн амархан болохыг тэр харсан ажээ. Түүний зарим хамтран ажиллагчид нэг бүлгийн аяллыг ердөө 45 минутад амжуулдаг гэнэ. “Тэд энэ газрыг сонирхохоо больсон юм” гэж тэр хэллээ.

Часкви тойргийн гишүүн, Перугийн Куско Интай Рейми гадасны

дээд зөвлөлийн гишүүн Сиро хамтран ажиллагчдынх нь сонирхлыг татахаа больсон зүйлийг ойлгох нь дэлхийн өөр нэг гайхамшиг—хамгийн чухал гайхамшиг “ер бусын ажил мөн гайхамшиг” (2 Нифай 25:17) болсон Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг сонирхох сонирхлоо дээшлүүлэхэд нь Сүмийн гишүүдэд тусалж болох юм гэдэгт итгэдэг ажээ.

Гайхамшиг алга болох аюул

Инкчүүд 1500-гаад оны сүүлчээр хаягдсан бөгөөд түрэмгийлэн эзлэгчдийн илрүүлгээгүй, Перугийн Андын өндөр уулан дахь алслагдсан бөглүү энэ хот хэдхэн хүнийг эс тооцвол бусад бүх хүмүүсийн хувьд хаягдсан аж. 20-р зууны эхээр гадаад ертөнц энэ хотыг нээснээр судлаачид, жуулчдын цуваа тасрахаа больжээ.

Хэдэн арван жил судалсны дараа “зарим хүмүүс Мачю Пикчюд

ТЭМДЭГЛЭСНЭЭС БУСАД НЬ АДАМ К.ӨҮЛСОНЫ ГЭРЭЛ ЗУРГУУД



*Судлаачид Мачю,
Пикчюг урт
удаан хугацаанд
судалсан юм.
Шинэ нээлтүүд
болон шинэ
мэдлэг нь тэдэнд
урам, эрч хүч
хайрласан ажээ.*

нэвэл зохих бүх зүйл нь олдсон гэж боддог юм. Бүх юм олдсон эсвээс бүх зүйл хийгдсэн хэмээн боддог хүмүүс уг юм буюу хүч чармайлыг үл хайхардаг эсвэл дутуу үнэлдэг” гэж Сиро хэллээ.

Яг үүнтэй адил явдал Сүмд тохиолдож мэднэ гэхээс Сирогийн санаа зовдог гэнэ. Сүмд олон жил болсон хийгээд мэдэмхийрэх нь зарим гишүүдийг “тэнгэрээс ирэх аливаа тэмдэг эсвээс гайхамшигт улам багаар цочирдон гайхах болж эхлэхэд, үүний хэрээр тэд зүрх сэтгэлдээ хатуу мөн оюун санаандаа харалган болж эхлэхэд, мөн тэд сонссон мөн харсан бүхэндээ итгэхгүй болоход” (3 Нифай 2:1) хүргэж мэдэхийг тэрээр харсан ажээ.

Ийнхүү гайхамшигт хайхрамжгүй хандах нь: Чи энэ үг хэлэгчийг сонсох хэрэггүй. Үүнийг чи аль хэдийн мэднэ шүү дээ. Ням гарагийн хичээлд яваад яах юм. Тэр хичээлийг чи өмнө нь сонссон шүү дээ. Өнөөдөр судар судлах хэрэггүй ээ. Сударт шинэ юм гэж юу ч байхгүй гэх зэрэг Сатаны худал хуурмаг үгс гишүүдийг төөрөгдүүлж мэднэ.

“Мөн хүмүүсийн зүрх сэтгэлийг Сатан тийн эзэмш[дэг]” (3 Нифай 2:2).

Сайн мэдээнээс суралцах урам зоригт өгсөх, уруудах нь хэвийн зүйл юм. Гэвч

сүнслэг байдлаа өсгөн нэмэгдүүлэхэд тоомсоргүй ханддаг хүмүүс эцэстээ “тэдэнд байгаа[гаа] ч” алдах аюултай юм (2 Нифай 28:30; мөн Матай 25:14–30-ийг үз).

Гайхамшигийг сэргээх нь

Дараах гурван үнэнийг ойлгосон нь хүмүүс үнэт зүйлст хайхрамжгүй хандаж байгаа үед бодол суурьтай хэвээр үлдэхэд Сирод тусалсан ажээ:

1. Мэдэх хэрэгтэй зүйлс надад их байна.

Сиро номлолынхоо үеэр сайн мэдээг эрчимтэй судалдаг байсан ба институтийн багшийн хувьд шинэ зарчим байна уу эсвэл мэддэг зарчим байна уу хамаагүй сүрч мэдэх зүйл өөрт нь ямагт мундахгүй олон байдгийг мэдсэн ажээ. Сүнсний шинэ мэдлэг гэдэг нь тулгарсан буюу тулгарах аливаа сорилт бэрхшээлээр дамжуулан өөртөө хэрэгтэй ямар нэг зүйлийг мэдэж авах явдал байдаг.

“Бодол суурьтай байхын нэг хэсэг нь миний мэдэхгүй юм их байгаа, эдгээр зүйлсийг мэдэх нь надад хэрэгтэй гэдгийг үргэлж санаж байх явдал мөн” гэж тэр ярилаа.

2. Өөртөө хэрэгтэй байгаа зүйлийг мэдэхэд Ариун Сүнсний тусламж хэрэгтэй.

Мэдэх хэрэгтэй зүйлээ мэдэхгүй байгаа бол танд энэ зүйлийг мэддэг багш хэрэгтэй (Иохан 14:26-г үз). Сиро аль нэг шүлгийг хэчнээн удаа уншсан эсвэл аль нэг үзэл баримтлалыг хэчнээн удаа сонссон нь хамаагүй судруудыг ганцаараа болон эхнэртэйгээ хамт судалж, хичээл, цуглаануудад байнга оролцох ёстой гэдгийг үргэлж санаж явдаг ажээ.

“Огт санаагүй зүйлсийг Сүнс надад зааж болно. Ариун Сүнс бол багш мөн” гэж тэр хэлэв.

3. Суралцах нь надаас хүч чармайлт шаардана.

Суралцах нь идэвхгүй үлбэгэр биш харин идэвхтэй үйл явц мөн.¹ Суралцах нь хүсэл эрмэлзэл, анхаарлаа төвлөрүүлэх, идэвхтэй оролцох, сүрч мэдсэн зарчмуудаа амьдралд хэрэгжүүлэхийг шаарддаг (Алма 32:27-г үз).

“Суралцахын тулд хариуцлага хүлээх ёстой. Тэнгэрлэг Эцэг ямар нэг юмыг сурах ёстой гэж намайг албаддаггүй” гэж Сиро хэллээ.

Урам хайрласан гайхамшиг

Сирогийн хувьд Мачю Пикчю бол дэлхийн гайхамшиг юм. Учир нь судлаачид энэ хотыг урт удаан хугацаанд судалсан юм. Шинэ нээлтүүд болон шинэ мэдлэг нь тэдэнд урам, эрч хүч хайрласан ажээ.

Археологчид бүтэн зууны туршид судалсны дараа хэдхэн жилийн өмнө оршуулгын газар, вааран эдлэл, тэр ч байтугай эгнээ олон барилга байгууламж олсон нь энэ бүгд Мачю Пикчю болон инкчүүдийн тухай мэдэгдээд байсан зүйл дээр нэмэгдсэн ажээ.

Есүс Христийн сайн мэдээг судлах нь ч үүн лүгээ адил юм. “Сайн мэдээг судлахад хүч чармайлт гаргадаг хүмүүс ямар нэг шинэ зүйлийг үргэлж олж мэддэг” гэж Сиро ярилаа.


Мачю Пикчюгийн талаар шинээр олж мэдсэн зүйлс хуучин мэдлэг дээр тулгуурладаг шиг судлаачдад “зүрх сэтгэлээ хатууруулахгүй түүнд тэдгээрийг бүрэн дүүрэн мэдэх хүртэл нь Бурханы нууцуудыг түүнд мэдүүлэх хүртэл үгийн илүү их хэсэг өгөгд [сөн]” (Алма 12:10; мөн С ба Г 50:24-ийг үз) ажээ.

“Сайн мэдээ бол бид тогтмол эргэж очиж байх ёстой амийн усны шавхагдашгүй оргилуур мөн” гэж Сиро хэллээ.

Гайхамшгийн гайхалтай ажил

Уулын хяр дээрээс Макчю Пикчюг харахад эртний барилга байгууламжуудын дотуур яваа жуулчдын өөр өөр бүлгүүд Сирод харагдана. Цөөхөн ч гэсэн зарим хамтран ажиллагчдынх нь сонирхол буурч үгүй болсон нь зөвхөн тэдэнд өөрсдөд нь төдийгүй, бас тэднээр дамжуулан гайхамшгийг мэдэрч болох хүмүүст хор уршигтайд Сиро харамсдаг ажээ.

Сайн мэдээний гайхамшгаас салахгүй байх нь хувь хүнийг төдийгүй, түүнтэй холбоотой байдаг хүмүүсийг мөн адислах болно. “Хүмүүсийн амьдралд сайн мэдээний гаргадаг өөрчлөлт бол гайхамшиг мөн. Тэрхүү өөрчлөлтийг биеэр амссан хүмүүс



бусдын амьдралд гайхамшиг болж чадна” гэж Сиро ярилаа. ■

ЭШЛЭЛ

1. Давид А.Беднар, “Seek Learning by Faith,” *Лиакхона*, 2007 оны 9-р сар, 16-г үз.



Судруудыг унших хүсэл эрмэлзэлтэй болох нь

Вилфер Монтес Леон

Бид судруудыг унших оргилуун хүсэл тэмүүлэлтэй болохын төлөө, Ариун Сүнсний удирдамж хүлээн авахын төлөө залбирах хэрэгтэй. Бид судруудаас эсвэл Бурханы үгээс баяр баясал олдог, үүгээр бидэнд өгч буй захиасын агуулсан хайрыг мэдэрдэг байх хэрэгтэй. Бид энэхүү гайхамшигт сайн мэдээнд шимтэн дурлах ёстой учраас судруудыг зүгээр гүйлгэн уншаад өнгөрөх ёсгүй, харин илүү ихийг хийх хэрэгтэй.

Та судруудыг судлах бүрд илүү ихийг мэдэх бөгөөд судруудаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгийнхээ хүслийг мэдэж чадна. Тэрбээр Сүмийн жишиг бүтээлүүдээр дамжуулан бидний залбиралд олонтоо хариулдаг. Бид амар амгаланг мэдэрч, сүнслэг санаа бодол төрсөн үед тэдгээр нь Ариун Сүнсээр дамжин Тэнгэрлэг Эцэгээс ирдгийг мэдэж чадна (С ба Г 8:1-3).



Ахлагч Д.Тодд
Кристофферсон

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын



Өдөр бүр авдаг адислалууддаа Бурханы МУТРЫГ

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХҮЙ

*Өдөр тумынхаа талхыг Бурханы мутраас гуйж, хүлээн авах нь
Түүнд итгээж сурах болон амьдралд тохиолддог сорилт бэрхшээ-
лүүдийг тэсч даван туулахад амин чухал юм.*

Их Эзэний шавь нарын нэг нь Түүнээс, “Эзэн, Иохан шавь нар-таа хэрхэн залбирахыг заасан шиг бидэнд зааж өгөөч” (Лук 11:1) гэж асуус-ныг Лук өөрийн цэдэгт тэмдэглэсэн бай-даг. Тэгэхэд нь Есүс Их Эзэний Залбирал хэмээн нэрлэгдсэн залбирлын загварыг өгсөн ажээ (Лук 11:2–4-ийг үз; мөн Матай 6:9–13-ийг үз).

Их Эзэний Залбиралд “Өдөр тутмын минь талхыг энэ өдөр бидэнд өгөөч” (Ма-тай 6:11; мөн Лук 11:3-ыг үз) гэсэн гуйлт байдаг. Тэнгэрлэг Эцэгтээ өдөр бүр хандан гуйдаг хэрэгцээ бид бүгдэд байдаг. Зарим хүмүүсийн хувьд талх гэсэн үг тухайн өдөр амь зуулгыг нь хангах хоол хүнс гэсэн шууд утгаараа хэрэглэгддэг. Бас архаг өвчтэй эсвэл өвчин нь удаан хутацаанд илааршдаг хүмүүст сүнсний болон бие бялдын хүч тэнхээг гуйж болно. Бусад тохиолдлуудад гуйлт нь хэн нэгний тухайн өдрийн ажил төрөлтэй холбоотой зүйлс, жишээ

нь хичээл заах, шалгалт өгөх зэрэг тулгамд-сан хэрэгцээ байж болно.

Бид тухайн өдөр шаардлагатай тус-ламж, хоол хүнс буюу өдөр тутмын талх-ныхаа төлөө Бурханд найдлага тавьдаг байх ёстойг Есүс бидэнд бас шавь нартаа сургасан билээ. Өдөр тутмын талхаа Тэнгэрлэг Эцэгийнхээ мутраас гуйх Их Эзэний урилга нь хүүхдүүдийнхээ өдөр тутмын өчүүхэн хэрэгцээг ч сайн мэддэг бөгөөд тэдэнд нэг бүрчлэн туслах энгүй их хүсэлтэй хайраар бялхам Бурханд ойртох уриалга юм. “Бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч” Түүнээс бид итгэ-лээр гуйвал “түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5) гэж Тэрбээр хэлсэн юм. Энэ нь мэ-дээжийн хэрэг, үлэмж итгэл төрүүлэхүйц хэдий ч, өдөр бүр юм хүлээн авахаас илүү чухал зүйл энд байдаг. Өдөр тутмынхаа талхыг гуйж авснаар Бурхан болон Түүний Хүүд итгэх бидний итгэл өсөн хөгждөг билээ.

*Бид тухайн өдөр
шаардлагатай
тусламж, хоол
хүнс буюу өдөр
тутмын талх-
ныхаа төлөө
Бурханд найдлага
тавьдаг байх ёс-
тойг Есүс бидэнд
бас Өөрийн шавь
нарт сургасан
билээ.*

Бурханд өдөр бүр найдлага тавих нь

Израилын овгууд Египетээс ялгууснаар гарч явсны дараа амлагдсан нутагт орохоосоо өмнө 40 жил цөлд бэдэрсэн юм. Сая гаруй хүнтэй дүрвэгчдийн энэ асар том бүлгийг тэжээх хэрэгтэй байлаа. Нэг дор тийм олон хүн ангийн махаар удаан хугацаанд амь зуух аргагүйгээс гадна тэд хагас нүүдлийн байдлаар амьдарч байсан болохоор тариа тарьж ургац хураан авах буюу мал аж ахуй эрхлэх боломжгүй байв. Иехова тэдний өдөр тутмын талх—маннаг тэнгэрээс илгээж, тулгарсан бэрхшээлийг гайхамшигтайгаар шийдсэн билээ. Их Эзэн Мосегоор дамжуулан маннаг өдөр бүр тухайн өдөрт хүрэлцэх хэмжээтэйг, харин Хүндэтгэлийн өдрийн өмнөх өдөр хоёр хоногт хүрэх хэмжээгээр хурааж байхыг хүмүүст зааварласан ажээ.

Зарим хүмүүс Мосегийн зааврыг эс хайхран нэг өдөрт хүрэхээс илүүг хурааж үлдсэнийг нь нөөцлөхийг хичээжээ.

“Мосе тэдэнд, нэг ч хүн үүнийг өглөө үлдээж болохгүй гэж хэлсэн.

Гэвч тэд Мосег сонссонгүй. Зарим нь үүнээс хэсгийг өглөө хүртэл хадгалсанд тэр нь өтөөр дүүрч өмхийрсөн” (Египетээс Гарсан нь 16:19–20).

Харин тэд зааврын дагуу зургаа дахь өдөр маннаг хоёр өдөр хүрэлцэх хэмжээгээр хураасанд тэр нь өмхийрсөнгүй (Египетээс Гарсан нь 16:24–26-ийг үз). Гэтэл зарим хүмүүс нүдээр үзэхгүйгээр итгэсэнгүй, дахиад Хүндэтгэлийн өдөр маннаг түүхээр явсан ч “тэд юу ч олсонгүй” (Египетээс Гарсан нь 16:27–29-ийг үз).

Иехова нэг өдрийн амь зуулгыг нэг удаа хангаснаар 400 гаруй жилийн хугацаанд өвөг дээдсийнхээ итгэлийг үлэмж хэмжээгээр мартсан үндэстэнд итгэлийг заахыг хичээсэн ажээ. Тэрбээр Өөртөө итгэхийг тэдэнд зааж байв. Чухамдаа, Израилын хүүхдүүд өдөр бүр Түүнтэй хамт амьдарч,

маргааш нь, тэгээд *дараагийн* өдөр нь Тэр хангалттай хоол хүнс өгөх болно гэдэгт итгэх хэрэгтэй байлаа. Ингэснээрээ Тэрбээр тэдний оюун санаа, зүрх сэтгэлээс хол хөндий байх аргагүй байв.

Израилын овгууд цаг нь ирсэн үед өөрсдийгөө хангах шаардлагатай болсон юм. Үүн лүгээ адил бид өдөр тутмын талхаа олж чадахгүй эсвэл тухайн үед өөрийгөө тэтгэж чадахгүй болсон үед Бурханаас гуйдаг ч гэсэн, амьдралаа авч явахын тулд чадах бүхнээ хийх ёстой.

Их Эзэнд итгэхүй

Би хэдэн жилийн өмнө Ерөнхий эрх мэдэлтнээр дуудагдсан үедээ хэдэн жил надад төвөг удсан эдийн засгийн асуудалтай тулгарав. Уг асуудал ноцтой биш, яаралтай шийдэх шаардлагагүй байсан ч бүрмөсөн шийдэгдээгүй байлаа. Зарим үед энэ сорилт манай гэр бүлийн сайн сайхан байдалд заналхийлж байсан болохоор бид санхүүгийн хувьд дампуурч мэдэх нь гэж боддог байлаа. Тэгээд хөндлөнгийн гайхамшигтай оролцооны төлөө залбирав. Би уг залбирлыг олон удаа зүрх сэтгэлийнхээ чин хүслээр хэлдэг байсан ч хариу ерөөсөө ирсэнгүй. Тэгээд эцэст нь, “Гэвч миний хүсэл бус харин Таны хүсэл биелэгдэг” (Лук 22:42) хэмээн залбирсан Аврагч шиг залбирч сурсан юм. Эцсийн шийдэлд хүрэх замын дагуу жижигхэн алхам хийх бүрдээ Их Эзэний тусламжийг эрэлхийлж байлаа.

Бий болсон ярвигтай асуудлыг нэг тийш болгохын тулд явах газар ч үгүй, хандах хүн ч үгүй болоод байсан үед би бүх нөөц боломжоо шавхаж дуусаад байлаа. Өөр ямар ч боломжгүй болсон учир би нулимс урсган Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө Түүний тусламжийг гуйн нэг бус удаа өвдөг сөгдөн залбирав. Тэр үнэхээр тусалсан шүү. Заримдаа зүгээр л амар амгалангийн мэдрэмж, бүх зүйл сайн болно гэсэн мэдрэмж төрдөг байлаа. Тэрбээр ямар арга замаар хэрхэн туслахыг би мэдэхгүй байсан ч Их Эзэн шууд буюу шууд бусаар замыг нээх болно гэдгийг

надад мэдүүлсэн юм. Нөхцөл байдал өөрчлөгдөж болно, ашигтай, шинэ санаа толгойд орж ирж болно, санаандгүй ямар нэг орлого юм уу нөөц боломж яг зөв цагт гарч ирж мэднэ. Тэгсээр яаж ийж байгаад асуудлыг шийдсэн юм.

Зовж шаналж байсан, тулгарсан асуудал тэр дороо түргэн шийдэгдээгүйд одоо би баярладаг. Бурханд хандан хэдэн жил бараг өдөр бүр тусламж гуйдаг байсан нь хэрхэн чин сэтгэлээсээ залбирч, залбирлынхаа хариут хэрхэн авдгийг, мөн Бурханд итгэлтэй байх практик арга замыг надад заасан юм. Аврагч, Тэнгэрлэг Эцэг хоёр, өөр ямар нэг байдлаар, ямар нэг арга замаар тохиох боломжгүй зүйлийг тохиолгон, надад урт удаан хугацаанд анхаарал халамж тавьж болно гэдгийг би мэдсэн билээ. Өдөр тутмын талх бол үнэт эрдэнэ гэдгийг би мэднэ. Өнөөдөр манна Библийн

түүхэнд манна бодитой байсан дугаа адил бодитойг би мэдсэн. Их Эзэнд бүх зүрх сэтгэлээрээ итгэхийг би сурсан. Өдөр бүр Түүнтэй хамт алхахыг би сурсан.

Асуудлаар дамжуулан ажиллах нь

Бурханаас долоо хоногийн, сарын эсвэл жилийнхээ талхыг гуйхын оронд өдөр тутмынхаа талхыг гуйх нь бидний хувьд шийдвэрлэж болохуйц, жижиг асуудлуудад анхаарлаа төвлөрүүлэх нэг арга зам мөн. Бид ямар нэг том асуудлыг шийдэхийн тулд үүнийг олон хэсэг болгон, өдөр бүр

Иехова нэг өдрийн амь зуулгыг нэг удаа хангаснаар 400 гаруй жилийн хугацаанд өвөг дээдсийнхээ итгэлийг үлэмж хэмжээгээр мартсан үндэстэнд итгэлийг заахыг хичээсэн ажээ. Тэрбээр тэдэнд Өөртөө итгэхийг заадаг байв.



нэг бага хэсэг дээр ажиллах хэрэгтэй. Зарим үед бидний нэг өдөрт шийдэж чадах зүйл нь тухайн өдөр нэг удаа л хийх зүйл байдаг.

1950-иад оны үед манай ээж хавдрын хүнд мэс засал хийлгэсний дараа цацраг туяаны цуврал эмчилгээ хийлгэсэн юм. Тэр үед эмээгийн түүнд зааж сургасан нэг зүйл ээжид минь тэр цагаас хойш тусалсаар байгааг ээж маань дурсан ярьдаг байлаа.

“Бүх бие шархиран өвдөж, ядарч туйлдсан нэг өдөр би, “Ээж минь ээ, би дахиад цацраг туяаны 16 эмчилгээ хийлгэж давахгүй юм байна” гэлээ.

“Чи өнөөдөр явж чадах уу? гэж түүнийг асуухад,

“Чадна аа гэв.

Ямар хүмүүс болоход туслах тэнгэрийн талх бас бидэнд хэрэгтэй. Наманчилж, төгөлдөржин, эцэстээ “Христийн дүүрэн байдлын чанарын хэмжээнд” хүрэх нь алхам алхмаар хэрэгжих үйл явц юм.


“Сайн байна, охин минь. Өнөөдөрийн хувьд ингээд л болоо.

“Нэг өдөр нэг зүйлийг зөвхөн нэг л удаа хийдэг байсан нь надад олон удаа тусалсныг би санадаг.”

Бид урагшаа харж, нэг өдөр нэг л зүйлийг нэг удаа хийсэн үед, Сүнс биднийг удирдах болно.

Чадавхиа бүрэн ашиглах нь

Өдөр тумынхаа талхыг Бурханы мутраас гуйж, хүлээн авах нь Түүнд итгэж сурах болон амьдралд тохиолддог сорилт бэрхшээлүүдийг тэсч даван туулахад амин чухал юм. Ямар хүмүүс болоход маань туслах тэнгэрийн талх бас бидэнд хэрэгтэй. Наманчилж, төгөлдөржин, эцэстээ “Христийн дүүрэн байдлын чанарын хэмжээнд” (Ефес 4:13) хүрэх нь алхам алхмаар



хэрэгжих үйл явц юм. Шинэ бөгөөд эрүүл саруул дадал зуршлыг зан байдалдаа төлөвшүүлж, муу зуршил буюу донтолтыг даван туулах нь олон өдөр, сар, бүр олон жил үргэлжилж болох, өдөр тутмын, өөрөөр хэлбэл, өнөөдрөөс маргааш, маргаашаас нөгөөдөр тасралтгүй үргэлжлэх хүч чармайлт байх нь олонтоо тохиолддог. Гэвч бид өдөр тутмын талхаа Бурханаас гүйж болно. Учир нь бидэнд тусламж өдөр бүр хэрэгтэй.

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх асан Ерөнхийлөгч Н.Элдон Таннер (1898–1982) хэлсэн нь: “Аливаа асуудлыг нааштайгаар шийдвэрлэхийн үнэ цэнийг тунгаан бодоод шийдлийг анхааралтай сонгож авахад өөрийгөө сахилгажуулах, шийдлийн зорилгыг тодорхойлон, хэрэгжүүлэхэд ямагт тууштай байж, биднийг зогсоох боломжийг аливаа саад бэрхшээлд олгохгүй байцгаая. Тухайн өдөр нэг л шийдлийг хэрэгжүүлэх ёстойг өглөө бүр өөртөө сануулж байцгаая.”¹

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар, гэр бүлийн залбирал, судар судлах, гэр бүлийн үдэш зэрэг өдөр тутмын энгийн үйл ажиллагаануудыг байнга хийдэг байх нь бат бөх гэр бүлүүдийг төлөвшүүлэхэд амин чухал юм гэж саяхан сургажээ. “Өчүүхэн жижиг мэт санагдах зүйлсийг байнга хийж байх нь сүнслэг байдлын чухал үр дүнд хүргэж чадна” хэмээн тэрбээр хэлжээ.²

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994) наманчлалын тухай дараах зөвлөгөөг өгсөн юм: “Бид [Христтэй] улам адилхан болохыг эрэлхийлэхдээ анхааралтай байх ёстой. Ийм болж чадахгүй юм байна хэмээн санаагаар унаж, найдвараа алдаж болохгүй. Христтэй адилхан болох нь насан туршийн зорилго бөгөөд өсөлт олонтоо гарах ч өөрчлөлт нь удаан, бараг боломжгүй юм шиг санагддаг.”³

Үйлчлэлд Их Эзэний тусламжийг эрэлхийлэх нь

Бид тэнгэрийн талхны өдөр тутмын хувийг гуйхдаа зөвхөн амин хувиа хичээх

ёсгүйг санагтун. Хэрэв бид, “үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд” (Марк 10:45) хүрч ирсэн Их Эзэнтэй илүү адилхан болохыг үнэхээр хүсдэг бол, бусдын төлөөх үйлчлэлдээ Түүний тусламжийг өдөр бүр эрэлхийлэх ёстой.

Ерөнхийлөгч Томас С.Монсон миний мэдэх хэнээс ч илүүтээр энэ зарчмаар амьдардаг хүн. Эргэн тойрныхоо хүмүүст аль ч өдөр эсвээс тэр өдрийн аль ч агшинд туслахын тулд Бурханы илчлэх хэрэгцээ ба арга хэрэгслийн төлөөх залбирал түүний зүрх сэтгэлд ямагт бэлэн байдаг юм. Түүнийг бишоп байх үеийн ганцхан жишээ нь, зарим үед багаахан хүч чармайлт ч гэсэн Сүнсний үйл хэрэг байж, гайхалтай үр дүнд хүрдгийг харуулсан ажээ.

“Түүний [Ерөнхийлөгч Монсон] гараа сунган тусалсан хүн бол Харольд Галлачер байлаа. Эхнэр, хүүхдүүд нь Сүмд идэвхтэй байсан атал тэр өөрө идэвхгүй байв. Харольдын охин Шарон аавыгаа дахин идэвхтэй болгохын тулд ‘ямар нэг юм’ хийгээч гэж Бишоп Монсонгоос гуйжээ. Бишопын хувьд түүнийг нэг өдөр Харольдын оч гэж сүнс өдөөсөн гэнэ. Зуны нэгэн халуун өдөр тэр Харольдын шилэн хаалгыг тогшжээ. Харольд сандал дээрээ суугаад, тамхи татаж, сонин уншиж байгаа нь бишопт харагдсан гэнэ. Харольд дээшээ харалгүй, ‘Хэн бэ?’ гэж дорой дуугаар асуухад,

“Бишоп чинь байна” гэж Том хариулжээ. ‘Би тантай танилцаж, гэр бүлийнхээ хамт цуглаанууддаа оролцож байгаач гэж гуйх гэж ирлээ.’

“‘Үгүй ээ, би толгой өндийлгөх завгүй байна’ гэж үл тоомсорлосон байдалтай хариулаад, ядахдаа дээшээ ч харсангүй. Үгийг нь сонссонд Том талархал илэрхийлээд босгон дээрээс буцав. Харольд цуглаануудад огт оролцолгүй байсаар тэднийх өөр газар шилжсэн аж.

Хэрэв бид, “үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд” хүрч ирсэн Их Эзэнтэй илүү адилхан болохыг үнэхээр хүсдэг бол, бусдын төлөөх үйлчлэлдээ Түүний тусламжийг өдөр бүр эрэлхийлэх ёстой.

“Олон жилийн дараа . . . Галлачер ах Ахлагч Томас С.Монсонгийн оффис уруу утасдаж, түүнтэй улзах цаг товлож өгнө үү гэж хүсчээ.

“. . . Хэсэг хугацаа өнгөрсний дараа тэр хоёр тэврэлдэн уулзсан гэнэ. ‘Олон жилийн тэртээ тэр нэгэн зун таныг гэртээ оруулалгүй, сандлаасаа ч босоогүйн төлөө би уучлал гуйхаар ирлээ’ гэж Харольдыг хэлэхэд Ахлагч Монсон түүнийг Сүмд идэвхтэй байсан уу гэж асуужээ. Харольд егөөтэй инээмсэглээд: ‘Одоо би тойргийнхоо бишопын зөвлөлийн хоёрдугаар зөвлөх. Сүмдээ яваач гэсэн таны урилга, үгүй гэсэн миний хариулт намайг ихэд шаналгаж тэгээд энэ талаар ямар нэг юм хийе гэж шийдсэн юм гэж хариулжээ.’”⁴


Өдөр бүр сонголт хийх нь

Өдөр тутмын талхныхаа тухай бодсоноор бид амьралынхаа нарийн ширийн зүйлсийн тухай, өдөр бүр болдог энгийн жижиг юмсын талаар сайн мэдлэгтэй болдог. Жишээ нь, гэрлэлтэд, нинжин сэтгэл, бие биедээ туслах, хайраа үргэлж халуунаар нь байлгахын төлөө анхаарах явдал, энгийн харьцаа нь хааяа нэг тохиох сэтгэлийн хөөрөл, үнэтэй бэлэг сэлтээр тодорхойлогдох биш харин байнгын үйл явц байх ёстойг амьдралын туршлага харуулж байна.

Үүн лүгээ адил, бид өдөр тутмын сонголтоороо өөрсдийн амьдралд болон ямар

“Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна.

Хэрэв хэн нэгэн нь энэ талхнаас идвэл, тэр мөнхөд амьдарна. Ертөнцийн амийн төлөө Миний өгөх талх бол Миний махан бие юм.”



хүмүүс болоход маань нөлөөлж мэдэх сэм шургалагч далдын нөлөөнөөс урьдчилан сэргийлж болно. Ахлагч Нийл А.Максвелл (1926–2004) бид хоёрын хооронд хэдэн жилийн өмнө болсон албан бус нэгэн ярианд, хэрэв хүн зөв сонголтууд хийх юм бол порнограф болон порнографын дүрслэлүүдээс зайлсхийж чадна гэсэн дүгнэлтийг бид хийсэн юм. Энэ нь чухамдаа, биет болон электрон хэлбэрээр порнографыг үзэж болох газар уруу явахгүй байх нь хувь хүний сахилгын асуудал юм. Гэсэн ч, порнограф нь эмгэнэлт уршигтай учраас хүний ажил хэрэг хэвийн байлаа ч оюун санаанд нь хортойгоор нөлөөлдөг. “Тийм ээ. Харин хүн үүнээс тэр даруйд татгалзаж чадна шүү дээ. Хүн порнографт гэртээ морилон, хоймортоо тухлан суух боломж олгох ёсгүй” хэмээн Ахлагч Максвелл хэлж билээ.

Хор хөнөөлтэй бусад нөлөө, зуршлуудын хувьд ч мөн л ийм юм. Хортой нөлөө, муу зуршлуудаас дөнгөж эхэлж байхад нь зайлсхийх нь сонор сэрэмжгүй байснаас нүгэл хилэнц, сул дорой байдал бидний бодгальд нэгэнт соёолсныг хожмын нэг өдөр мэдэж харамсахаас биднийг хамгаалж чадна.

Амьдрал дээр, огт учир холбогдолгүй олон зүйл ганцхан өдөр болдоггүй. Өдөр бүр давтагдааг энгийн үйл ажиллагаанууд өчүүхэн жижиг байж болох ч бидний төлөвлөгөө, хүсэл мөрөөдөл биелэхэд хэрэгтэй сахилга бат болон зан чанарыг төлөвшүүлэхэд барилга барихад тоосго хэрэгтэйн адил чухал юм. Тиймээс, та өдөр тутмын талхаа гуйж залбирахдаа өөрийн тулгамдсан хэрэгцээ болон өөрийгөө юунаас хамгаалах хэрэгтэй байгааг буурь суурьтай бодож байхад анхаар. Унтахаар орондоо орохдоо, тухайн өдөр ямар амжилт олсон, ямар ажил бүтээгүйг болон маргааш нь бага ч болов хэрхэн илүү сайн ажиллах талаар бодож бай. Таныг тухайн өдрийн турш дэмжин тэтгэх маннаг Тэнгэрлэг Эцэг замын чинь дагуу байрлуулсанд таларх. Зарим зүйлийг тэсэн өнгөрүүлж, заримыг нь өөрчлөхөд Түүний

мутар өөрт чинь тусалж байгааг та хараад Түүнд итгэх итгэл чинь өсөн нэмэгдэхийг харах болно. Дахиад нэг өдөр ард өнгөрч, мөнх амьдрал өөд дахиад нэг алхам хийсэндээ та баярлах болно.

Амийн талхнаас хуваалцахыг сана

Юуны өмнө Түүний манна бол Гэтэлгэгчийн хэв шинж, бэлгэдэл байсан гэдгийг санагтун

“Би бол амийн талх байна.

Та нарын өвөг дээдэс цөлд маннаг идсэн бөгөөд тэд нас барцгаасан.

Энэ нь тэнгэрээс бууж ирэх талх бөгөөд үүнээс идэгч нь үхэхгүй.

Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн нь энэ талхнаас идвэл, тэр мөнхөд амьдарна. Ертөнцийн амийн төлөө Миний өгөх талх бол Миний махан бие юм” (Иохан 6:48–51).

Амийн Талх, Есүс Христ амьд гэдгийг, Түүний Цагаатгал үнэн бодитой, хүч нь хязгааргүй гэдгийг би гэрчилж байна. Эцсийн эцэст, Түүний Цагаатгал, Түүний ач ивээл бол бидний өдөр тутмын талх юм. Тэрбээр Эцэгтэйгээ нэг байдгийн адилаар бид Түүнтэй нэг байхын тулд бид өдөр бүр Түүнийг эрэлхийлж, өдөр болгон Түүний хүслийг биелүүлдэг байх ёстой (Иохан 17:20–23-ыг үз). Бидний ингэсэн тохиолдолд Тэнгэрлэг Эцэг биднийг өдөр тутмын талхаар хангах болтугай. ■


2011 оны 1-р сарын 9-нд Сүмийн Боловсролын Системийн галын дэргэдэх ярилцлага дээр хэлсэн үгнээс. Англи хэл дээрх бүрэн эхийг <http://speeches.byu.edu-оос> үз.

ЭШЛЭЛ

1. Н. Елдон Таннер, “Today I Will . . .”, *Лиакхона*, 2003 оны 3-р сар, 27–28.
2. Давид А.Беднар, “More Diligent and Concerned at Home”, *Лиакхона*, 2009 оны 11-р сар, 20.
3. Эзра Тафт Бенсон, “A Mighty Change of Heart,” *Tambuli*, 1990 ны 3-р сар, 7.
4. Хейди С.Свинтон, *To the Rescue: The Biography of Thomas S. Monson* (2010), 160–61.

*Эцсийн эцэст,
Аврагчийн Ца-
гаатгал болон
Түүний ач ивээл
бол бидний өдөр
тутмын талх
юм.*





ТЭРБЭЭР СУРГАДАГ БАЙСНЬХАА ДАГУУ АМЬДАРДАГ БАЙЛАА

*Ерөнхийлөгч Жорж Альберт Смит сайн мэдээнд зөвхөн
итгэдэг байсан төдийгүй үүгээр амьдардаг байсныг
түүний амьдралын туршилага харуулж байна.*

Тед Барнес

Сургалтын хөтөлбөрийн хэлтэс

Сэтгэл санаанд дарамт учруулсан тэр өдрийн сүүлчээр Жон А.Видцөү “ажлын өдрийнхөө дараа нэлээд ядарчихсан” оффистоо сууж байлаа. Тэрээр ярвигтай асуудалтай тулгарсны сацуу үүрэг хариуцлагынхаа хүндийг мэдэрч байлаа. “Шургаж унатлаа ядарлаа” гэж тэр хэллээ.

“Тэгтэл хаалга тогшиж, Жорж Альберт Смит орж ирлээ. ‘Ажлынхаа дараа гэр уруугаа явж байна гэж тэр хэлэв. Би таны тухай бас таны шийдвэрлэх ёстой асуудлуудын тухай бодож байлаа. Таныг тайтгаруулж, адислахаар хүрч ирлээ’ гэж тэр хэллээ.”


“... Би үүнийг огт мартахгүй. Бид хоёр хэсэг хугацаанд хамт яваад салж, тэр харихаар явлаа. Санаа сэтгэл өөдрөг сайхан байлаа. Ядаргаа бүр арилчихаж.”

Олон жилийн дараа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн болсон Ахлагч

Видцөү (1872–1952) энэхүү болсон явдлыг дурсан санаж өгүүлсэн нь: “Тэрбээр бусдын төлөө... өөрийн цаг зав, хүч чадлыг өгдөг байсан нь түүний төрөлхийн зан юм.”¹

Хэрэв бидэнд Есүс Христийн сайн мэдээний тухай гэрчлэл үнэхээр байдаг бол энэ нь бидний амьдралд тэр тусмаа бие биедээ ханддаг бидний хандлагад харагдах болно гэдэгт 1945–1951 онуудад Сүмийн найм дахь Ерөнхийлөгчөөр үйлчилж байсан Жорж Альберт Смит (1870–1951) итгэдэг байжээ. “Зөв шударга, чигч тууштай амьдрал бол энэ ажлын үнэнийг гэрчлэх боломжийг бидэнд олгох хамгийн хүчтэй гэрчлэл мөн” гэж тэр заажээ.²

Мелкизедек санваартнуудын болон Нийгмийн Халамжийн Бүлгийн 2012 оны сургалтын хөтөлбөр *Teachings of Presidents of the Church: George Albert Smith*-д Ерөнхийлөгч Смитийн гэрчлэл түүний сургаалууд болон амьдралынх нь түүхүүдээр яруу тодоор илэрхийлэгдсэн байгаа. Эдгээр сургаалууд



болон түүхүүдээс зарим жишээг доор харуулав.

Нинжин сэтгэлийн хүч

Зуны нэгэн халуун өдөр хэсэг ажилчид Ерөнхийлөгч Смитийн гэрийн гадаах гудамжинд засварын ажл хийж байв. Ид ажлын үеэр улам халуун болж, ажилчид зохисгүй, бүдүүлэг үгс хэлж эхэлжээ. Удалгүй хөршүүдийн нэг нь хүрч ирэн Жорж Алберт Смит энд ойрхон суудгийг хэлээд ажилчдыг бүдүүлэг үгс хэлснийх нь төлөө зэмлэсэн гэнэ. Ажилчид огт тоосонгүй бүр ч илүү муухай хараа-лын үгс урсгаж эхэлжээ.

Тэр үед Ерөнхийлөгч Смит нимбэгийн ундаа бэлтгэн гал тогооны өрөөндөө байжээ. Тэр нимбэгийн ундаагаа тосгуур дээр хэдэн шилэн аяганы хамт авч гарч ирээд, “Найз нар минь, та нар их халууцаж, ядарсан байна шүү. Та нар наашаа ирж, манай моддын дор сууж, хүйтэн ундаа уугаач” гэжээ.

Ажилчид даруусгагдан, түүний саналыг баяртайгаар хүлээн авсан аж. Аятай сайхан завсарлагааны дараа тэд ажлаа нам гүмхэн, хүндэтгэлтэйгээр дуусгасан гэдэг.³

Энэ мэтийн бусад олон туршлага нь бид “өөрийн асуудлуудыг хүн бүхнийг хайрлаж, тэдэнд нинжин сэтгэлээр хандсанаар шийдвэрлэж” чадна гэсэн Жорж Алберт Смитийн итгэл үнэмшлийг харуулж байна.⁴ “Алдаа гаргадаг хүмүүс байдаг” гэж тэр хэллээ. “Бидний дунд төөрч замаа алдсан хүмүүс бий. Гэвч тэд бол бидний Их Эзэний хүүхдүүд. Тэрээр тэднийг хайрладаг. Тэдэнд хайр, нинжин сэтгэл, тэвчээр, адислах хүслээр хандан, гаргасан алдаагаа ялахад нь туслах эрхийг Тэрбээр та бидэнд олгосон билээ. Бусдыг шүүх нь надад өгөгдсөн эрх биш. . . . Харин, хэрэв тэд буруу зүйл хийж байвал, боломжтой бол тэднийг Селестиел хаант улсад мөнх амьдрах замд нь буцааж оруулахыг ямар нэг арга замаар хичээх нь надад өгөгдсөн онцгой боломж юм.”⁵

“Нинжин сэтгэлээр дамжуулан хөршүүдийнхээ амьдралд баяр баясал, тайтгарал, сэтгэл ханамжийг өгөх нь хэчнээн сайхан билээ. Би энэ үгийг том үсгээр бичин, агаар мандалд бэлгэдэл болгон намирахыг хэчнээн их хүсдэг билээ. Нинжин сэтгэл бол хатуу зүрх сэтгэлийг зөөллөж, зөрүүд бодгалийг зөв замд нь оруулах Бурханаас бидэнд өгсөн хүч юм.”⁶

Сайн мэдээг хуваалцахуй

Ерөнхийлөгч Смит сайн мэдээг хуваалцахыг “оргил нинжин сэтгэл” хэмээн үзсэн байдаг.⁷ Тэрбээр бусад сүмүүдийн сайн талыг хүлээн зөвшөөрч, үүнд баярладаг байсан ч сэргээгдсэн сайн мэдээ бол бусдаас ялгарах өвөрмөц онцлогтой бөгөөд хүн төрөлхтөнд үнэт зүйлсийг санал болгодгийг мэддэг байлаа.

Түүнийг нэгэнтээ номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байхад нь нэг хүн түүнд, “Ингэхэд, танай сүм бусад аль ч сүмийн адил сайн юм гэдгийг би мэдсэн” хэмээн хэлсэн гэдэг. “Тэр хүн биднийг тэнгэрт тулгал магтлаа гэж бодсон байх гэж би бодож байна” гэж Ерөнхийлөгч Смит хэлжээ. “Харин би

түүнд: ‘Хэрэв энд миний төлөөлж байгаа сүм хүмүүний үрсэд бусад аль ч сүмээс илүү чухал биш бол, миний энд ирсэн үүрэг зорилго буруу байгаа хэрэг’ хэмээн хэлж билээ.”⁸

Бидний захиас туйлын чухал байдгийн нэг шалтгаан нь “Хожмын Үеийн Гэгээтнүүд бол сайн мэдээний ёслолуудыг гүйцэтгэхэд Тэнгэрлэг Эцэгээсээ эрх мэдийг авсан цорын ганц хүмүүс мөн гэдэгт байгаа юм. Бид дэлхийд хэрэгтэй хүмүүс” гэж Ерөнхийлөгч Смит сургажээ.⁹

Үүний улмаас, Хожмын Үеийн Гэгээтнүүд “Тэнгэрлэг Эцэгээс бидэнд элбэг дэлбэгээр соёрхсон сайн сайхан зүйлсийг Түүний бүх хүүхдүүдтэй хуваалцах энгүй их, оргилуун хүсэлтэй байхыг” Ерөнхийлөгч Смит хүсэн хүлээдэг байжээ.¹⁰

“Бид [сайн мэдээний] ач холбогдлыг хангалттай мэдэрэхгүйгээс бид үүний шаарддаг оргилуун хүслээр сайн чадахгүй байна гэж би заримдаа боддог.”¹¹

Ерөнхийлөгч Смит сайн мэдээг хуваалцахад “орги-луун хүслийн” үлгэр жишээг харуулдаг байсныг дотны нэг найз нь ажигласан ажээ: “Ерөнхийлөгч Смиттэй нэлээд хэдэн удаа галт тэргээр хамт явах аз жавшаан надад тохиосон юм. Галт тэргэ хөдөлснөөс хойш нэлээд хугацаа өнгөрмөгц тэр цүнхнээсээ сайн мэдээний хэдэн товхимол гаргаж ирээд халаасандаа хийж, зорчигдын дундуур яваад өгдөг байлаа. Тэрбээр нөхөрсөг, хэнтэй ч эв нийцтэй хүн байсан болохоор удалгүй нэг зорчигчтой танилцав. Тэр түүнээс хойш удалгүй Бошиглогч Иосеф Смит Сүмийг хэрхэн үндэслэсэн тухай түүх, Гэгээтнүүд Наувутаас дүрвэсэн болон уудам

хээр талыг туулан Юта уруу хийсэн хүнд хүчир аяны үеэр тэдэнд тохиолдсон гай зовлон, хүнд сорилтуудын тухай шинэ найздаа ярьж, сайн мэдээний зарим зарчмуудыг тайлбарлаж байхыг би сонслоо. Тэрээр аялал дуустал нэг зорчигчийн дараа өөр нэг зорчигчтой дээрх байдлаар яриа хөөрөө өрнүүлдэг байлаа. Ерөнхийлөгч Смиттэй дөчин жил гаруй сайн танил байсны хувьд тэрбээр хаана ч байсан Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн шилдгээс шилдэг, манлай номлогч байсныг би мэднэ.¹²

Хүүхдүүдээ заах нь

Жорж Альберт Смит, түүний эхнэр Люси хоёр “хүүхдүүдээ гэрэл ба үнэнд хүмүүжүүлэх” (С ба Г 93:40) бурханлаг үүрэгтээ туйлын хариуцлагатай ханддаг байжээ. Аав нь нэг удаа хичээл заасан тухай тэдний охин Эдит дараах зүйлийг ярьжээ. Тэр төгөлдөр хуурын хичээлээсээ гэртээ харихаар троллейбусанд суужээ. Кондуктор нь түүнээс мөнгө хураасангүй. “Кондукторыг хажуугаараа өнгөрөхөд би гартаа таван центгийн зоос барьсан хэвээр буух газартаа ирчихсэн байлаа. Ингээд билетийнхээ мөнгийг хэмнэсэндээ их баяртай байлаа.

“... Би аз хийморийнхоо тухай аавдаа ярихаар чухам л хөл газарт хүрэхгүй баярлаж билээ. Аав миний яриаг тэвчээртэй сонсов. Өнөөдөр миний аз шовойсон өдөр байлаа хэмээн би бодож байсныг яана. . . .

Намайг болсон явдлаа ярьж дуустал, ‘Тэвч охин минь, энэ тухай кондуктор мэдээгүй ч гэсэн чи мэдэж байгаа, би мэдлээ, бас Тэнгэрлэг Эцэг мэдэж байгаа шүү дээ. ‘Иймээс, хэрэв чамайг үйлчлүүлснийхээ төлөө мөнгөө бүрэн төлөхийг харвал бид гурав гурвуулаа сэтгэл хангалуун байх болно гэв.’”

Эдит гудамжны булан уруу буцаж очоод мөнгөө төлжээ. “Миний алдааг эелдгээр залруулж өгсөн аавынхаа уужуу тайван ухаанд би их баярласан даа. Учир нь хэрэв аав тэр явдлыг үл ялих зүйл гээд дуугүй өнгөрсөн бол тэр намайг дэмжлээ гэж би бодох байсан биз ээ” гэж тэр хожим нь дурсчээ.¹³



Ерөнхийлөгч Смит, Мормоны Номыг Мейни Төрквойз (зүүн талд), Мануелито Бегай нарт үзүүлж байгаа нь

Хайр нь зөв шударгаар амьдрахад хүүхдүүдэд сүнслэг нөлөө үзүүлэх хүчтэй байдгийг Ерөнхийлөгч Смит Сүмийн гишүүдэд заахдаа: “Хүүхдүүдээ ёс суртахууны хуулийг хэрхэн сахихыг заа. Хүүхдүүд чинь хаана ч байлаа гэсэн нүгэл хилэнц үйлдэх аливаа уруу таталтанд автагдах хүсэлгүй байхын тулд тэднийг хайрын гараараа гэвэр.”¹⁴

Хүүхдүүдээ хамгаалж, хайрлахын зэрэгцээ тэд бидний зөвлөгөөг дуртай сонсдог байхын тулд тэдний хайрыг татахад хангалттай цаг гаргах нь бидний онцгой боломж бас бидний үүрэг гэдгийг би та бүхэнд хэлэх ёстой.¹⁵

Мөнхийн гэр бүлүүд

Жорж Альберт Смит, Люси Смит хоёр гэрлээд 40 орчим жил болоход Люсигийн эрүүл мэнд муудаж, өвчинтэйгөө урт удаан хугацаанд тэмцжээ. Ерөнхийлөгч Смит эхнэрийнхээ эрүүл мэндийн талаар санаа нь зовон, чадлынхаа хэрээр түүнийг тайвшруулах гэж хичээдэг байсан бөгөөд Ерөнхий эрх мэдэлтний үүрэг нь түүнийг гэр орноо орхиж томилолтоор явахыг олонтоо шаарддаг байв. Ерөнхийлөгч Смитийг нэг удаа оршуулга дээр үг хэлсний дараа, түүнийг гэртээ түргэн эргэж ирнэ үү гэсэн зурвасыг хэн нэгэн нь түүнд өгчээ. Тэрээр хожим нь өдрийн тэмдэглэлдээ:

“Би тэр даруй цуглааны байрнаас гарч явсан ч хайрт эхнэр минь намайг гэртээ ирэхээс өмнө сүүлчийн амьсгалаа хураасан

Бидний захиас туйлын чухал байдгийн нэг шалтгаан нь “Хожмын Үеийн Гэгээнтнүүд бол сайн мэдээний ёслолуудыг гүйцэтгэхэд Тэнгэрлэг Эцэгээсээ эрх мэдлийг авсан цорын ганц хүмүүс мөн гэдэгт байгаа учраас Ерөнхийлөгч Смит сайн мэдээг хуваалцахыг “орил нинжин сэтгэл” хэмээн үзсэн байдаг. Бид дэлхийд хэрэгтэй хүмүүс.”

байлаа. Намайг оршуулга дээр үг хэлж байх үед тэр минь өөд болсон ажээ. Чин үнэнч ханиа алдаж уй гашууд автан байлаа би, түүнгүйгээр яана даа би.

Манай гэр бүл үлэмж гашуудсан ч, хэрэв бид итгэлтэй байх юм бол түүнтэйгээ дахин учран золгох болно гэсэн итгэл найдварыг сэтгэлдээ тээн тайтгарч билээ” хэмээн тэрээр цааш нь бичжээ. . . Их Эзэн нинжин сэтгэлтэй бөгөөд үхэл хагацлын гунигт мэдрэмж бүрийг арилгадаг. Чухам үүний төлөө би үлэмж баяртай байдаг билээ.¹⁶

Ерөнхийлөгч Смит авралын төлөвлөгөөний тухай гэрчлэлээсээ болон гэр бүлүүдийг үүрд мөнхөд лацдан холбодог ариун сүмийн ёслолуудаас хүч чадал, тайтгарлыг авдаг байлаа. Тэрбээр сургасан нь:

“Эцэг эх хүүхдүүд, эхнэр нөхрүүд бидний харилцаа тэнгэрт үргэлжлэх бөгөөд энэ бол Эцэг бидэнд тэнгэрт өвлүүлэхээр зэхсэн агуу, алдар суут хаант улсын зөвхөн эхлэл гэсэн итгэл үнэмшил нь биднийг найдвар хийгээд баяр баяслаар дүүргэдэг билээ.

“Хайрт гэргий минь бас энэрэлт эцэг эх минь талийгаач болж, миний амьдралаас эгнэгт авагдсан болохоор би тэднийгээ дахин харахгүй хэмээн олон хүний боддогтой адилаар бодох юм бол, энэ нь амьдралдаа миний эдэлдэг хамгийн агуу баяр баяслуудын нэгийг: тэдэнтэйгээ дахин уулзаж, хайр энэрэлд нь дахин багтаж, надаас өмнө хорвоог орхисон бүх хүмүүсийн төлөө чин сэтгэлээсээ талархах тэрхүү боломжийг надаас салгах болно.”¹⁷

“Үхэл бол мөнх байдлын туршид Бурханы хүүхдүүдийн хийх алхмуудын зөвхөн ганцхан нь бөгөөд энэ нь түүний төлөвлөгөөний дагуу тохиож байгааг бид ойлгосон үед үхлийн ялзралыг зайлуулж, мөнх амьдрал үнэн бодитойг бидний нүдэн дээр тохиолгох болно. Олон гэр бүл талийгаач болсон хайртай хүмүүстээ түр зуур баяртай гэж хэлэх хувь тавилантай юм. Үхэл хагацал болоход бид үймэн тэвдэж, барьц алдах юм бол энэ нь бидний амьдралд их уй гашууг авчрах болно. Харин бидний сүнсний мэлмий нээгдэж, түүгээрээ харж чадах юм бол бид харсан тэр зүйлээрээ тайтгарах болно гэдэгт би итгэлтэй байна. Их Эзэн биднийг итгэл найдваргүйгээр орхидоггүй юм. Харин ч үүний эсрэгээр хэрэв бид дэлхийд мөнх бус байдалд байхдаа түүний зөвлөгөөг хүлээн авч хэрэгжүүлбэл тэрбээр бидэнд мөнхийн аз жаргалын баталгаа бүрийг өгөх болно.

“Энэ бол хоосон мөрөөдөл биш. Энэ бол бодит үнэн.”¹⁸



Дээд талд: Ерөнхийлөгч Смит хүү бага Жорж Альберт Смитийн хамт. Дээд талд: Time сэтгүүлийн 1947 оны нэг дугаарт Ерөнхийлөгч Смит болон Сүмийн тухай өгүүлэл нийтлэгджээ.

Хайр ба үйлчлэл

Ерөнхийлөгч Смит бол бусдад үзүүлдэг хайраар нэрд гарсан хүн байлаа. Хайр бол сайн мэдээний голт зүрх гэдэгт тэрбээр итгэдэг байлаа. “Та нарт хүртээмжтэй болсон Есүс Христийн сайн мэдээ нөхдөө хайрлах хайрын мэдрэмжийг зүрх сэтгэлд тань суулгаагүй бол энэ Сүм зохион байгуулагдах үед дэлхийд ирсэн гайхамшигт бэлгийн бүрэн үр жимсийг та нар амсаагүй байгаа нь тэр гэдгийг би хэлмээр байна” хэмээн тэрбээр Гэгээнтнүүдэд хандан хэлсэн юм.¹⁹

Ерөнхийлөгч Смит Сүмийн Ерөнхийлөгчийн хувьд дэлхий даяарх халамжийн ажил болон бусад санаачлагуудаар дамжуулан мянга мянган хүний амьдралыг адисалсан юм. Үүний сацуу тэрбээр илүү хувийн шинжтэй, өчүүхэн жижиг үйлчлэл хийхэд цаг хугацаа олж чаддаг байлаа. Түүнтэй хамтран ажиллагчдын нэг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Эванс (1906–71) ийн бичжээ: “Ажлын өмнө эсвэл дараа түүнийг эмнэлгийн коридороор алхлан, эргэлтийн нэг өрөөнөөс нөгөөнд гэнэт хүрч очин өвчтөнүүдийг адислан, урам хайрлаж, хөгжөөн, тайтгаруулж, итгэл төрүүлэхэд тэд маш их баярладаг байжээ. . . . Тэр хаана ч очлоо гэсэн хүмүүст тусалж, урам хайрладаг нь түүний зан төлөвийн шинж юм.”²⁰

Ерөнхийлөгч Томас С.Монсон Ерөнхийлөгч Смитийн хайрын нэгэн жишээний тухай ийн өгүүлсэн байдаг: “Өвлийн нэгэн хүйтэн өглөө, гудамж цэвэрлэх багийнхан [Солт Лейк хотод] гудамжин дахь шуудуунаас том том мөсийг зайлуулж байжээ. Ажил эрхлэх нь туйлын шаардлагатай байсан түр хугацаагаар ажиллагчид байнгын багт тусалж байсан аж. Битүү захтай, хөнгөн ноосон цамцтай нэг хүн ихэд даарсан харагджээ. Сахлаа сайхан засч янзалсан өндөр гоолиг нэг хүн цэвэрлэгээний багийнхны дэргэд зогсож, нөгөөх ажилчнаас, ‘Өглөө ийм хүйтэн байхад та ноосон цамцнаас илүү дулаан хувцас өмсөх хэрэгтэй шүү дээ. Хүрэм чинь хаана байгаа юм бэ?’ гэж асуухад нөгөөх хүн хүрэм байхгүй гэжээ. Тэгтэл тэдэн дээр

ирсэн хүн хүрмээ тайлж, тэр ажилчинд өгөөд, ‘Энэ хүрэм таных. Зузаан ноосоор хийсэн болохоор та даарахгүй. Бид энүүхэнд гудамжны нөгөө талд ажилладаг гэв. Тэр нь Саут Темпл гудамж байлаа. Сүмийн Удирдлагын Байр уруу өдөр тутмын ажлаа хийхээр хүрэмгүйгээр алхаж орсон сайн самари хүн бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч Жорж Альберт Смит байлаа. Хар амиа үл бодсон түүний өгөөмөр сэтгэлийн энэхүү үйлдэл зүрх сэтгэлийнх нь өрөвч зөөлнийг харуулсан юм. Тэр ахынхаа манаач байсан нь лавтай.’”²¹

Өдөр тутмын амьдралынх нь нарийн ширийн зүйлс

Ерөнхийлөгч Жорж Альберт Смит галт тэргээр хамт зорчигчидтой итгэлээ хуваалцдаг байсан нь ч, гудамж цэвэрлэгч даарсан ажилчинд хүрмээ тайлж өгсөн нь ч, үйлдлээрээ болон сургаалаараа гэрчлэлээ хаа явсан газартаа хуваалцдаг байсныг харуулж байна. *Teachings of Presidents of the Church: George Albert Smith* номын эхнээс эцсийг хүртэлх үндсэн гол сэдэв бол Есүс Христийн сайн мэдээ бидний амьдралд хүчтэй нөлөө үзүүлдэг тухай юм.

Нэгэн судлаач Ерөнхийлөгч Смитийн тухай ийн хэлжээ: “Түүний шүтлэг бишрэл бол хөдөлгөөнгүй хөшүүн сургаал биш. Энэ бол онол биш. Энэ бол түүний хувьд бишрэм сайхан төлөвлөгөөнөөс илүү чухал зүйл. Энэ бол амьдралын философиос илүү чухал зүйл. Түүнтэй адилхан практик оюун ухаантай хүнд шүтлэг бишрэл нь хүний амьдардаг, юмсыг хийдэг хандлага, арга маяг юм. Энэ нь эелдэг уриалгахан ганц үг хэлэх эсвэл аяга хүйтэн ус өгөх зэргээр илэрч болно. Түүний шүтлэг бишрэл үйл хэргээр илэрдэг байх ёстой. Энэ нь өдөр тутмын амьдралд нарийн ширийн зүйлсээр илрэх ёстой.”²²

Тэргүүн Зөвлөл дэх түүний зөвлөхүүдийн нэг Ерөнхийлөгч Бага Ж.Рюбен Кларк Ерөнхийлөгч Смитийн амьдралыг дараах үгсээр товч тодорхойлжээ: “Тэр бол заасан зүйлийнхээ дагуу амьдарч чаддаг байсан цөөхөн хүний нэг байлаа.”²³ ■

ЭШЛЭЛ

1. Жон А.Видцөү, Conference Report, 1951 оны 4-р сар, 99; мөн *Teachings of Presidents of the Church: George Albert Smith* (2011), xxxvii–xxxviii-ыг үз.
2. *Teachings: George Albert Smith*, 9.
3. *Teachings: George Albert Smith*, 223-ыг үз.
4. *Teachings: George Albert Smith*, 223.
5. *Teachings: George Albert Smith*, 227.
6. *Teachings: George Albert Smith*, 228.
7. *Teachings: George Albert Smith*, 124.
8. *Teachings: George Albert Smith*, 152.
9. *Teachings: George Albert Smith*, 125.
10. *Teachings: George Albert Smith*, 129.
11. *Teachings: George Albert Smith*, 150.
12. Престон Нибли, *Teachings: George Albert Smith*, 123.
13. *Teachings: George Albert Smith*, 235-ыг үз.
14. *Teachings: George Albert Smith*, 240.
15. *Teachings: George Albert Smith*, 228.
16. *Teachings: George Albert Smith*, xxvii-г үз.
17. *Teachings: George Albert Smith*, 83–84.
18. *Teachings: George Albert Smith*, 76–77.
19. *Teachings: George Albert Smith*, 14.
20. Ричард А.Эванс, *Teachings: George Albert Smith*, 11–13.
21. Томас С.Монсон, *Teachings: George Albert Smith*, 13.
22. Брайнт С.Хинкли, *Teachings: George Albert Smith*, 2.
23. Бага Ж.Рюбен Кларк, *Teachings: George Albert Smith*, 3.

АККУМЛЯТОР БА ЗЭВРҮҮН САЛХИ

Нэг өдөр Айдахогийн Фоллс Ариун сүмд ээлж солигдсоны дараа би тус ариун сүмээс өмнө зүгт байдаг хурдны зам дээр унтарч орхисон машин руу нь хоёр ахыг сайн дураараа хүргэж өгөв. Гэр бүлийн нэгэн эелдэгхэн хос арванхоёрдугаар сарын хацар хайрам хүйтэн өдөр зам дээр зогсож, Томпсон ах, Кларк ах хоёрыг тэндээс ариун сүмд хүргэж өгсөн ажээ.

Томпсон ах машиндаа шинэ аккумулятор худалдаж авъя гэсэн болохоор би түүнийг ойролцоох автомашины дэлгүүрт хүргэж өглөө. Миний машинд багаж байсан учир би аккумуляторыг нь сольж өгье гэлээ.

Аз болоход би хос шинэ бээлий авчирснаас гадна өвлийн хүрэмтэй байлаа. Би машины хамрыг сөхөөд ажилгүй болсон аккумуляторыг авч шинэ аккумулятор тавихаар бэлтгэлээ.

Аккумуляторыг солихын тулд машины зарим сэлбэгийг, түүний дотор салхивчны шил утаагчийг авч буцааж угсрах хэрэгтэй байлаа. Миний багажнууд бүх болтны хэмжээнд нь тохирохгүй байснаас гадна нэлээд хэдэн болтонд түлхүүр ерөөсөө багтахгүй байлаа. Янз бүрийн багажийг, өөр өөр байрлалаас хэрэглэх гэж оролдсон ч огт тус болсонгүй. Гадаа температур Цельсийн хасах 15 хэм байсан бөгөөд бага даацын ачааны машиныг яс янгинам хүйтэн салхи улих мэт сүнгэнэн үлээнэ. Ингээд хүйтэн жаварт хаашаа ч үгүй гацсан болохоор

байж болох цорын ганц тусламжийг гуйгаад үзэхээр шийдэв. Өөртөө хэрэгтэй байгаа зүйлийг Тэнгэрлэг Эцэгт тайлбарлан, эрэг

боолтуудыг суллах арга замыг олоход туслахыг гуйж чин сэтгэлээсээ залбирлаа. Залбирлаа дуусгаад бахь шүүрэн авч, сулрахгүй байсан эргийг эргүүлэл тэр дороо суларчихав! Чин үнэнээсээ, чимээгүйхэн талархал илэрхийлээд нөгөөх эргийг авч, цааш нь үргэлжлүүлэв.

Тэгтэл машины доод хэсэгт тэр доор нэг болт сулардаггүй ээ. Яах ч учраа олсонгүй. Дахиад чин үнэнээсээ, улам их итгэлтэйгээр залбирлаа. Энэ удаад эхлээд цаад талд нь байгаа хэдэн боолтыг дараа нь аккумуляторын бүсийг тайлж авахад

би чиглүүлэгдлээ. Сулрахгүй байсан боолт амархан суларлаа. Хэдэн хормын дараа хуучин аккумуляторыг салган гаргаж ирэв.

Шинэ аккумуляторыг тавьж, бээрснээс мэдээ алдсан хуруунуудаар бүх эрэг боолтуудыг чадахынхаа хэрээр буцааж эргэдсэний дараа цахилгааны утсуудыг залгав. Томпсон ах түлхүүрээ эргүүлээд, машин асахад яралзтал инээмсэглэв. Тэгэхэд нь би машины хамрыг хаалаа. Гадаа цаг орчим байсан болохоор миний шилбэ, тавхай даарснаас мэдээ алдаж, хөшсөн учир машинд орохдоо эв хавгүй бүдрэв.



Янз бүрийн багажсийг, өөр
өөр байрлалаас хэрэглэх гэж
оролдсон ч огт тус болсонгүй.
Ингээд хүйтэн жаварт хаа-
шаа ч үгүй гацах нь тэр.

ҮНЭ ЦЭНЭТЭЙ ЗҮЙЛ

Би үйлчлэгчдэд утсаар үйлчилгээ үзүүлэх төвд ажилладаг байлаа. Энд хамт ажиллагчид хоорондоо уулзаж, харилцах боломжгүй байлаа. Бие биетэйгээ танилцах боломжийг бидэнд олгохын тулд манай дарга нийт ажиллагсдадаа зориулж нэг бямба гарагт үдийн хоол өгөхөөр шийдсэн юм. Хүн бүр өөртөө үнэ цэнэтэй ямар нэг юмаа авчирч, яагаад энэ нь эрхэм чухал болохыг тайлбарлахыг тэр бид бүгдэд зааварлав.

Би даргынхаа энэ хүсэлтийн талаар бодож үзээд, энэ нь миний хувьд хамт ажиллагсдадаа сайн мэдээний тухай заах боломж юм гэдгийг ойлгож билээ. Шүтлэг бишрэл бол эмзэг сэдэв гэдгийг мэдэж байсан болохоор авч очих юмныхаа талаар болгоомжтой байж, уг зүйл надад яагаад үнэ цэнэтэй болохыг хэрхэн тайлбарлахаа бодлоо.

Хоол өгөх өдөр бид бие биетэйгээ сайн танилцсандаа бүгдээрээ баяртай байлаа. Хоолны дараа манай дарга өөрийн үнэтэй зүйл—гэр бүлийн фото зургийн цоморлигоо үзүүлж, үйл ажиллагааг эхлэв. Тэрээр нөхрөөсөө салж, өрх толгойлсон эх болоод амьдралаа шинээр эхлэхэд туулсан сорилт бэрхшээлүүдийн талаар бидэнд ярилаа.

Нэлээд хэдэн хүний дараа миний ээлж ирлээ. Миний авчирсан зүйл бол өдөр бүр биендээ авч явдаг ЗС (Зөвийг сонго) бөгж юм гэдгийг би хамт ажиллагсдадаа ярилаа. Би тэнд ЗС гэдэг хоёр үсэг бол “Зөвийг сонго” гэдэг үгсийг товчилсон үсэг болохыг хэлээд энэ бөгж Бурханы зарлигуудад үргэлж дуулгавартай байхыг надад сануулдаг юм гэлээ. Нэлээд хэдэн хүн Сүм болон Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн итгэл бишрэлийн тухай асуусан нь Тэнгэрлэг Эцэгээс хүүхдүүддээ зориулсан төлөвлөгөөн дэх гэр бүлүүдийн ач холбогдлын тухай, гэр бүлүүд үүрд мөнх оршиж болно гэдгийг

мөн бидний төлөө амиа өгсөн Аврагч бидэнд бий гэдгийг тэдэнд ярих боломжийг надад олгосон юм. Би бас номлолынхоо зарим туршлагаас хуваалцлаа. Би ярьж байх үедээ хамт ажиллагсдынхаа нэгэн адил Сүнснийг мэдэрсэн.

Тэр өдрөөс хойш зарим хүмүүс сайн мэдээний талаар нэлээд олон асуулт асуухад би тэдний заримыг нь сүмд урьж билээ. Хожим нь би ажлаа өөрчилсөн болохоор тэднээс хэн нэг нь илүү их зүйл мэдэхийг сонирхсон эсэхийг мэдээгүй ч, Есүс Христийн үнэн Сүм дэлхий дээрх байдгийг, хүүхдүүддээ зориулсан аз жаргалын төлөвлөгөө Тэнгэрлэг Эцэгт байдгийг хамт ажиллагсдадаа ярьж өгсөндөө сэтгэл тэнэгэр байдаг мэдсэн билээ.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бид сайн мэдээг хуваалцах үүрэг хариуцлагатай билээ. Бид ЗС бөгж мэтийн өчүүхэн бөгөөд энгийн зүйлсээр дамжуулан, ах, эгч нарынхаа авралын төлөө үйлчилж болох агуу хичээлүүдийг зааж чадна. ■
Рафаел Барриос, Санта Фе, Аргентин

Шүтлэг бишрэл бол эмзэг сэдэв гэдгийг мэдэж байсан болохоор би хуваалцах зүйлийнхээ тухайд нягт няхуур байх хэрэгтэйгээ мэдэж байлаа.



Би Томпсон ах, Кларк ах хоёрыг гэртээ эсэн мэнд хариг гэж тэдний араас дагаж явлаа. Машинаа суугаад явах үед халаагуур ажиллан, шилбэ, тавхайг алгуурхан дулаацууллаа. Би Тэнгэрлэг Эцэгтээ тусалсных нь төлөө үлэмж ихээр талархлаа. Би буцах замдаа Тэрбээр энэ хоёр ахын залбиралд намайг Өөрийн үйлчлэгч болгон илгээснийг мэдээд сэтгэл догдолж билээ. Их Эзэн өөрийн гайхалтай арга замаар тэдний хэрэгцээг хангаж, миний итгэлийг дахин нотолсон юм. ■

К.Лий Бендиксен, Айдахо, АНУ

*Намайг сэтгэлийн шанал-
гаагаа дарах гэж буйдан
дээр сууж байтал, манай
хоёр настай хүү хоосон хөн-
жил уруу хүрч ирэн, “Сайн
уу, бяцхан дүү минь” гэв.*



даван туулахын тулд хийдэг байсан зүйлийг хийх ёстойгоо би мэдсэн юм. Мөн хүнд бэрх цагт тэдний амьралд дүүрэн байсан Аврагчийг хайрлах хайраар би энэ бүхнийг хийх ёстой.

Би ийнхүү өдөр бүр хувиараа судар судлах явцдаа Их Эзэний мутар агуу хайраараа намайг тэвэрч байсныг, тэрчлэн бүхний төлөө Түүний цагаатлагч золиослолын хүчийг мэдэрдэг байлаа. Сүнс надтай ярьж, амар амгалан намайг эзэмдэн, эрч хүчтэй залбиралд минь хариу ирж билээ. Уншсан үгсээ тунгаан бодсон нь уй гашуу, уйтгар гуниг тохиосон үед надад хүч чадал өгсөн юм.

Нэг өдөр дараах үгсийг уншсан үед Сүнс намайг баяр баясаар дүүргэж билээ:

“Би бага насны хүүхдүүдийг төгс хайраар хайрладаг; мөн тэд бүгдээр адилхан мөн авралыг хүртэгсэд бөлгөө. . . .

“Бага насны хүүхдүүд . . . түүний нигүүлслийн улмаас [Бурхан дотор] бүгд амьд юм. . . .

“Учир нь болгоогтун бүх бага насны хүүхдүүд Христээр амьд юм” (Моронай 8:17, 19, 22; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Би охиноо Христ дотор *амьд*, инээмсэглэн, аз жаргалаар дүүрэн, Түүний гарт тэврүүлсэн байхыг нь харсан юм шиг мэдэрэмж төрж билээ. Тэр үеэс хойш би тэвчих хүчийг, гэр бүлийнхээ төлөө бие сэтгэл бүхнээ зориулах шинэ итгэл найдварыг мэдэрдэг болсон юм. Хэрэв бид Цагаатгалаас, судруудаас, амьд бошиглогчдын үгсээс, тэрчлэн ариун сүмийн гэрээнүүдээрээ дамжуулан бие биенээсээ чанга зууран барьвал, мөнхийн гэр бүл болж дахин нэгдэх болно гэдгийг би мэдэж байлаа.

Есүс Христийн тухай, Тэрээр бидний төлөө юу хийснийг болон юу хийдгийг, бид Түүнтэй адилхан болохын тулд юу хийх ёстой тод томруун гэрчилдэг Мормоны Номонд би дуртай. Мормоны Ном

МОРМОНЫ НОМОО УНШ

Бид хоёр баяр хөөрөөр бялхана даа бодож байсан ч, сэтгэл зүрхэндээ гуниг тээж, гар хоосон буцаж ирлээ. Дебра Каилия Картер 2010 оны 4-р сарын 26-нд төрөх ёстой өдрөө мэндэлсэн ч, амьгүй төрсөн юм.

Бид гэртээ орж ирээд Дебраг эмнэлэг дээр өргөж, тэврэхэд ашигладаг байсан жижигхэн ягаан хөнжлийг гаргаж ирлээ. Намайг сэтгэлийн шаналгаагаа дарах гэж буйдан дээр сууж байтал, манай хоёр настай хүү хоосон хөнжил уруу хүрч ирэн, “Сайн уу, бяцхан дүү минь. Чамдаа хайртай шүү” гэж шивнэв.

Нүүрийг минь даган нулимс урсахад би эргэн харж суулаа. Эргэж хараад суутал хананд өлгөөтэй байгаа *Найз* сэтгүүлийн нэгэн үзүүлэнгийн: “Бидний Тэнгэрлэг Эцэг

ганцхан залбирлын зайтай, харин Ариун Сүнс шивнэх төдий зайд оршдог” гэсэн үгсийг олж харлаа.¹

Би эрч хүчтэй, нам гүмхэн залбирлаар зүрх сэтгэлийнхээ үгсийг Бурханд хандан юулж эхэллээ. Тэгээд залбирсныхаа дараа “Мормоны Номоо дахин унш” гэж Ариун Сүнс шивнэхийг мэдэрлээ. Номыг уншиж дууссан ч нөгөөх мэдрэмж болон сүнсний өдөөлт тодоос тод мэдрэгдэж байлаа.

Маргааш өглөө нь би эрт босч Мормоны Номоо уншиж эхлэв. Итгэл, залбирал, найдвар, Есүс Христийн зан чанар, сайн мэдээг номлох болон Их Эзэний дуу хоолойг анхааран сонсох тухай бүх хэсгийг харандаа, самбарын үзгээр тодруулан зурлаа. Нифай, Инос, Моронай болон Мормоны Номын бусад бошиглогчид сорилт бэрхшээлүүдийг

миний амьдралд гэрлийг авчирч, зүрх сэтгэлийг минь Христэд найдах найдвараар дүүргэсэн юм. ■
Жювелин Картер, Виржини, АНУ

ЭШЛЭЛ

1. Элайн С.Далтон, "At All Times, in All Things, and in All Places," *Лиахона*, 2008 оны 5-р сар, 118-аас авав.

ААВЫН ГУТАЛ

Хэдэн жилийн өмнө аав, ээж хоёр тусламж хэрэгтэй хүмүүст хандивлах гутал хувцас, бусад юмсыг цуглуулахад Нийгмийн Халамжийн Бүлэгт тусалж байх үеэрээ бөөн хувцас хунарын дотор тун дажгүй сайн нэг хос гутал байхыг ажиглажээ. Тэр агшинд нөгөөх гутлыг авч хадгалах юмсан гэсэн хүчтэй бодол аавд төрсөн гэнэ.

Ээж инээд алдаад, "Энэ гутал чиний өмсдөгөөс гурван размераар бага юм байна шүү дээ. Огт таарахгүй!" гэжээ.

Гэвч аав дахин дахин шалсаар байж. Эгч нар хэдэнтээ наргиа үгс хэлсний дараа нөгөөх гутлыг авч хадгалахыг аавд зөвшөөрсөн ажээ.

Аав гэртээ ирмэгц авчирсан гутлаа тослон, дотор нь сонин чихэж, хайрцганд хийгээд шүүгээн дээрээ тавьлаа. Хайрцганд хурч болохгүй гэж бидэнд анхааруулав. Тэр гутал таван жил нөгөөх газраа байсаар байв.

Нэг өдөр манай зэргэлдээх байшинд нэг айл нүүж ирлээ. Тэднийх хоёр охин, зургаан сартай нэг жаалтай айл байлаа. Эгч бид хоёр тэдний хоёр охинтой тэр дороо найзууд боллоо. Тэр хоёр охин бидний үе чацуутнууд байв. Бид сүм дээр сүрч мэдсэн зүйлээ шинэ найз нартайгаа хуваалцаж байснаас гадна тэднийг Хүүхдийн Хэсэгтээ урьлаа. Тэд сэтгэл догдлон, бидний хуваалцсан зүйлийн талаар илүү ихийг мэдэх хүсэлтэй байв.

Тэд Хүүхдийн Хэсгээс гэртээ ирсний дараа Сүмийн тухай аав, ээжтэйгээ зогсолтгүй ярилцаж байлаа. Манай аав ээж хоёр тэднийхийг бүгдээрээ номлогчдын хичээлүүдийг сонсож, сүмд явахыг урив. Тэднийхэн урилгыг баяртай хүлээж авлаа. Номлогчдын хичээл тэдэнд таалагдсан учир бид тэдэнтэй хамт сүмд явахдаа баяртай байв.

Гэвч хагас сайн өдөр болоход тэдний охид нэг л уруу царайтай харагдав. Юу болсон тухай биднийг асуухад аав, ээж хоёр нь сүмд явахгүй гэж байна гэж охид хариулав.

Бид хоёр санаагаар унаж, аавыг тэдний эцэг эхтэй яриач гэж гуйлаа. Аав сүмд явснаас ирдэг адислалуудын тухай тэдэнд ярихад, тэдний аав, "Тийм ээ, би энэ бүхний тухай мэднэ. Асуудал нь юу гэвэл би удаан хугацаанд гүйлтийн энэ шаахайнаас өөр гутал өмсөж элээгээгүй хүн. Гэтэл Сүмийн

цуглаанд сайхан хувцаслаж явах ёстой шүү дээ" гэж хариулжээ.

Тэр агшинд аав ээж уруу харлаа. Ээж яах ёстойгоо тэр дор нь ойлгосон юм. Аавын шургуулгатай шүүгээн дээрх хайрцаганд байсан гутал найз охидын маань аавд яг таарч, тэднийхэн бүгдээрээ сүмд явж билээ. Тэр ням гараг тэдэнд ч, бас бидэнд ч гайхалтай сайхан байлаа. Тэд удалгүй Сүмийн гишүүд болсон. Өнөөдөр тэд мөнхийн сайхан гэр бүл болоод байгаа.

Тэр гутлыг авч хадгалах удирдамжийг аав Ариун Сүнснээс хүлээн авсныг би мэднэ. Үүний үр дүнд сайн мэдээг сонсоход бэлэн байгаа гэр бүлүүдийг эрж олох удирдамжийг би Түүнээс байнга эрэлхийлдэг билээ. Тэрбээр гэр бүлүүдийг бэлтгэдгийг, мөн бид тэднийг эрж олон Христэд авчрах хэрэгтэйг би мэднэ. ■

Присила Коста Завиер, Сан Пауло, Бразил

Хэдийгээр ээж инээд алдаад, "Энэ гутал чиний өмсдөгөөс гурван размераар бага юм байна шүү дээ" гэж хэлсэн ч, тэр гутлыг авах юмсан гэсэн хүчтэй бодол аавд төрсөн гэнэ.



ДЭЭШЭЭ ХАР

*Бид бүгдэд тохиолддог нэг
сорилт бол хүмүүс бидний
амьдралыг юу гэх бол гэж
хажуу тийшээ харах биш,
харин Бурхан биднийг юу
гэх бол хэмээн дээшээ
харах явдал юм.*



Ахлагч Карл Б.Кук

Далын



Би залуу байхдаа Германы Гамбургт номлолд үйлчлэхээр дуудагдсан. Өнөөгийн номлогчийн бэлтгэлийн төвийг орлож байсан Хэлний Бэлтгэлийн Номлолд би герман хэл сурах гэж шармахтайгаа хатдаг байж билээ. Нэг долоо хоног, дараа нь хоёр долоо хоног өнгөрлөө. Миний дүүрэг дэх бусад залуус надаас хавьгүй илүү өсч хөгжиж байгааг би харлаа. Тэд герман хэлний хэцүү дүрмүүдийг амжилттай эзэмшиж байхад миний “дай”, “дер”, “дас” угтвар үгс ёстой л “будaa” болж байлаа.

Миний санаа зовж, урам хутарч эхэллээ. Заахаар дуудагдсан хүмүүстэйгээ харилцаж чадахгүй юм бол би яаж номлолд амжилттай үйлчлэх юм бэ?

Тэгээд тусламжийн төлөө залбирч, санваарын адислал аваад нэлээд итгэлтэй болов. Харин хэчнээн ч чармайгаад нэг өдөр би улам санаагаар унаж, өмнөхөөсөө бүр илүү сэтгэл түтшиж байгаагаа мэдрэв. Хамтрагч бид хоёр үүдний хонгилоор явж байгаад би сахиулын ханын жижигхэн өрөөний дэргэд зогсож, хамтрагчаа түр

хүлээнэ үү гэв. Би тэр жижигхэн өрөөнд орж, угаалтуур дээр өвдөг сөгдөн сууж, Тэнгэрлэг Эцэгээс тусламж гуйлаа.

Их Эзэн миний залбиралд хариулсан юм. “Би чамайг герман хэлийг сайн эзэмш гэж дуудаагүй, харин бүх зүрх сэтгэл, оюун ухаан, хүч чадлаараа үйлчил гэж дуудсан юм” гэсэн үгс санаанд минь тодхон орж ирснийг би мэдэрч билээ.

“Би үүнийг чадна шүү дээ. Би бүх зүрх сэтгэл, оюун ухаан, хүч чадлаараа үйлчилж чадна. Хэрэв Их Эзэн үүнийг л надаар хийлгэх гэж дуудсан юм бол би үүнийг хийж чадна” гэсэн бодол тэр даруй төрлөө. Залбирлаас босох үед санаа сэтгэл тун сайхан болсон байлаа.

Тэр үеэс эхлэн өсөлт хөгжилтөө хэмжих миний хэмжүүр өөрчлөгдсөн юм. Би өөрийн өсөлт хөгжилт, амжилтыг хамтрагч болон дүүргийнхээ бусад гишүүдийнхтэй харьцуулан хэмжихээ больж, үүний оронд миний хийж байгаа зүйл

Их Эзэнд ямар санагдах бол гэдэгт анхаарал төвлөрүүлэх болов. Өөрийгөө бусад хүмүүстэй харьцуулж хажуу тийшээ харахын оронд би дээшээ хардаг, өөрөөр хэлбэл, Их Эзэн миний хүч чармайлтын талаар юу гэж боддогийг мэдэхийг хичээдэг боллоо.

Тэр үеэс хойш би герман хэлийг хэр зэрэг түргэн, хэр зэрэг сайн сурснаа мэддэггүй ч, нэг үе санаа зовдог байсан зүйлээ дахин мэдрээгүй юм. Их Эзэн надаар юу хийлгэхийг хүсдэгийг, мөн үүнийг хийхэд миний хүч хангалттай гэдгийг би мэдэж байлаа.

Тухайн өдөр юу болохыг мэддэггүй байсан ч би чадах бүхнээ хийх болно гэдгийг Тэнгэрлэг Эцэгт хэлж, өглөө бүр Түүнтэй зөвлөдөг боллоо. Би залбиралдаа, “Миний сурч чадах юм бүхнийг сурах боломжийг надад олгож өгөөч, юу байх нь хамаагүй, би чадах бүхнээ Танд зориулах болно” гэж хэллээ.

Өдөр нь юу сурч мэдсэн, юу хийснээ шөнө нь илтэхийн тулд дахин залбирдаг байлаа. Түүнчлэн өөрийн сорилт бэрхшээл, амжилт бүхнийг би тэнгэр дэх



Эцэгтэйгээ хуваалцдаг байлаа. Өсөлт хөгжилтөө түргэсгэхийн тулд өөр хүмүүст ч биш, өөртөө ч биш, зөвхөн Бурханд ханддаг болсон билээ.

35 жилийн тэртээ ханын жижигхэн өрөөнд миний авсан тэрхүү сургамж, олон дуудлага, ажил үүрэг гүйцэтгэх явцад насан туршид санаанд минь тодхон үлдсэн юм. Миний хүч чадлаас хэтэрсэн юм биш үү гэж санагдахаар ямар нэг зүйл хийхийг надаас хүссэн үед дээрх туршлага надад, “Хүлээ. Хэн чамайг дуудсан билээ? Хэнд чи үйлчилж байгаа билээ? Хэнийг чи баярлуулахаар чармайж байгаа билээ? гэж надад хэлдэг.

Өнөөгийн бидний амьдарч байгаа дэлхийд олон янзын хэмжүүр байдаг ч тэдгээрийн олонх нь биднээс шууд хамааралгүй юм. Ялангуяа залуу хүмүүст ийм хэмжүүрүүд онцгой хатуу байж болно гэж би боддог. Чи сургуульд сурч аль нэг хичээлээр дүн авдаг, гэвч энэ дүнг бусад хичээлүүд, чиний гэр бүл болон амьдралын нөхцөл байдал чинь ямар билээ гэдэгтэй холбогдуулан үзэх шаардлагагүй. Заримдаа биднийг харагдах байдлаар эсвэл унаж яваа машинаар үнэлэн дүгнэх нь байдаг. Бид өөрийнхөө үнэ цэнийг нийгмийн сүлжээний сайтууд дахь вэб хуудсанд хэчнээн найз нөхөд бичигдсэнээр үнэлж болох юм. Бид ямар хүнтэй болздог талаар эсвэл сургууль төгсөхөөсөө өмнө гэрлэвэл хүмүүс юу гэж бодох бол хэмээн санаа зовдог. Бусдыг баярлуулахыг боддоогоо харуулах нь амархан ч, бид дээрх гална талын хэмжүүрүүдэд итгэж болохгүй. Учир нь дэлхий магтах, муулах хоёрт аль алинд нь хэтэрхий түргэн.

Бид бүгдэд, тэр тусмаа залуу насанд хүрэгчдэд тохиолддог нэг

сорилт бол хүмүүс бидний амьдралыг юу гэх бол гэж хажуу тийшээ харах биш, харин Бурхан биднийг юу гэх бол хэмээн дээш харахыг хичээх явдал мөн гэж би боддог. Тэрбээр гаднах байдлыг биш харин зүрх сэтгэлийг хардаг (1 Самуел 16:7). Мөн Тэрбээр бид бүтдийн хэрэгцээг өөр хэнээс ч илүү сайн мэддэг.

Ингэхлээр хэрхэн “дээшээ харах” билээ? Бидэнд тусалж чадах хэдэн зарчим байдаг.

Сүнсний хүч чадлыг эзэмш

Бид өдөр бүр хувиараа залбирч, судар судлах замаар шийдвэр гаргахад өөртөө хэрэгтэй сүнсний хүч чадлыг эзэмшиж болно. Өдөр тутмын залбирал нь бидэнд зориулсан Бурханы төлөвлөгөөнд хүлээн зөвшөөрөгдөхүйц гуйлтыг агуулж болно. Бид уг төлөвлөгөөг бүхэлд нь харж чадахгүй ч, тухайн өдрийн төлөвлөгөөг хүлээн авч, хэрэгжүүлэх чадварыг гуйж болно. Бид сүнсний өдөөлтийг хүлээн авамтгай байсан үед Түүнийг дагахаар хийсэн сонголтынхоо үр дүнг үзэх болно. Мөн хүлээн авсан өдөөлтүүдийнхээ дагуу үйлдэх чадвартай болно. Бид адармаатай зүйлсийг хийх, шаардлагатай болсон юуг ч гэсэн зөв учир шалтгааны улмаас хийх чадвартай болно.

Хүлээн авсан удирдамжиндаа үнэнч бай

Бид хувийн илчлэлтээр дамжуулан хайрт Тэнгэрлэг Эцэгээсээ хүлээн авсан удирдамжиндаа үнэнч байснаар “дээшээ харж” чадна. Зарим үед хүмүүс биднийг хүлээн авсан удирдамжийнхаа дагуу ажиллахгүй байхыг ятгаж мэднэ. Бүр тэдний бодол зөв байсан ч бид мэдэрсэн зүйлдээ тууштай үнэнч байх хэрэгтэй.

**Бид хувийн илчлэлтээр
ламжуулан хайрт Тэн-
гэрлэг Эцэгээсээ хүлээн
авсан удирдамж чиг-
лэлдээ үнэнч байснаар
“дээшээ харж” чадна.**





ТЭНГЭР ӨӨД ХАР

“Тэнгэр өөд харах нь насан туршийн хүч чармайлт байх ёстой. Зарим мунхаг хүмүүс Бурханы мэргэн ухаанаас нүүр буруулж, гаднаа гяланцаг болсон хоосон зүйлийг шүтэж, хуурмагаар нэрд гарахын хойноос улайран хөөцөлддөг. Тэдний биеэ авч яваа байдал өв залгамжлах эрхээ таваг шөлнөөс сольсон Есавын гунигт түүхтэй төстэй юм.

“Ийм үйлдэл ямар үр дагавартай байдаг вэ? Бурханаас нүүр буруулах нь гэрээнүүдээ зөрчиж, хүсэл мөрөөдөл замхран, итгэл найдвар үгүй болно гэсэн үг. Ийм намаг балчиг, сордог элснээс зайлсхийж байхыг би та нараас хичээнгүйлэн гуйж байна. Та нар бол эрхэм дээд өв залгамжлах эрхтэй хүмүүс. Бидний Эцэгийн хаант улс дахь мөнх амьдрал бол та нарын зорилго.

“Энэхүү зорилгод ганц удаагийн үсрэлтээр хүрдэггүй, харин насан туршийн зөв шударга үйлс, ухаалаг сонголтуудын үр дүнгээр, эрхэм дээд зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө байнга хичээн зүтгэснээр хүрдэг.

“Өнөө үеийн төөрөгдөл, үзэл санааны зөрчил сөргөлдөөн, өдөр тутмын амьдралын зовлон бэрхшээл дунд итгэл нь бидний амьдралын бат бөх үндэс болж байна.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Guideposts for Life's Journey” (Brigham Young University devotional address, 2007 оны 11-р сарын 13), 3, speeches.byu.edu.

Манай нэг охин Испанид бүрэн цагийн номлолд үйлчилдэг. Намайг номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байх үед охин маань Шинэ Зеландад ахлах сургуульд сурч байлаа. Тэр 21 хүрээд, “Аав, ээж хоёр оо, би номлолд үйлчилмээр байна” гэж билээ. Мэдээж хэрэг, охин маань зөв шийдвэр гаргасанд бид баяртай байсан ч, өсвөр насныхаа жилүүдэд найз нөхөд, гэр бүлээсээ алс хол амьдарч байсан нь түүний хувьд золиослол болсныг мэдэж байсан учир би, “Чи номлолд аль хэдийн үйлчилсэн шүү дээ” гэв.

Охин маань инэмсэглэснээ, “Үгүй ээ, аав аа, *та* үйлчилсэн шүү дээ. Харин *би* одоо Их Эзэнд үйлчилмээр байна” гэлээ.

“Сайн байна” гээд би инэмсэглэн, “Охин минь номлолдоо яв. Үйлчлэх өдөөлтийг дага” гэв.

Өнөөдөр охин минь зөвхөн Тэнгэрлэг Эцэгтээ болон Испани дахь Түүний хүүхдүүдэд үйлчилж байгаа төдийгүй өөрийн мэдэрсэн сүнслэг өдөөлтийг дагасанд би баяртай байна. Охин минь аавынхаа хий гэж хэлсэн зүйлээс өөр зүйл хийхдээ амьдралд нь зөв зүйтэй бөгөөд өөрт нь зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд орсон зүйлийг хийсэн юм.

Зоригтой үйлдэхээс бүү бай

Бидний амьдралд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг мэдэх нь чухал болохоор бид заримдаа аль нэг зүйлийн эхлэлээс төгсгөлийг хүртэл бүх юмыг нэгд нэгэнгүй нарийн мэдэх гээд төвөгтэй байдалд орж гацдаг. Ийм занганд бүү ор. Эрүүл саруул ухаанаар зөв сонголт хийвэл амьдрал чинь урагш ахина. Бид зөв сонголт хийснээрээ адислагддаг. Алдаа гаргахаас айдаг бол сонголт хийхээс

бүү ай. Шинэ зүйлийг туршиж үзэхээс бүү ай. Ингэснээр чи аялалдаа баяр баяслыг олох болно.

Тэвчээртэй хүлээ


Манай гэр бүлийг Шинэ Зеландад амьдарч байхад сонирхогчид, шинэ хөрвөгчид, номлогчид болон бусад хүмүүст тохиолддог байсан олон сорилт бэрхшээл заримдаа биднийг тэвдүүлдэг байж билээ. Бид хариу авахын тулд олон удаа залбирч, хариугаа *түргэн* авна гэж боддог байлаа!

Бид бүгдэд тусламж хэрэгтэй. Заримдаа бид эрж байгаа шийдэлдээ түргэн *хүрдэг*. Гэвч зарим үед шийдэл нь бидний бодож байснаас өөр замаар, эсвэл бидний хүсэн хүлээж байснаас хожуу ирдэг. Заримдаа хариу ерөөсөө ирэхгүй юм биш үү ч гэж бодогдож мэднэ.

Дээрх тохиолдлуудад, Их Эзэн тусламж илгээтэл урт удаан хугацаа өнгөрөх байлаа ч “тэвчээртэй хүлээ”. Гэвч тэвчээртэй хүлээ гэдэг нь зүгээр суу гэсэн үг биш. Дээр өгүүлснээр, зоригтой үйлдэхээс бүү ай. Үргэлж сайн зүйлсийг хийж бай. Зарлигуудыг үргэлж сахь. Заавар хүлээн автал байнга залбирч, судар судлан, чадах бүхнээ хийсээр бай. Тэвчээртэй хүлээхээс бүү шантар. Их Эзэн Өөрийн цагт бүх зүйлс чиний сайн сайхны төлөө үйлчлэхээр болгоно.

“Дээшээ харсан нь” Хэлний Бэлтгэлийн Номлолд байсан үеэс эхлэн намайг удаа дараа адисалсан юм. Их Эзэн Хиламан 3:27-д, “Зүрх сэтгэлийнхээ гүнээс түүний ариун нэрийг дуудах бүгдэд Их Эзэн нигүүлсэнгүй байдгийг” Мормон тайлбарласан байдаг. Би Түүний нигүүлсэл, хайр энэрлийг биеэрээ амсаж, мэдэрсэн хүн. Түүнд итгэж, нэрийг нь дуудсан үед Түүний нигүүлсэл бид бүгдэд ирнэ гэдгийг би мэднэ. ■

Нүдийг нь оносон хариулт



Залуу эрэгтэйчүүдийг
номлолд явах ёстой
гэж яагаад тийм их
шахаж шаарддаг юм бэ?
Энэ чинь хувь хүн өөрөө шийдэх ёстой
асуудал биш үү?

Залуу эр хүн бүр номлолд үйлчлэх санваарын үүргээ биелүүлэх үү, үгүй юу гэдгийг өөрөө шийдэх ёстой. Ерөнхийлөгч Томас С.Монсон ийн хэлжээ: “Зохистой, чадвартай залуу эрэгтэй бүр номлолд үйлчлэхээр бэлтгэх ёстой. Бидэнд үй олон адислалыг үргэлж өгч байдаг Их Эзэн биднийг санваарын үүрэг, хариуцлагаа биелүүлээсэй гэж хүсэн хүлээдэг юм. Залуу эрэгтэйчүүд ээ, номлогч болж үйлчлэхэд бэлтгэхийг би та бүхэнд зөвлөж байна” (“As We Meet Together Again,” *Лиахона*, 2010 оны 11р сар, 5–6).

Номлолд бэлтгэх нь Аароны санваартан залуу эр хүний туршлагын хэсэг юм. Энэ бол түүний үүрэг бөгөөд тэрээр энэхүү үүргийнхээ чухлыг ойлгодог байх ёстой. Хэрэв залуу эрэгтэй номлолыг шахалт шаардлага гэж үздэг бол, мэдээж хэрэг, номлолд үйлчлэх хэрэггүй. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний талаар бусадтай хуваалцах хүсэлтэй бол тэрээр номлолд үйлчлэх ёстой.

Гэвч тэрээр номлолд үйлчлэх талаар залбирч, “сануулж, тайлбарлаж, ухуулж мөн зааж, мөн Христэд ирэхэд бүхнийг урих” (С ба Г 20:59) түүний дотор бүрэн цагийн номлолд үйлчлэх ариун үүргийг санваар авах үед өөртөө хүлээснээ бас санах ёстой. Хэрэв залуу эрэгтэйчүүд эрүүл мэндээр тэнцэхгүй буюу хөгжлийн бэрхшээлийн улмаас номлолд үйлчлэх боломжгүй бол энэ үүргээс хүндэтгэлтэйгээр чөлөөлөгддөг. ■



Хамгаалагч тэнгэр элчүүд байдаг уу? Намайг хамгаалахаар томилогдсон тэнгэр элч байдаг уу?

“**Х**амгаалагч тэнгэр элч”
гэсэн нэр томъёо
судруудад байдаггүй, харин
үүний оронд “тохинуулагч”

гэсэн үг байдаг (Омнаи 1:25;
Моронай 7:22 –29-ийг үз).
“Тэнгэр элчүүд Ариун Сүнс-
ний хүчээр ярьдаг бөгөөд”
(2 Нифай 32:3) итгэлтэй
хүмүүсийг тайтгаруулах,
удирдах, хамгаалах болон
үнэнийг илчилж, нотлох
Ариун Сүнсний үүргийг
олонтоо хуваалцдаг. Тийнхүү
Ариун Сүнсийг хамгаалагч
тэнгэр элч хэмээн үзэж болно.

Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын Ахлагч Жеффри
Р.Холланд сургасан нь: “Эрин
үеүдийн эхлэлээс хойш өдийг
хүртэл Бурхан хүүхдүүдээ
хайрлах хайр, анхаарал халам-
жийг дамжуулахдаа . . . тэнгэр

элчүүдийг ашигласаар ирсэн
юм. . . . Харагддаг болоод
харагддаггүй тэнгэр элчүүд
үргэлж ойрхон байдаг” (“The
Ministry of Angels,” *Лиахона*,
2008 оны 11-р сар, 29).

Хүн бүрийг харж хам-
гаалж байх тусгай тэнгэр элч
томилогдсон тухай Их Эзэн
илчлээгүй ч, таныг тэнгэрээс
хамгаалж тайтгаруулж байдаг
итгэлтэй байж болно. Хэрэв
итгэлээ хөгжүүлэн ашигладаг
бол Бурхан танд туслахын
тулд итгэлийг тань бэхжүүлж,
тайтгаруулан, зөв зүйлийг
хийх урам зоригийг хайрлаж,
тэнгэр элчүүдийг илгээдэг
билээ. ■

Ижил хүйстэнтэй бэлгийн харилцаанд орох талаар Сүм ямар бодлого баримталдаг вэ? Ижил хүйстэнд сэтгэл татагддаг хүмүүстэй найз нөхөд байж болох уу?

Сүм ижил хүйстэнтэй
бэлгийн харилцаанд
орохыг эсэргүүцдэг. Бид
үүний зэрэгцээгээр ижил
хүйстэнд сэтгэл татагддаг
хүмүүсийг ойлгож, хүндэтгэл-
тэй ханддаг.

Хэрэв та ижил хүйстэнд сэт-
гэл алдардаг хүмүүсийг таньдаг
бол: “Найз нөхдөө анхаарал
болгоомжтой сонго” гэсэн
бусад хүмүүстэй нөхөрлөхөд
баримталдаг зарчмаа баримтал.
Тэд таны бодол санаа, үйлдэлд
их нөлөө үзүүлнэ. Тэр ч бай-
тугай таныг ямар хүн бэ гэд-
гийг тодорхойлоход тусална.
Өөрийн чинь эрхэмлэдэг үнэт
зүйлсийг хуваалцдаг найз

нөхдийг сонго. Ингэснээр та
нар өндөр жишгүүдээр амьд-
рахад бие биенээ хүчирхэг-
жүүлэн, бие биедээ урам дэм
хайрлах болно. Жинхэнэ анд
найз өөрийг чинь хамгийн сайн
хүн болоход дэмжин тусална.
. . . Хүн болгонтой эелдэг найр-
саг, хүндэтгэлтэй харьц” (*За-
луучуудын бат бөх байдлын
төлөө* [товхимол, 2001], 12).

Хүмүүний бэлгийн харил-
цаа Тэнгэрлэг Эцэгийн тө-
лөвлөгөөнд онцгой зорилгыг
агуулдаг хэмээн Сүм сургадаг
билээ. Бид аз жаргалтай амь-
дарч, тэрхүү зорилгыг хэрэг-
жүүлэхийн тулд ариун явдлын
хуулиар амьдрахыг бидэнд

зарлиг болгосон юм. Ижил
хүйстэнтэй бэлгийн харил-
цаанд орох нь дээрх зорилгын
эсрэг бөгөөд Бурханы зарли-
гийг зөрчдөг.

Гэвч хэрэв хэн нэгэн нь
ижил хүйстэнд сэтгэл алдардаг
ч, энэхүү мэдрэмжээрээ ижил
хүйстэнтэй бэлгийн харил-
цаанд ордоггүй бол тэрээр
нүгэл үйлдээгүй хэрэг. Сүмийн
ёс суртахууны жишиг нь хүн
бүрийн хувьд, тухайлбал ижил
буюу эсрэг хүйстэнд сэтгэл
татагддагаас үл хамааран адил
юм. Их Эзэн болон Түүний
Сүм Түүний хуулиудыг зөрчдөг
аливаа зан авирыг өөгшүүл-
дэггүй билээ. Дахин хэлэхэд,
бид ёс суртахуунгүй авирласан
хүнийг биш, харин ийм зан
авирыг буруушаадаг. ■

*Энэ сэдвээрх нэмэлт мэдээллийг
Ахлагч Жеффри Р.Холланд, “Helping
Those Who Struggle with Same-Gender
Attraction,” Лиахона, 2007 оны 10-р сар,
40-өөс үзнэ үү.*



Ахлагч
Жеффри Р.Холланд
Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

ГЭРЭЭНҮҮДИЙГ САХИХ НЬ

НОМЛОЛД
ҮЙЛЧЛЭХ ХМҮҮСТ
ӨГСӨН ЗАХИАС



Энэ ажлын голт зүрх бол бид гэрээнүүдээ сахих явдал мөн. Бид бурханлаг байдлын хүчийг өөр юугаар ч харуулж чадахгүй.

Гэрээнүүдээ сахихын чухлыг, тухайлбал би өөрийн гэрээнүүдийг, харин та нар өөрсдийнхийгөө сахих нь агуу ач холбогдолтой тухай би та нарт ярья. Дуулгавартай байдал бол энэ сэдвийн нэг хэсэг гэдэг нь тодорхой хэдий ч энэ сэдэв бол дуулгавартай байдлын талаар ярилцахаас илүү чухал юм. Үүний сацуу энэ нь нэн хувийн шинжтэй сэдэв.

Энэ нь нэг талаараа сайн мэдээний төлөвлөгөөн дотор бидний ярилцах үндсэн тулгуур асуудал юм. Учир нь гэрээ хийгчид болон түүнийг сахин биелүүлэгчид нь селестиел хаант улсын дээд адислалуудын төлөө байдаг. Тийм ээ, бид гэрээг сахих тухай ярихдаа үхэшгүй байдал дахь өөрсдийн үндсэн гол зорилгын тухай ярьдаг.

Нэг удаа нэг гэрээ хийснээр хаант улсыг байгуулах нь

Гэрээ гэдэг бол сүнслэг байдлын талаар үүрэг хүлээсэн гэрээ, бид тодорхой нэг арга замаар—Түүний Хүү, Их Эзэн Есүс Христийн замаар амьдарч, бодож сэтгэн, үйлдэх болно хэмээн Бурхан Эцэгтээ хийсэн ариун амлалт юм. Эцэг, Хүү, Ариун Сүнс гурав түүний хариуд мөнх амьдралын бүрэн алдар суут бидэнд амладаг.

Гэрээнүүдийг хүмүүс хувиараа хийдэг нь миний хувьд сонирхолтой юм. Баптисм болон гишүүний баталгааны үед хийгддэг гэрээ биднийг мөнх амьдралын зам дээр гаргадаг. Эдгээр ёслолуудыг хүлээн авах хүмүүс хэчнээн олон байсан ч, тэдэнд нэг бүрчлэн тус тусад нь гүйцэтгэдэг билээ.

Эрэгтэйчүүд санваар авах үед хийдэг гэрээ байдаг. Санваарыг хүнд ямагт тусад нь мөн нэг л удаа олгодог.

Хамгийн дээд гэрээнүүдийг бид ариун сүмд хийдэг. Ариун сүм бол бид Тэнгэр дэх Эцэгтээ хамгийн ариун амлалт хийдэг газар, бас Тэрбээр бидэнд өгдөг амлалтуудынхаа жинхэнэ утга учрыг илүү бүрэн дүүрэн нээдэг газар юм. Дахин хэлэхэд, эдгээр нь хувь хүний, тухайлбал бид бусад хувь хүмүүстэй лацдан холбуулахаар ариун сүмд очсон үед ч хувь хүний туршлага байдаг.

Тийнхүү, нэг хүн нэг удаа нэг ёслол, нэг удаа нэг гэрээ хийх замаар мөнх бус байдалд бидний хийдэг аялал ариун сүмд хийгддэг эцсийн гэрээнүүд уруу хөтөлдөг.



Ариун сүмийн гэрээнүүдийн үүрэг


Хувийн хишгээ, түүний дотор гайхамшигтай ёслолуудыг хүлээн авахын тулд ариун сүмд явах нь уг хишигт өөрийг тань бэлтгэдэг бөгөөд энэ нь номлолын бэлтгэлийн тань нэг хэсэг, номлолд явах шийдвэр төгс байдлын тань илрэл гэдгийг ойлгох нь та нарт туйлын чухал юм.

Та нар ариун сүмд очоод ариун сүмийн гэрээнүүдийн ач холбогдлыг мөн ариун сүмд авдаг хувийн хишиг номлолын амжилт хоёр чинь хоорондоо салшгүй холбоотойг ойлгох болно.

Чухамдаа *ариун сүмийн хишиг* гэдэг үг энэхүү амин чухал холбооны гол шижим юм. Ариун сүмийн хишиг бол бэлэг. Энэ бол гэр бүлийн амьдралаа шинээр эхэлж байгаа хуримласан хост өгдөг онцгой бэлэг гэсэн утгатай юм. Би Бригам Янгийн Их Сургуулийн ерөнхийлөгч байхдаа өгөөмөр сэтгэлт хандивлагчдын бэлгүүдээс их сургуулийн байнгын сан бий болгоход тодорхой цаг заваа зориулсан юм.

Энэ бол бид Түүнтэй гэрээ хийх бүрд бидний төлөө Бурханы хийдэг зүйл





юм. Тэрбээр бидэнд *хишиг хүртээдэг*. Бид уг ёслолд холбогдох зарим тодорхой зүйлийг амладаг бол Тэрбээр хариуд нь өгүүлшгүй гайхамшигтай, бараг хүмүүний ой тойнд багтамгүй, эрхэм дээд баялгийг бидэнд амладаг билээ. Хэрэв бид дуудлага-даа үнэхээр амжилт гаргахыг хүсвэл, хэрэв бид Тэнгэр дэх Эцэгээс ирдэг тусламж, давуу тал, адислал бүрийг авч чадвал, хэрэв бид бурханлаг байдлын хүчийг хүлээн авахын тулд тэнгэрийн хаалга бидэнд нээлттэй байхыг хүсвэл, гэрээнүүдээ сахих ёстой гэдгийг би өөртөө ч бас та нарт ч хэлж байна!

Энэ ажлыг та нар ганцаараа хийж чадахгүйг мэднэ. Бидэнд тэнгэрийн тусламж хэрэгтэй; бидэнд Бурханы *бэлгүүд* шаардлагатай. Тэрбээр үүнийг энэ эрин үе дэх ажлын эхэнд заасан юм. Их Эзэн “Сионы гэтэлгэлийн” тухай ийн заасан юм:

“Тэд өөрсдөө бэлтгэгдэхийн тулд, мөн миний хүмүүс илүү сайнаар заалгаж, мөн туршлагатай болж, мөн өөрсдийн үүрэг,

мөн тэдний гараас миний шаарддаг зүйлүүдийн талаар илүү төгс мэдэхийн тулд буюу.

“Мөн миний ахлагчид тэнгэрийн хүчээр хишиг хүртээгдэх хүртэл энэ нь улиран тохиохоор авчрагдаж чадахгүй бөлгөө.

“Учрыг болгоогтун, тэд итгэлтэй байж мөн миний өмнө даруу төлөв байдалд үргэлжлүүлэхийн хэрээр агуу хишиг хийгээд адислал тэдэн дээр юүлэгдэхээр би бэлтгэсэн билээ” (С ба Г 105:10–12).

Энэ ажил туйлын нухацтай бөгөөд дайсны эсэргүүцэлтэй тулгардаг болохоор хүч чармайлтаа өсгөн нэмэгдүүлж, Сүмийг тууштайгаар урагш ахиулах бурханлаг хүч бидэнд нэн их хэрэгтэй. Хувь хүмүүс бидний хувьд үүнд хүрэх түлхүүр бол ариун сүмд бидний хийдэг гэрээ буюу дуулгавартай байж, золиослол хийх, Тэнгэр дэх Эцэгтээ өргөл өргөх бидний амлалт бөгөөд Түүний амлалт бидэнд “агуу хишиг” хүртээдэг билээ.

Гэрээнүүд ба Их Эзэний ажил

Бидний хувийн амлалтууд энэ ажлын агуу мөн чанар, нийт цар хүрээтэй харьцуулахад хэчнээн чухал болохыг харахад энэ нь та нарт тусалж байгаа биз дээ? Авра-лын төлөвлөгөөн дэх аливаа бусад зүйлийн адил дэлхий даяарх бүх ахлагч нар, систерүүдийн амжилтыг ганцхан номлогч, нэг л удаа тодорхойлдог.

Бид гэрээнүүдийг бүхэл тойрог, гадсаараа хийдэггүй шүү дээ. Харин бид Браун ах, Бөрнс ах, Жөүнс эгч, Женсен эгч гэхчлэн гэрээнүүдийг хийдэг. Энэ ажлын голт зүрх бол бид гэрээнүүдээ сахих явдал мөн.

Та нарыг ямар номлолд үйлчлэхийг би мэдэхгүй, гэхдээ Тэнгэр дэх бидний Эцэг та нарын номлолд өвөрмөц онцгой амлалтуудыг өгсөн юм. Тэрбээр та нарын хүн нэг бүрд агуу амлалтууд өгснийг би мэднэ.

Номлогч бүрийн зарчимч байдал, номлогч бүрээс гэрээгээ чанд сахьдаг хүч чадлаар бүхэл номлол нэгддэг бөгөөд ингэснээр бид уулыг ч нүүлгэж чадна. Номлол хийж буй хүн бүрд ирдэг эв нэгдэл,

хүч чадал, тэнгэрийн хишиг байгаа газарт “энэ ажлыг өсөлт хөгжилтөөс” нь юу ч зогсоож чадахгүй. Ийнхүү “Бурханы үнэн зоримгоор, ариунаар, юунаас ч хамааралгүйгээр урагш давших болно.”¹

Гинжин хэлхээний холбоос сул биш байгаа үед хуяг дуулганд хэврэг зай завсар байхгүй үед бидэнд итгэл үнэмшил байдаг. Нүгэл хилэнц, алдаа дутагдлын эсрэг дайн бол сайн мэдээ амжилтанд хүрдэг арга зам бөгөөд нэг гэрээг нэг хүн нэг удаа, нэг номлогч нэг удаа хийдэг билээ.

Чухам иймээс Их Эзэн Сүмийн эхэн үеийн удирдагчдад, “Миний өмнө бүх цэвэр ариун байдалд үйлдэхийн тулд та нар өөрсдөдөө үүрэг хүлээх болно, та нар үүнийг үйлдэхийн хэрээр та нарын хүлээн авсан хаант улсад алдар суу нэмэгдэх болно” (С ба Г 43:9–10) хэмээн мэдэгдсэн билээ.

Эдгээр үгс гэрээнд хамаатай юм. Энэ бол ариун сүмд явж Их Эзэний өмнө болон бие биенийхээ өмнө үүрэг хүлээж, “бүх цэвэр ариун байдалд” үйлдэхийн тулд бидний хийдэг тэр зүйл яах аргагүй мөн. Үүний хариуд бидэнд болон бидний ажилд хүч, алдар суу ирдэг билээ. Энэхүү хүч болоод алдар суу гэрээнүүдээ сахиснаар ирдэг бөгөөд Их Эзэн энэ тухай, “Миний хэлснийг та нар хийхэд Их Эзэн бибээр үүрэг хүлээдэг; гэвч миний хэлснийг та нар үл хийхэд та нарт амлаалт байх нь үгүй” (С ба Г 82:10) хэмээн хэлжээ.

Надад итгэ. Энэ ажлын голт зүрх бол гэрээнүүдээ сахих явдал мөн. Бид бурханлаг байдлын хүчийг өөр юугаар ч харуулж чадахгүй. Энэ тухайд Их Эзэний үг та нарт бий.

Та нар номлолдоо бэлтгэхийн тулд ариун сүмд явах хэрэгтэй. Ариун сүмд хийсэн гэрээнүүдээ нэг бүрчлэн сахь. Тэдгээр гэрээнүүд нэн хувийн шинжтэй бөгөөд Тэнгэр дэх Эцэгийнхээ өмнө бид бүгдийн хийдэг үлэмж ариун үүрэг амлаалт юм.

Гэрчлэлийн гэрээ

Үүнийг хийхийг та нараас хүсэхийн сацуу би өөрөө ч бас ийнхүү үйлдэх болно

гэдгийг мэдэхийг та нараас хүсч байна. Би өөрийнхөө гэрээнүүдийг сахина. Тэдгээр гэрээнүүдийн нэг нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүний хувьд “бүх дэлхийд Есүс Христийн нэрний” (С ба Г 107:23) тусгай гэрч байх явдал мөн. Би гэрээнүүдээ сахиснаар Их Эзэн Есүс Христ болон Түүний Цовдлолтын талаар зөвхөн өнөөдөр та нарт гэрчилж байгаа бус, харин энэхүү гэрчлэлийг дэлхийд нотлохоор дуудагдаж, томилогдон, ийнхүү гэрчлэх итгэмжлэл хүлээсэн билээ. Хайрт залуу найз нар минь ээ, би энэхүү үйлчлэлд та нартай нэгдсэндээ баяртай байдаг.

Бурхан амьд гэдгийг, Тэр бол Тэнгэр дэх бидний Эцэг гэдгийг, Тэрбээр бидэнд өгсөн амлалтуудаа ямагт биелүүлэх болно гэдгийг би мэднэ. Есүс бол Христ, махан биеэр төрсөн Эцэгийн Ганц Хүү бөгөөд дэлхийн Аврагч гэдгийг би мэднэ. Тэр шаналан зовж, цус нь шүүрэн, бид үүрд мөнх амьдрахын тулд амь эрсэдсэн юм.

Эцэг, Хүү хоёр энэ эрин үеийн агуу бошиглогч хөвгүүн Иосеф Смит дээр хүрч ирснийг би мэднэ. Тэрбээр бас дуудлагынхаа гэрчлэл, гэрээнүүдээ чин үнэнч байхын төгс бэлгэдэл болгон цусаа урсгасан юм. Өнөөдөр газар дээрх Бурханы тэргүүлэх дээд прист Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн удирдлага, бошиглогчийн үйлчлэл дор амьдарч буй, тасаршгүй гинж лүгээ адил 15 хүнд дээрээс ирсэн бошиглолын түлхүүрүүдийг би мэднэ.

Энэ ажил үнэн. Энэ тунхаглал үнэн. Дэлхий дээр амьдарч байсан буюу амьдарч байгаа мөнх бус аль ч эрэгтэй, эмэгтэй хэн нэгнээс эдгээр нь хамааралгүй юм. Миний амьдралд удирдамж чиглэл өгч, гэрчлэлийг минь үр өгөөжтэй болгон, намайг та нартай хамт дэлхийн Гэтэлгэгчийн тусгай гэрч бай хэмээн илгээсэн Ариун Сүнсний илэрхийллээр би дээрх зүйлсийг мэддэг билээ. ■

1997 оны 4-р сарын 25-нд номлогчдод зориулсан хиймэл дагуулын нэвтрүүлэгээр хэлсэн үгнээс.

Эшлэл

1. Иосеф Смит, *History of the Church*, 4:540.





ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮД ЭЭ, БОСЧ, УРАГШ ГЭРЭЛТҮҮЛ!

ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЕРӨНХИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ

Энэ жилийн Мючелийн сэдэв бол та нарыг удирдагч байхын төлөөх уриа дуудлага юм. Энэ бол ариун журмаар, даруу хийгээд цэвэр ариун байдлаар удирдан дагуулах дуудлага юм. Энэ бол дэлхийг өөрчлөх дуудлага!

Залуу Эмэгтэйчүүдийн байгууллагын хэсэг болсон

үед чинь алтан шаргал болон цагаан бамбартай хүзүүний зүүлтийг та нарт өгсөн байгаа. Энэ бол Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн залуу эмэгтэй та үнэн ба шударга ёсны

төлөө чанд зогсож, босч, дэлхийг гэрлээрээ гэрэлтүүлж явахыг сануулагч юм. Энэ нь та бол Бурханы үнэ цэнэтэй охин мөн гэсэн хүндтэй нэр төрдөө чин үнэнч байх ёстой гэсэн үг юм. Энэ нь та Түүнийг болон Аврагчийг “ямар ч цагт, мөн бүх зүйлд, мөн бүх газарт” (Мозая 18:9) гэрчлэхийг хичээн чармайх ёстой гэсэн үг юм.

Та энэ жил эргэн тойрныхоо хүмүүст үлгэр жишээ үзүүлэхийн тулд бамбартай хүзүүний зүүлтээ

бахархалтайгаар зүүж явах болно гэдэгт бид итгэлтэй байна. Та өдөр бүр **залбирч**, Мормоны Номыг **уншин Залуучуудын бат бөх байдлын төлөө** товхимол дахь **жишгүүдийг** дуулгавартай дагаж, **инээмсэглэснээр “урагш гэрэлтүүлэх”** болно. Та зарлигуудыг сахьж, **Залуучуудын бат бөх байдлын төлөө** товхимол дахь жишгүүдээр амьдарснаар баяр баясгалангаар гэрэлтэж, Ариун Сүнсээр удирдуулах шаардлагыг хангах болно гэдгийг бид мэдэж байна. Энэхүү удирдамж нь ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахаар зохистой байхад чинь туслах зөв сонголтууд хийх боломжийг та бүгдэд олгох болно.

Та нар эдгээр зүйлсийг хийх юм бол Аврагч замыг тань гэрэлтүүлэх болно гэдгийг Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн бид гэрчилж байна. Тэрбээр та нарт, “Би та нарын гэрэл байх болно . . . ; мөн би та нарын өмнө замыг бэлтгэнэ, хэрэв та нар миний зарлигуудыг дагавал; . . . мөн та нар надаар удирдагдаж байгаагаа мэдэх болно” (1 Нифай 17:13) хэмээн амласан билээ. ■



2012 ОНЬ МЮЧЕЛИЙН СЭДЭВ

“Та нарын гэрэл үндэстнүүдийн хувьд жишиг байж болохын тулд босч мөн урагш гэрэлтүүл”
(С ба Г 115:5).



Дээд талд: Элайн С.Далтон ерөнхийлөгч (голд); Мэри Н.Кук нэгдүгээр зөвлөх (зүүн талд); Анн М.Дибб хоёрдугаар зөвлөх (баруун талд). Дээд талд: Давид Л.Бек ерөнхийлөгч (голд); Ларри М.Гибсон нэгдүгээр зөвлөх (зүүн гар талд); Адрибн Окоа хоёрдугаар зөвлөх (баруун гар талд).



ГЭРЭЛТҮҮЛЭГЧ ҮЛГЭР ЖИШЭЭ БАЙ

ЗАЛУУ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЕРӨНХИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ

Сүмийн залуу эрэгтэйчүүд—Аароны санваартан дикон, багш нар, пристүүд та нар бол өөртөө Аврагчийн нэрийг авсан, Түүний ариун санваарыг эзэмшсэн хүмүүс билээ. Та нар Түүний ажлыг хийхээр, мөн та нарыг таньдаг бүх хүмүүсийг адислахаар дуудагдсан юм. Өнөө үе бол та нарын хувьд санваартны үүргээ биелүүлэн, “босч, урагш гэрэлтүүлэн” “үндэстнүүдэд жишиг” (С ба Г 115:5) байх цаг мөн.

Өнөө үе бол “Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, Тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэх” (Матай 5:16) цаг мөн. Есүс Христ бол төгс үлгэр жишээ мөн. Залуучуудыг Хүчирхэгжүүлэх нь номын дагуу Сүмийн жишгүүдийг сахьж, Түүний зарлигуудыг дуулгавартай даган, Түүнийг мэдэж, даган Түүнтэй улам адилхан болохыг хичээгтүн. Ингэснээр та нар эргэн тойрныхоо хүмүүст сүнсний хүч чадлын гэрэлтүүлэгч эх сурвалж байх болно.

“Их Эзэний савуудыг авч явахуйцаар цэвэр ариун байгтун та нар” (С ба Г 133:5) хэмээн Их Эзэн хэлсэн билээ. Ёс суртахууны цэвэр ариун байдал тань тойрог, салбарынхаа гишүүдэд онцгой гэрэл болон гэрэлтүүлж, ням гараг бүр тэдэнд ариун ёслолыг гүйцэтгэхэд

Аврагчийг зохистойгоор төлөөлөх боломжийг та нарт олгоно.

Гэр бүл, найз нөхөд, чуулгын гишүүд болон бусад хүмүүст анхаарал халамж тавьж, тэдэнд үйлчлэх боломж бүрийг ашигла. Ингэсэн тохиолдолд та тэдэнд болон өөрийг чинь чимээгүйхэн ажигладаг хүмүүст үйлчлэлийн баярт гэрэл болж чадна.

Бүх хүмүүсийг чин сэтгэлийн нөхөрлөл, нинжин сэтгэлийг гэрлээр гийгүүл. Сүмийн үйл ажиллагаануудаас ирдэг гайхамшигт олон адислал болон сайн мэдээний сургаалуудыг найз нартайгаа хуваалц. Зоригтой байж, Дэлхийн Гэрэл ба Амьдрал болсон Есүс Христэд ирэхэд тэднийг урь.

Бид та нарт хайртай. Бид та бүхний төлөө залбирдаг. Их Эзэн та нарт хайртай бөгөөд Түүний хаант улсыг байгуулахад туслахад та нар Түүнд хэрэгтэйг бид гэрчилж байна. Өнөө үе бол Түүний ариун санваарыг эзэмшигч та нарын хувьд “босч, урагш гэрэлтүүлэх” цаг мөн. Энэхүү санваараа эрхэмлэн дээдэлж, Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлснээр та нарын гэрэл



УРАГШ ГЭРЭЛТҮҮЛ

Бид бүгдэд гэрэл байдаг. Үүнийг хуваалц
(С ба Г 115:5-ыг үз.)

Сургаал ба Гэрээ 115:5.

Их Эзэн бидэнд босч, урагш гэрэлтүүлэхийг зарлигласан билээ.

Би та бүгдэд хэлж байна

1838 оны энэхүү илчлэлтэд Их Эзэн Сионыг байгуулах бусад асуудлын хамт Миссурийн Фар Вестэд ариун сүм барих тухай удирдамжийг өгсөн юм. Тэрбээр мөн эцсийн өдрүүд дэх Өөрийн Сүм: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн нэрийг өгсөн билээ. Энэ илчлэлтийг хэдийгээр тэр үеийн Сүмийн удирдагчдад өгсөн ч “босч, урагш гэрэлтүүлэх” зарлиг нь өнөө үед бид бүгдэд хамаатай юм.

Босч мөн урагш гэрэлтүүл

“Та нарын хүн нэг бүрээр хийлгэх агуу ажил Их Эзэнд бий. “Та нарын гэрэл үндэстнүүдийн хувьд жишиг байж болохын тулд босч мөн урагш гэрэлтүүл” (С ба Г 115:5).



Тэрбээр та нарт итгэдэг. Тиймээс Тэрбээр та нарыг энэхүү сорилт бэрхшээл ихтэй ч, гайхамшигтай үед улам өндөрт зогсож, улам илүү гэрэлтүүлэх болно гэдэгт найдан, та нарыг дуудсан билээ.”

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Угдорф, “Your Right to Choose the Right,” *New Era*, 2005 оны 8-р сар, 8.

Чиний гэрэл

Чи гэрлэх хэрхэн гэрэлтүүлж чадах вэ? Дараах санаануудыг өдрийн тэмдэглэлдээ бичиж ав.

- Эелдэг дөлгөөн, сайхан сэтгэлтэй, даруухан бай.
- Сүмийн жишгүүдийг чанд сахьж, тэдгээр жишгүүдээр амьдар.
- Амьд сайн мэдээний баяр баясгаланг инээмсэглэлээрээ харуул.
- Сайн мэдээг найз нартайгаа хуваалц.
- Судруудын талаарх гэрчлэлээ хуваалц.

Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмдэмээн нэрлэгдэх ёстой.
5 Үнэнээр би та бүгдэд хэлж байна: Та нарын гэрэл үндэстнүүдийн хувьд “жишиг байж болохын тулд “босч мөн урагш гэрэлтүүл;
6 Мөн Сионы газар нутагт, мөн түүний “гадаснуудад хамтдаа цуглах нь батлан хамгаалалтын тулд, мөн



Үндэстнүүд

“Өнөөдөр Их Эзэний хүмүүс бүх үндэстнүүдийн дунд тархсан Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн

Сүмийн гадаснуудад цугларч байгаагаараа ‘үндэстнүүдийн дундаас’ цуглаж байна. . . . Сионы аюулгүй байдал хийгээд адислалуудыг эрэлхийлж буй хүмүүсийг удирдахын

тулд зөв шударгын гэрэлт цамхаг байхыг Их Эзэн биднээс уриалдаг билээ.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Тодд Кристофферсон, “Come to Zion,” *Лиахона*, 2008 оны 11-р сар, 37.

Туг

Туг бол модны үзүүрт бэхэлсэн далбаа, уриа дуудлага буюу бэлгэдийг илэрхийлсэн зүйл юм. Сургаал ба Гэрээ 45:9-ийг үз.



“Туг баригчид зөв зорилгын тэргүүн эгнээнд алхалдаг. Тэд эрхэм сайхан зүйлийг төлөөлдөг. Аль нэг ялгарах онцлог, зорилго, эв нэдлийг илэрхийлэх

хийн тулд хүмүүс туг барих буюу бусад бэлгэдлүүдийг хэрэглэдэг. . . .

“Бид туг баригчид учраас зүрх сэтгэлээрээ зөв шударга хүмүүст Есүсийг олоход нь туслах ёстой. Бид тугаар зүтээр далладаггүй. . . . Үүний оронд, Есүс Христийн төлөө туг баригч бид Түүний ариун нэрийг өөрсдөдөө хүсэл, талархалтайгаар хүлээн авдаг билээ. Бид Түүний зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө гэрээгээр үүрэг хүлээсэн хүмүүс.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон, “Standards of the Lord’s Standard Bearers,” *Ensign*, 1991 оны 8-р сар, 7.

Редакторын тэмдэглэл: Энэ хуудас бол сонгосон судрын шүлгийн бүх талыг хамарсан тайлбар биш, зөвхөн өөрийн тань судалгааны эхлэх цэг юм.

БУРХАН

ХОЁР ЗАЛБИРАЛД ХОЁУЛАНД НЬ ХАРИУЛСАН ЮМ

Карлос Айван Гармендия Пачеко

Намайг Мексикийн Дуран-год номлогчоор үйлчилж байх үед манай номлолын ерөнхийлөгч номлол даяар “золиослолын долоо хоног” зохион байгуулж билээ. Тэр долоо хоногийн турш онцгой зорилго дэвшүүлж, илүү их хүч чармайлт гарган шаргуу ажиллахыг тэрбээр биднээс хүсэв. Хэрэв бид ийм маягаар золиос хийвэл Их Эзэн биднийг адисалж, бид заах олон хүмүүсийг олно гэдэгт хамтрагч бид хоёр итгэлтэй байлаа.

Гэвч золиослолын долоо хоногт бид тийм ч их амжилт олсонгүй. Заах гэр бүл олдсонгүй болохоор бидний урам хугарав.

Тэр долоо хоногийн дараа нэг өглөө хамтрагч бид хоёр манай бүсийн газрын зургийг харж байлаа. Манай бүс маш том байсан ч бид хамгийн алслагдсан цаад талын хэсэг уруу явах хэрэгтэйг мэдэрч билээ.

Бид тэнд хүрээд Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, аль гудамжаар, аль байшин уруу очих ёстойгоо асуув. Бид хоёр залбирч дуусаад бүх гудамжуудыг харахаар эргэтэл ойрхон нэг төмөр хашаа харагдсанд дээгүүр нь өнгийж харлаа. Гартаа



хогийн шүүр барьсан нэг эмэгтэй нүдээ аниад сууж байх юм.

Миний хамтрагч “Сайн байна уу!” гэсэнд нөгөөх эмэгтэй босч, юу ч болоогүй юм шиг хог шүүрдэж эхэллээ. Тэгэхэд нь бид Есүс Христийн Сүмийн номлогчид байна гэж хэлээд түүнд зориулсан захиас бидэнд байна гэлээ. Тэр эмэгтэй биднийг гэртээ оруулахад бидний хооронд маш сүнслэг яриа өрнөж билээ. Бид түүнд Иосеф Смитийн тухай, тэрээр үнэнийг мэдэхээр залбирахын тулд ойн цоорхой уруу хэрхэн очсон тухай, залбирлынх нь хариуд Бурхан Эцэг, Есүс Христ хоёр түүн дээр хүрч ирсэн тухай ярилаа.

Тэр эмэгтэй бидний үгийг тасалж, “Тэр үнэн. Бурхан бидний

залбиралд хариулдгийг би мэднэ. Та нарыг надтай ярих үед би Их Эзэнд хандан залбирч, Түүний замд ороход намайг удирдах хэн нэгнийг илгээгээч гэж гүйсэн юм. Тэгтэл та хоёр тэр дорхноо хүрч ирсэн” гэлээ.

Бид Сүнснийг мэдэрч, Бурхан биднийг түүн уруу илгээснийг, Түүний хүүхдүүдийн хэнд нь бидний тусламж хэрэгтэй байгааг мэдэхийн тулд бид ч бас тэр дороо залбирснаа гэрчиллээ. Руфина эгч удалгүй баптисм хүртэв. Дараагийн долоо хоногуудад түүний хүүхдүүд, ач зээ нар, бас зарим хөршүүд нь бүгд нийлээд манай бүсэд 20 хөрвөгч баптисм хүртэж билээ. Их Эзэн биднийг Рупина эгч уруу удирдсан бөгөөд тэрээр сайн мэдээг түүний гэр бүл, хөршүүдтэйгээ хуваалцах үүд хаалгыг нээж өгсөн юм.

Хэрэв бид гуйвал Тэнгэрлэг Эцэг бидний итгэлийг сорьж үзсэний дараа биднийг адисалдгийг би мэднэ. Хамтрагч бид хоёр Их Эзэний мундарт эмсэг байж, сайн мэдээний захиасыг сонсоход бэлэн хүмүүсийг олж чадсандаа би баяртай байдаг. Бурхан бидэнд хайртай бөгөөд хэрэв бид хүсэх юм бол Тэр биднийг удирдах болно гэдгийг би мэднэ. ■

ИТГЭЛТЭЙ БАЙ

Ахлагч Жеральд Кауссе

Далын



ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДАВИД СТОКЕР

Би 20 гарсан үедээ Францын нэгэн нэртэй бизнесийн сургуульд орохоор маш хүнд шалгат өгөх хэрэгтэй болж билээ. Хоёр жилийн турш өдөр, шөнөгүй хичээллэсэн дээ. Гэвч би сүм болон институтэд үргэлж явж, Сүмийн ажил үүргүүдээ биелүүлдэг байлаа.

Шалгалтын хамгийн чухал хэсэг нь ярилцлага байв. Нэг сургуульд ярилцлага өгсөнд шалгалтын комиссын гишүүд намайг Сүмийн гишүүн гэдгийг мэдээд ярилцлага амжилтгүй болсон юм.

Тэгээд би орохыг хамгийн их хүсдэг сургуульдаа шалгалт өгсөн юм. Ярилцлага хийгчид нэлээд ярилцсаны дараа хичээлийн бус цагаараа юу хийдэг вэ хэмээн надаас асуулаа. Энэ бол миний хувьд сургуульд орох уу, үгүй юу гэдгийг шийдэх асуулт гэдгийг би мэдэж байлаа. Гэвч би хормын төдийд бодоод, баримталдаг зарчмууддаа үнэнч байх юм шүү гэж шийдэв.

“Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн” гэдгээ хэлээд Сүмд юу хийдэг тухайгаа 15 минут тайлбарлав.

Сургуулийн захирал, “Энэ тухай ярьсанд чинь баярлалаа. Би оюутан байхдаа Нэгдсэн Улсад сурч байсан. Миний хамгийн сайн найз нарын нэг нь мормон байсан юм. Тэр бол агуу эр хүн, бас маш эелдэг найз байлаа. Би Мормончуудыг маш сайн хүмүүс гэж боддог” гэлээ.

Цээжин дотроос бөөн хар юм аваад хаячих шиг болов! Тэр жил би энэ сургуулийн шилдэг элсэгчдийн нэг болсон юм.

Энэ түүхээс би хоёр сургамж авсан. Нэгдүгээрт, бид бусад хүмүүст үзүүлдэг нөлөөгөө дутуу үнэлэх ёсгүй. Хоёрдугаарт, бид зарчмууддаа үргэлж үнэнч байх ёстой. Чадах бүхнээ хийсэн үед Их Эзэн үлдсэн хэсэгт нь танд туслах болно. ■

Чулуу, сум ба Цас

“Их Эзэний Сүнс түүнтэй хамт байв, үүний хэрээр тэд түүнийг чулуунуудаараа бас сумнуудаараа ч онож чадсангүй” (Хиламан 16:2).

Давид Л.Фришнехт

Сургалтын хөтөлбөрийн хэлтэс
Бодит түүхээс сэдэвлэв.

Сургуулиас гэртээ ирэхэд сэтгэл догдлоод байх юу байхав. Заримдаа би математикийн гэрийн даалгаврынхаа тухай бодно, заримдаа гимнастикийн хичээл дээр бүтдээрээ юу хийсэн тухайгаа бодно. Харин заримдаа нэг их юм бодолгүйгээр алхдаг.

Харин тэр өдөр, сэтгэл сэвэлзээд, нэг л өөр байлаа. Заримдаа надтай тоглодог хоёр хөвгүүн—Жош, Маркус хоёр цасан бөмбөгүүд хийж байснаа, над уруу зааж,

“Хөөе, Давид, наашаа хүрээд ир!” гэж Жош инээн, чанга хашгирав. “Чамд нэг юм үзүүлье.”

Маркус бас чанга инээлээ.

Жош, Маркус хоёр надаас ах болохоор сүрхий хол чулуудаж чаддаг байв. Тэд цасан бөмбөгүүдээ миний зам уруу чулуудах хүртэл нэлээд хугацаа хэрэгтэйг би мэдлээ. Тэр хоёр надад ерөнхийдөө сайн байдаг ч, цасан бөмбөг дотроо мөс хийсэн байж магадгүй гэж бодлоо.

Тэдний дайралтыг зогсоох арга чарга юу байдаг билээ гэж бодлоо.

Тэднээс зугтааж гудамжны нөгөө талд гүйж гардаг юм бил үү?

Үгүй ээ, тэр хоёр намайг шоолж, нэр хоч өгөх болно.

Тэдний хажуугаар хурдан гүйж өнгөрөх үү? Үгүй ээ, тэр хоёр надаас илүү хурдан гүйдэг болохоор намайг замын дунд гүйцээд очно.

Би өөрийнхөө шидэх цасан бөмбөлгийг хийх үү? Энэ ч сайн санаа биш л дээ, тэд хоёулаа, би ганцаараа шүү дээ. Бас тэр хоёр толгойн орой дээр байгаа болохоор давуу байрлалтай байлаа. Гэтэл би толгойн ёроолд, ил газар байж байдаг.

Ганцхан арга байгаа нь би тэдний дэргэдүүр тайван алхаж өнгөрөн, цасан бөмбөлгөөр шидэхийг

АН БӨМБӨГ

нь хүлээх л байв. Тэгээд ингэж шийдлээ.

Толгойд ойртож ирэх үед надад нэг санаа төрөв. Хотын хэрмэн дээр зогсоод сайн мэдээг номлосон лемен хүн Самуелыг би саналаа. Түүний үгсэд дургүйцсэн хүмүүс түүн уруу чулуу шидэж, сум харваж байсан.

Их Эзэн Самуелыг чулуу, сумнаас хамгаалсныг би мэднэ. Тиймээс Их Эзэн цасан бөмбөгүүдийг миний хажуугаар өнгөрүүлж болно шүү дээ.

Би чимээгүй залбирал хэлээд, цасан бөмбөгүүдийг миний хажуугаар өнгөрүүлэхийг Тэнгэрлэг эцэгээс гуйлаа. Би Самуел шиг зоригтой, эргэлзэхгүй байх хэрэгтэйгээ мэдэж байлаа. Толгойн тэнд хүрч очих үедээ бүх юм зүгээр өнгөрнө гэдэгт итгэлтэй байлаа.

Яг миний бодож байснаар над уруу цасан бөмбөгүүдээр нүүлгэж эхэллээ. Хоёр цасан бөмбөг миний толгойд их ойрхон хүйтэн салхи татуулан нисч өнгөрөв. Нэлээд хэдэн цасан бөмбөг гарны хажуугаар өнгөрч, нэг хоёрын зэрэг бөмбөг хөлд ойрхон унасан ч нэг нь ч намайг оносонгүй. Нэг нь ч оноогүй гээд бод доо!

Тэр хоёр намайг толгойн дэргэдүүр өнгөрөн харагдахгүй болтол цасан бөмбөгүүдээ шидсээр байсан ч, надад хор учруулж чадаагүй юм. Гэртээ харих үлдсэн замдаа би нэг их баяртай байсангүй, юундаа ч баярлаад байх билээ. Би лемен хүн Самуелын адилаар хамгаалагдсан юм. Залбирал болон Их Эзэнд итгэх итгэлээ ашигласан нь намайг адисалсныг би мэдэж байлаа. ■



Бид итгэлээр гуйж, энэ дагуу үйлдсэн үед залбирал үр өгөөжтэй байдгийг би гэрчилж байна."

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар, "Ask in Faith," Лиахона, 2008 оны 5-р сар, 96.

Мормоны Номын НАЙР

Мормоны Номын үеийн олон хүүхдэд Есүс Христийг харж, Түүний үгсийг сонсох аз жавшаан тохиосон ажээ. Энэ жил та нар Мормоны Номноос долоо хоног бүр уншсанаар “Христийн үгэн дээр найрлаж” (2 Нифай 31:20) болно.

Насанд хүрсэн нэг хүнээр үдээсийг өргүүлж, будах хуудсыг сугалж авахад туслуул. Уншсаныхаа дараа тэр долоо хоногийн дугаартай бүх хоосон зайнуудыг буд. Долоо хоног бүр юу унших тухай зөвлөмжийг 62-р хуудаснаас үз. Чи ганцаараа эсвэл гэрийнхэнтэй хамт уншиж болно.



ЧИМЭГЛЭЛИЙГ СКОТТ ГРЕЕР





“Мормоны Номын найр”-ын төлөө долоо хоног бүр унших зөвлөмж (хуудас 60–61-ийг үз)

ДОЛОО ХОНОГ	УНШИХ ЗҮЙЛ	ДОЛОО ХОНОГ	УНШИХ ЗҮЙЛ
1	Мормоны Номын удиртгал	29	Алма 20:1–28
2	1 Нифай 1:1–3, 18–20; 2:2–4; 3:2–7; 4:1–18	30	Алма 23:6–7, 16–18; 24:1–7, 16–27; 27:2–5, 14, 27–29
3	1 Нифай 8:2, 5–33	31	Алма 30:6–9, 12–14, 31–32, 35–39, 43–45, 49–50, 55–59
4	1 Нифай 16:9–10, 16–19, 23, 26, 28–32; Алма 37:38–46	32	Алма 31:1, 5–7, 12–21, 37–38; 32:1, 5–6
5	1 Нифай 17:8–11, 16–19, 49–55; 18:1–4	33	Алма 32:26–43
6	2 Нифай 2:11–13, 22–27; 4:15–16; 31:5–8, 17–21	34	Алма 37:3, 6, 8–11, 14–15; 43:1–9, 16–17, 43–47; 44:16–20
7	2 Нифай 32:3–9; Иаков 7:1–20	35	Алма 46:1–5, 11–16, 19–20; 48:7– 13, 22–23; 49:25–26, 28
8	Инос 1:1–13	36	Алма 50:25–36; 51:5–6, 11, 13–16, 20–22
9	Мозая 1:9–10, 18; 2:1–2, 5–8, 16–19; 3:17, 19; 4:9–10; 5:15	37	Алма 53:10–21; 56:2–11, 43–48, 55–56
10	Мозая 11:1–2, 20, 27–29; 12:1, 9, 14, 17–19, 35–36; 13:15–24	38	Хиламан 2:2–11; 5:4–13
11	Мозая 17:1–12, 20	39	Хиламан 5:20–50
12	Мозая 18:1–17	40	Хиламан 6:18–23; 7:6–13, 26–29; 8:1, 4, 10, 25–28
13	Мозая 21:1–15, 23–24	41	Хиламан 9:1–24
14	Мозая 21:29–35; 22	42	Хиламан 9:25–39; 10:1–6
15	Мозая 23:1–7, 19–26, 36–39	43	Хиламан 13:1–7; 14:2–8; 16:1–3; 3 Нифай 1:4–9
16	Мозая 24:8–25; 25:1, 14–19	44	3 Нифай 1:10–15, 21–23; 2:1–2; 8:2–7, 23; 9:1–2, 18–22
17	Мозая 27:6–24; Алма 36:11–12, 16–24	45	3 Нифай 11:1–17, 23–26
18	Мозая 27:32–37; 28:1–9	46	3 Нифай 17:1–24
19	Алма 1:2–15; 2:1–9	47	3 Нифай 18:1–9, 19–21, 24, 35–39
20	Алма 2:10–18, 29–31; 5:1, 19, 26–27, 33	48	3 Нифай 19:11–26; 20:1; 27:1–8
21	Алма 6:7–8; 7:9–12; 8:1–22	49	3 Нифай 28:1–9; 4 Нифай 1:1, 15, 23–26; Мормон 1:1, 11–17
22	Алма 8:23–32; 9:1–8, 14–15	50	Мормон 2:1–2, 9, 23–24, 26–27; 3:2–3, 16–22
23	Алма 10:27–32; 11:21–46	51	Ифер 1:1, 33; 2:5, 16–25; 3:1, 4–14
24	Алма 12:1–7; 14:1–17	52	Моронай 10:3–23
25	Алма 14:18–29; 15:1–13		
26	Алма 17:1–3, 12–13, 17–39		
27	Алма 18:1–4, 8–35		
28	Алма 18:40–43; 19:1–2, 8–15, 18–19, 22–33		





Энэ сэдвээр
Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын Ах-
лагч Даллин
Х.Өүкс бодлоо
хуваалцаж
байна.

БИ ЗОРИЛГОДОО ХЭРХЭН ХҮРЧ ЧАДАХ ВЭ?

Бид гагцхүү итгэлтэй л байх ёстой” гэж хэлэв. Бид Бурханд итгэх итгэлтэй байх ёстой. Бид Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлтэй байх ёстой. Мөн бид өөртөө итгэлтэй байхыг хэчнээн их хүсдэг билээ.

Та нар зорилго дэвшүүлж, уг зорилгодоо хүрэхэд шаардлагатай сахилгыг өөртөө төлөвшүүлж чадах юм бол, амьдралдаа тохиолдох ихэнх асуудлыг шийдвэрлэж чадах болно. Өөрчлөлт гаргах зүйлсийг хийхэд эрч хүчээ зориулагтун.

Хэрэв та нарын зорилго зөв байвал, түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө хичээн чармай.

Та нар зохистой бөгөөд бодитой зорилго тавих ур чадварыг хөгжүүлэх хүслийг өөртөө төлөвшүүлэх ёстой.

СОНГОХ ЭРХ

бол өөрсдийнхөө төлөө сонгох бэлэг юм

“Төрсөн өдрийн баяр хүргэе, Жюлиана!” гэж аав хэллээ. Аав нь гялалзсан өнгөтэй цаасанд боож, туузаар ороосон хайрцгийг Жюлианад өгөхөд

Жюлианагийн царай гэрэлтэн мишээв. Тэр ааваасаа бэлэг авсандаа магнай хагартлаа баярлаж, хайрцгийг нээж үзэхийг тэсч ядан хүлээж байлаа.

Чи бэлэг авахдаа Жюлиана шиг сэтгэл догдолдог уу?

Тэнгэрлэг Эцэг бидний хүн нэг бүрд үнэлж баршгүй бэлэг өгсөн юм.

Үүнийг сонгох эрх гэдэг. Сонгох эрх бол бид сонголтыг өөрсдийнхөөрөө хийх чадвар юм.

Биднийг дэлхийд ирэхээс өмнө Сатан хэнд ч ийм эрх олгохыг хүсээгүй юм. Тэр биднийг дэлхийд албадан ирүүлж, өөрийнхөө хүсдэг зүйлийг биднээр хийлгэхийг санаархаж байв. Гэвч өөрсдийнхөөрөө сонголт хийх нь бидний хувьд чухал болохыг Тэнгэрлэг Эцэг мэдэж байлаа. Бид өөрсдийн хийсэн зөв сонголт бүрээрээ Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёрт улам ойр болж өсч хөгждөг. Бид Тэр хоёртой хамт амьдрахаар эргэж очих боломжтой байхын тулд зөв сонголтууд хийдэг байхыг Тэд биднээс хүсэн хүлээдэг.

Бид Хүүхдийн Хэсэгт энэ жил 3С буюу зөвийг сонгоход сонгох эрхээ хэрхэн ашиглах тухай сурч мэдэх болно! ■

Дуунууд ба судрууд

- “Бурханы хүүхэд болохоор,” 2012 оны Хуваалцах цагийн тойм, 28
- 2 Нифай 2:27

Чи яах вэ?

Тухайн өдөр ямар зөв сонголтууд хийснээ орой нь тунгаан бод. Өөрийн хийсэн сайн сонголтуудаас нэгнийх нь тухай зураг зурж, шүлэг бич эсвэл дуу зохио.



ЗС тоглоом

Сонгох эрхийн тухай илүү ихийг мэдэхийн тулд чи энэ тоглоомоор гэрийнхэнтэйгээ тоглож болно. Шоо дөрвөлжинг хайчилж, хатуу цаасан дээр наа. Шоо дөрвөлжинг дээр харуулснаар нугалж, бичигтэй шошгуудыг наагаад шоогоо хатаа.

Гэрийнхэнтэйгээ тойрог болон суу. Нэг хүнээр шоог орхиулж, дээш харсан тал дээрх үгсийг уншуул. Дараах нөхцөлүүдэд өөр өөр сонголт хийж болох тухай ярилц. Сонголт бүрийн дараа юу тохиолдож болох вэ? Шоог хаяулахаар дараагийн хүнд өг.

Хичээл дээр нэг шинэ хөвгүүн хажууд чинь суужээ.
.....
Чи яах вэ?

Жаахан эмэгтэй дүү чинь чамтай болон найз нартай чинь хамт тоглохыг хүсчээ.
.....
Чи яах вэ?

Жеремай гэрийн даалгаврыг чинь хуулья гэж гуйжээ.
.....
Чи яах вэ?

Мартин чамайг ням гарагт кинонд урьжээ.
.....
Чи яах вэ?

Леаг сургууль дээр хүүхдүүд дээрэлхдэг ажээ
.....
Чи яах вэ?

Дүү чинь чамд таагүй ханддаг байж.
.....
Чи яах вэ?

Мормоны Ном Есүс Христийн тухай заадаг

Диане Л.Мангум

Хуучин Гэрээ Есүс Христийн тухай, тэгэхдээ дэлхий дээр амьдрахаар ирснээс өмнөх үеийнх нь тухай бидэнд өгүүлдэг. Түүнийг Иехова гэдэг байв. Иеховаг дагадаг байсан хүмүүсийн тухай Хуучин Гэрээ өгүүлдэг.

Шинэ Гэрээ бол дэлхий дээрх Есүсийн амьдралын тухай бидэнд өгүүлдэг судрын ном юм. Шавь нар нь Түүний амьдрал, сургаалын тухай бичсэн юм.

Иносыг залбирч байхад
Их Эзэний дуу хоолой оюун
санаанд нь орж ирсэн юм.



Жаредын ах Есүс Христийг харсан юм.



Мормоны Ном Есүс Христийн тухай мөн Түүнийг дагасан хүмүүсийн тухай заадаг.

Мормоны Ном Есүсийг төрөхөөс 600 орчим жилийн өмнө Хуучин Гэрээний үед Иерусалимд бичигдэж эхэлжээ. Энэ ном бошиглогч Лихай гэр бүлийнхээ хамт Иерусалимыг орхин, далайн чанад дахь Шинэ Дэлхийг зорин амлагдсан нутаг уруу хэрхэн удирдагдсан тухай өгүүлдэг.

Мормоны Номны бошиглогчид Есүс дэлхийд ирэх болно гэдгийг заадаг байв. Тэд бас наманчилж,


Есүс Христийг дагах нь аз жаргалд хүргэх болно гэдгийг заадаг байлаа.

Есүс Иерусалимд цовдлогдож, амилсны дараа хүмүүст заахын тулд Шинэ Дэлхийд айлчилсан юм. Тэрээр баптисм, ариун ёслолын тухай, бусдыг хэрхэн хайрлах тухай заасан байна. Тэр арванхоёр Төлөөлөгчтэй сүмийг зохион байгуулжээ. Тэрбээр Шинэ Гэрээнд өгүүлдгийн



Лихай Есүс Христийг зүүдэндээ буюу үзэгдэлд харжээ.

Хаан Бенжамин Есүсийн Цагаатгалын тухай өөрийн ард түмэнд заасан юм.



адилаар хүүхдүүдийг цутлуулан, адисалсан юм.

Мормоны Номын бошиглогчид Библийн бошиглогчдын адилаар Есүс Христийн тухай гэрчлэлээ хуваалцдаг байлаа.

Есүс Шинэ Дэлхийд айлчилснаас хойш 400 орчим жилийн дараа амьдарч байсан бошиглогч Моронай бол Мормоны Номын сүүлчийн бошиглогч юм. Мормоны Номыг уншсан хүн бүр

итгэлтэйгээр залбирах юм бол энэ ном үнэн гэдгийг мэдэж чадна гэж Моронай нас барахынхаа өмнө бичсэн билээ. Моронай хүн бүрийг “Христэд ирэхийг” (Моронай 10:32) урьсан юм.

Өнөөдөр хүүхдүүд Мормоны Ном үнэн бөгөөд Есүс Христ бол өөрсдийнх нь Аврагч гэдэг гэрчлэлтэй болохын тулд бас залбирч болно. ■

НОМХОН ДАЛАЙН

ЧАНАДАД

НАЙЗ НӨХӨДТЭЙ БОЛСОН НЬ

Жейн Хансен Лассетер

Бригам Янгийн Их Сургуулийн хэсэг оюутан Тонга уруу явахад бэлэн болоод байлаа. Юта болон Тонгагийн хүүхдүүд найз нөхөд болбол тэнд хөгжилтэй сайхан байна даа гэж тэд бодсон гэнэ.

Тиймээс эдгээр оюутнууд Ютагийн Прово дахь Өүк Хиллсийн есдүгээр тойргийн Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдээс Тонгагийн хүүхдүүдэд зориулж зураг зураач гэж хүсчээ. Тэнд бас хүүхдүүдийн гэрэл зургийг авсан гэнэ.

Оюутнууд Тонгад ирээд Нейа-фугийн гуравдугаар тойрогт хуваагдах цагийг зохион байгуулахад нь хүүхдүүдэд тусалж, хүүхэд бүрд нэг зураг бас Ютад амьдардаг нэг хүүхдийн гэрэл зургийг өгсөн гэнэ. Хүүхдүүд Юта дахь шинэ найз нарынхаа тухай мэдээд сэтгэл нь их догдолж,

Юта дахь найз нартаа зориулж зураг зурсан аж. Тэдний зарим нь өөрсдийнхөө тухай, Тонга дахь хүмүүсийн амьдралын тухай захиа бичсэн гэнэ. Захидлуу-даа заримыг нь

англиар, бусдыг нь тонго хэлээр бичжээ. Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч нь тонга хэлээр бичсэн захидлыг англи хэлээр орчуулсан гэнэ. Оюутнууд хүүхдүүдийн гэрэл зургийг авчээ.

Нэг хөвгүүн, “Би рагби тоглодог. Тонга маш халуун орон” гэж бичжээ. “Чиний зураг надад их таалагдлаа. Чи их гоё харагдаж байна. Би бас чам шиг дуулах дуртай” гэж нэг охин бичсэн ажээ. Өөр нэг хүүхэд Хүүхдийн Хэсгийн хээ тухай бичиж, хайраа илэрхийлэн: “Өнөөдөр бидний хичээл бо-шиглогчдын тухай байлаа. Би чамд их хайртай шүү!” гэжээ. ■



Тэр **тэнд** бий

Роземари М.Виксом

Хүүхдийн Хэсгийн ерөнхий ерөнхийлөгч



*“Хүчийг бидэнд өгөөсэй
хэмээн бид сэтгэл оюу-
наа Бурханд хандсан
залбиралд юүлсэн болой”
(Алма 58:10).*

Манай хөвгүүдийн нэг нь 11-тэй байхад нэг өглөө сэртэл толгой нь учиргүй их өвдөж байлаа. Хүү маань сургуульд явахаас цааргалж байгаа юм болов уу гэж эхлээд бодсон ч тэр их халуурч байгааг тэр даруй мэдлээ. Түүнийг эмчид аваачиж үзүүлсэн даруйд биднийг эмнэлэгт яаралтай хэвт гэв. Эмнэлэг дээр түүнд нуруу нугасны менингит гэсэн хүнд өвчний онош тавих нь тэр.

Өвчний байдал улам дордож, хүү минь ухаан алдав. Эмч намайг өрөөнөөс гарна уу гэв. Би коридорт гараад, айсандаа уйллаа. Танихгүй нэг эмэгтэй миний мөрөн дээр гараа

тавилаа. Би Тэнгэрлэг Эцэгт хандан хүүд минь туслаач, хүүг минь хүнд өвчнөөс нь салгаач хэмээн гуйж, чангаар залбирлаа. Надад агуу их тайвшралт мэдрэгдсэнийг би санадаг.

Хүүд минь мэс засал хийхэд эдгэртлээ олон хоног болж билээ. Өнөөдөр тэр эрүүл чийрэг эр хүн, гэрлэж, хоёр хөөрхөн охины эцэг болоод байна. Энэ явдал миний хувьд залбирлын хүчний жишээ болсон юм.

“Хүүхдийн залибрал” гэдэг

нэртэй Хүүхдийн Хэсгийн дуу байдаг. “Тэнгэрлэг Эцэг минь, Та үнэхээр тэнд байдаг уу? Хүүхэд бүрийн залбирлыг Та сонсож, хариулдаг уу?” гэж энэ дуунд асуусан байдаг. (*Children's Songbook*, 12).

Мэдээж хэрэг хариулт нь: Тийм ээ, Тэр сонсож, хариулдаг.

Тэнгэрлэг Эцэг үнэхээр амьд гэж үү хэмээн бодсон үедээ өвдөг сөгдөн, “Тэнгэрлэг Эцэг минь ээ, Та үнэхээр тэнд байдаг уу? Би дэлхийд ирэхээсээ өмнө үнэхээр Тантай хамт амьдарч байсан уу? Тантай дахин хамт амьдрахаар эргэж очиж болох уу?” гэж асуу.

Тэр залбиралд чинь хариулж, Тэнгэрт байдгаа чамд мэдүүлнэ. Чи хэзээ ч ганцаараа биш. Тэр бидэнд байнга хэрэгтэй. Тэр Тэнгэрт байдаг. ■



Зөв хувцас

Сара Чау

Бодит түүхээс сэдэвлэв.

“Чи итгэгч хүмүүст үлгэр дууриал бол” (1 Тимот 4:12).

1. Ээж нь Аннад шинэ хувцас авч өгөхөөр дэлгүүр уруу дагуулж явжээ.

Үүнийг авбал ямар вэ?

Үгүй ээ, баярлалаа.



2. Цэцгэн хээтэй шар эсвэл толбон хээтэй улаан палааж зүгээр юм биш үү?

Чи шар, улаан өнгөнд дуртай шүү дээ. Үүнээс өөр юу авмаар байна?



3. Номлогч шиг харагдахын тулд энэ палаажнуудын нэгийг авмаар байна.

Тэг л дээ. Харин чамд яг таарах хэмжээтэйг нь олъя.



4. Тойргийнх нь хоёр систер номлогч Анна таалагддаг байлаа. Тэр сүм дээр түүнтэй гар барьдаг байв. Түүнийг тэдэнтэй гудамжинд тааралдаад гараараа даллахад тэд инээм-сэглэн, хоол идэхээр ирэхдээ гэр бүлийнх нь төлөө залбирдаг байлаа.



5. Нэг ням гарагт Анна номлогчдод шинэ палаажаа үзүүлэх гэж тэсч ядан хүлээж байлаа. Анна номлогчдыг сүм дээр хараад тэдний ойролцоо эргэлдэж эхлэв.



Би одоо яг та хоёр шиг харагдаж байгаа биз!

6. Чи үнэхээр бид хоёр шиг харагдаж байна.

Чи зөвхөн номлогч шиг харагдаад зогсохгүй, бүр номлогч болсон байна!



7. Чамайг долоо хоногийн турш бидний төлөө залбирсан гэж ээж чинь бидэнд ярьсан. Тэгээд хар л даа. Бид нэг хүнийг өнөөдөр сүмд авчирсан. Залбирал чинь бидэнд тусалмаа.

Номлогч Анна, баярласан шүү.



Би одоо номлогч байж чадна!

Хикари Лофтус, Хилари Уоткинс Лемон нар


Анна номлогчдын үлгэр жишээг дагахыг хичээдэг. Одоо номлогч болоход өөрт чинь туслах сонголтуудыг хийхийн тулд дараах заавруудыг дага.

Дараах зүйлсийг олж бэлтгэ: нэг шоо эсвэл 1-6 хүртэл дугаарласан зургаан цаасыг жижиг цаасан цүнхэнд хийнэ; хүн бүрд нэг

зоосон мөнгө, хатаасан вандуй эсвэл ямар нэг өөр жижиг зүйл.

Яаж тоглох вэ? Тоглогч бүр тоглоомонд оролцохын тулд дээрх зүйлсээс нэгийг авна. Ээлжлэн шоог орхих буюу цүнхнээс дугаарыг гаргаж, орхисон шоон дээрх тоо эсвэл цүнхнээс гаргаж ирсэн цаасан дээрх

дугаарын тоогоор зоос буюу хатаасан вандуйг урагш ахиулна. Хэрэв номлогч ямар нэг юм хийх хэрэгтэйг заасан шугаман дээр зоос буюу вандуй чинь очвол цааш нэг нүд нүү. Номлогчид хүлээж байгаа барианы шугамыг хүн бүр давтал тоглоомыг ээлжлэн үргэлжлүүл!



ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Даруухан хувцаслах нь Тэнгэрлэг Эцгээ болон өөрийгөө хүндлэн дээдэлж буйг хэрхэн харуулдаг тухай хүүхдүүдээ ярьж өг. Номлогчид яагаад даруухан хувцаслагдгийг хүүхдүүдээс асуу.

Номлолын ажлын тухай гэрчлэлээ хүүхдүүдтэйгээ хуваалц. Та өөрийн хөрвөлтийн түүхийг хуваалцаж, номлолын ажил хийсэн туршлагынхаа тухай эсвэл номлолын ажил өөрт чинь яагаад чухал болох тухай ярьж болно.

Сүмийн цуглааны үеэр хүндэтгэлтэй байв.

Угаасан юмсаа хурааж эвхэхэд нь чи ээждээ тусалжээ.

Номлогчдын төлөө залбирахаа санажээ.

Сайн номлогч болсны тань төлөө баярлалаа!

Ариун ёслолын үеэр Аврагчийн тухай бодож байв.

БАРИА

Залуучуудын төв нь өсвөр үеийнхнийг төлөвшүүлдэг газар юм

Степани Жейн Жонсон

Сүмийн сэтгүүлүүд

Залууст зориулсан Сүмийн төвүүд нь дэлхийн уруу таталтуудаас өсвөр үеийнхнийг хамгаалаад зогсохгүй, ертөнцийг өөрчлөх Сүмийн ирээдүйн удирдагчдыг бэлтгэхэд зориулагдсан юм.

Залууст зориулсан төвүүдэд (голдуу Европын орнуудад байдаг) институт хичээллэхээс гадна өсвөр үеийнхэн шашны ангиудад хичээллэх, гэрийн даалгавараа хийх, ширээний теннис тоглох, хоол хийх мөн судраас хуваалцах зэрэг үйл ажиллагаануудыг явуулдаг.

Залуусаар дамжуулан Сүмийг хөгжүүлэх нь

2003 оны сүүлээр Данийн Копенгаг, Германы Хамбург, Лейпциг, Берлин хотуудад залууст зориулсан дөрвөн төв нээгдсэн юм. 2004 онд Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910-2008) Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Л.Том Перрид Төв Европыг хариуцуулан даалгасан бөгөөд Ахлагч Перри залуучуудын идэвх санаачлагыг хөхүүлэн дэмжсэн.

Одоо Европд санваарын удирдагчаар үйлчилж байгаа хүмүүсийн ихэнх нь тэр үед 30-аас доош насны залуучууд байсан хэмээн Европын институт семинарыг хариуцсан захирлын туслах Ерик Псота хэлж байна.

Эрик Псота мөн “Европ дахь Сүмийн өсөлтөд 18-30 насныхан чухал үүрэгтэй байх болно хэмээх Ахлагч Перригийн хүлээн авсан илчлэлт нь Европын залуучууд болон бүх санваарын удирдагч нарт гайхамшигтай нөлөө үзүүлсэн юм. Энэхүү илчлэлт нь залуучууд Сүмийн өсөлт хөгжилтөнд оруулах үүрэг хариуцлагаа ойлгоход тусалдаг учир одоо ч гэсэн чухал хэвээр байгаа.” хэмээн үргэлжлүүлэн хэлэв.

Одоо Европд залуучуудын 140 төв байдаг

бөгөөд 30-г шинээр нэмэн барьж байна. Эдгээр төвд өсвөр үеийнхнийг дэлхий даяар сайн мэдээг тараахад бэлтгэдэг юм.

Норвеги улсад Хаант улс болон нөхөрлөлийг хөгжүүлсэн нь

Залуучуудыг Бурханы Хаант улс байгуулахад сургадаг олон төвүүдийн нэг нь Норвегийн Осло хотын залуучуудын төв юм. Францаас ирсэн Матилда Гуилламет эгчийн жишээг аваад үзье. Гуилламет эгчийг найз нь түүнийг сайн мэдээнээс суралцахыг урьсан учир тэр 2009 онд Парис хотноо номлогч нараас хичээл авч эхэлжээ.

Гуилламет эгч 2010 онд баптисм хүртсэнийхээ дараа нэг жилийн хугацаатай Норвеги уруу нүүжээ. Тэнд очоод залуучуудын төвд явснаар түүний гэрчлэл ихэд өсчээ.

“Тэрээсээ хол амьдарч байхад маань залуучуудын төв яг гэр шиг минь санагддаг байв. Дотуур байранд байснаас тэнд цагийг өнгөрөөх нь хамаагүй сайхан байдаг. Тус төвд үйлчилдэг номлогч хос яг ээж аав шиг минь болсон бөгөөд өөр олон гайхалтай хүмүүс надад зөвлөгөө өгч, намайг тайвшруулдаг байсан. Гэр бүлийнхнээсээ би ганцаараа Сүмийн гишүүн тул Парис болон Осло хотод номлогч хосуудтай сайн мэдээний тухай ярилцдаг байлаа” гэж Гуилламет эгч ярилаа.

Сэм Баснет 2009 онд баптисм хийлгэсэн бөгөөд мөн л гэр бүлээсээ ганцаараа гишүүн юм. Ослогийн залуучуудын төвд номлолын ажил хийж байсан нь Непалд байдаг хамаатан садангийндаа зочлох үеэрээ тэдэнтэй сайн мэдээг хуваалцахад нь тус болжээ. Тэрээр гэрийнхэндээ санваар болон Мормоны Номын тухай ярьж өгсөн бөгөөд



**Энэ нь өсвөр
үеийнхнийг
сайн мэдээ-
гээр дэлхийд
нөлөөлөхөд
бэлтгэдэг
газар юм.**

Ослод байхдаа номлогч нартай хамт бусдад энэ тухай заадаг байжээ.

“Манай гэрийнхэн ‘урьдны Сэм’ болон ‘өөрчлөгдсөн Сэм’ хоёрын ялгааг харсан бөгөөд миний мэдэрсэн зүйлийг мэдрэхийг хүсч байлаа. Урьд нь би ямар ч итгэл найдваргүй, гутранги үзэлтэй байлаа. Баптисм хийлгэснийхээ дараа би залуучуудын төвд очдог болсон ба тэнд очсоноор илүү өөдрөг үзэлтэй болсон.”

Залуучуудын төвд ирж урам зориг авч, эрч хүчийг мэдэрсэн нь ганц Баснет ах биш юм. Шотландаас ирсэн Бенжамин Керр сүүлийн хоёр зуныг Ослод өнгөрүүлсэн ба тэндхийн залуучуудын төвийг өөрт нь юу хамгийн чухал болохыг сануулдаг газар хэмээн хэллээ.

“Залуучуудын төв бол миний хувьд энэ дэлхийгээс хоргодох газар маань юм. Энд би тайван амгалан, аюулгүй байдлыг мэдрдэг. Намайг хамгийн ихээр урамшуулан дэмждэг үйл явдлууд энд болдог. Ялангуяа гэр бүлийн үдэш мөн өөрсдийн санаа зовж байгаа зүйл болон хэцүү асуудлуудынхаа талаар ярилцах зэрэг нь их сайхан байдаг. Эдгээр үйл явдал нь надад сайн мэдээний энгийн

зарчмуудын чухлыг сануулдаг юм” гэж Керр ах хэллээ.

Залуучуудыг хөгжүүлж, ирээдүйн удирдагчдыг бэлтгэх нь

Сайн мэдээнд найз нар болон гэр бүлийнхнээ хүчирхэгжүүлэхэд нь залуучуудад туслахаас илүү зүйлийг залуучуудын төвд хийдэг. Залуучуудын төвд удирдагчдыг төлөвшүүлдэг. Энд ганц бие насанд хүрэгсэд удирдлагын зөвлөлд ээлжээр үйлчилж, үйл ажиллагаа болон хичээлүүдийг төлөвлөдөг юм.

Угандагаас ирсэн боловч одоо Норвеги улсын иргэн болсон Барбара Матову эгч залуучуудын төвд “Бүх хүүхдүүдээ хайрлах Бурханы хайрыг” мэдэрчээ. Сүмийн зохион байгуулалтын талаарх миний гэрчлэл нэмэгдсэн. Бурханы Хаант улсыг ганцаараа бус харин олноороо нэгдэн нийлж байгуулдаг болохыг би эндээс сурсан.”

Энд залуучууд ирээдүйд хүлээн авах Сүмийн дуудлагуудад бэлтгэгдээд зогсохгүй сайн хань, сайн эцэг эх болохоор бэлтгэдэг юм. Тэд зөвхөн нийгмээ бус гэр орноо өөрчлөхөд ч мөн бэлтгэгдэх болно.

“—Тэвчээр, харилцан яриа, бусдыг удирдах чадвар мөн Ариун Сүнсний өдөлтийг дагах зэрэг ганц бие насанд хүрэгсдийн зөвлөлд суралцдаг удирдах зарчмууд нь ганц бие насанд хүрэгсэдээс гадна эцэг эх нарт хэрэг болдог” гэж эхнэртэйгээ хамт Норвегийн Трондхайм хотын номлолын төвд үйлчилсэн Жералд Соренсон ах хэлжээ.

Залуучуудын төвд дэлхийн өсөн нэмэгдэж буй нүглүүдийн эсрэг тэмцэх Сүмийн ирээдүйн удирдагчдыг илүү ихээр бэлтгэх болно.

“Залуучуудын төвд ирдэг хүмүүс нь сайн мэдээг зөвхөн онолын хувьд сураад зогсохгүй сүмийн бус найз нөхөддөө үйлчилж, тэдэнтэй сайн мэдээг хуваалцах зарчмуудыг хэрэгжүүлдэг. Залуучуудын төвд сайн бэлтгэгдсэн шинэ үеийнхнийг урам зоригтойгоор, мөнхийн зорилготойгоор Их Эзэнд үйлчлэхэд нь бэлтгэдэг.” ■

Английн болон Бразил гэгээнтнүүдийн үйлчлэлийн өдрүүд

Өнгөрсөн 4-р сард Тэргүүн Зөвлөлөөс энэ жил Сүмийн гишүүдийг үйлчлэлд илүү идэвхтэй оролцохыг уриалснаас хойш дэлхий дахины Гэгээнтнүүд үйлчлэлд илүү идэвхтэй оролцдог болоо. Англи болон Бразилийн Сүмийн нэгжүүд өөрсдийн орныхоо бусад гишүүдтэй хүчээ нэгтгэн хамтран үйлчиллээ.

Англи

2011 оны 9-р сарын 5-нд Тотенхам Маршес дахь Тусламжийн гар хөтөлбөрт Английн 11 гадасныхан бүсийн ерөнхийлөгч, Далын гишүүн Ерик В.Копискитэй оролцлоо.

Энэ үйл ажиллагаа нь Сүмийн халамжийн хөтөлбөрийн 75 жилийн ой болон Лондон хотын 2011 оны их цэвэрлэгээний аяныг эхлүүлэх үйл явдалтай давхцсан юм. Гишүүд хотын захиргааны ажилчидтай хамтран таван цагийн турш зэрлэг зулгааж, цэцгийн мандал суулгаж, илүү ургасан мод сөөг тайрч, Лий Валли цэцэрлэгийн хогийг цэвэрлэлээ.

Мөн тэр өдөр Лондон хотын бусад бүсийн гишүүд Тусламжийн гар хөтөлбөрт хамрагдаж Хавен Хоуз болон Ричард Хоузын хүүхдийн эмнэлэгүүдэд үйлчлэл үзүүлээ.

Стратфорд тойргийн 18 гишүүн Ричард Хоузын хүүхдийн эмнэлэгт очиж эмнэлэгийн оффисыг будаж, зэрлэг түүж, гаднах талбайг шүүрдэж, багажнуудыг засч янзаллаа. Ричард Хоузын үйлчилгээ хариуцсан менежер: “Манай эмнэлгийн хувьд энэ Сүмийнхэнтэй анх удаа хамтран ажиллаж байна.

Сайн дурынхан энэ ажлуудыг баяр хөөртэйгөөр хийсэн нь үнэхээр сайхан байлаа. Зам дагуу шүүрдэх зэрэг энгийн үүрэг даалгаврыг ч тэд маш сайн хийлээ” хэмээн хэлсэн.

Сүүлийн хэдэн сарын хугацаанд Их Британи болон Умард Ирландын Сүмийн

2011 оны 9-р сарын 5-нд Английн 11 тойргийн гишүүд Лондон хотын 3-н дүүрэгт үйлчлэл хийлээ.

Зургийг Линдси Флигс



гишүүд улс даяар зохион байгуулагдсан 10 гаруй үйлчлэлийн хөтөлбөрт оролцлоо.

Бразил

Олон нийтийн үйлчлэл хийж, гамшигт нэрвэгдсэн хүмүүст тусалдаг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Мормоны Тусламжийн гар хөтөлбөрийн 12 жилийн ойд зориулж 2011 оны 7-р сарын 30-нд шар хантааз өмссөн гишүүд Бразил даяар хийсэн хэдэн зуун үйлчлэлд оролцлоо.

Мормон Тусламжийн гар (*Mãos que Ajudam*) нь найз нөхөд болон хөршүүдэд Сүмийн хүмүүнлэгийн тусламжийг үзүүлэх үүднээс анх Бразилд үүссэн. Харин одоо үүнийг жил бүр тэмдэглэн явуулдаг болсон.

Латин Америкийн хамгийн том, олон хүн амтай уг улсад энэ жилийн үйлчлэлийн өдрөөр 120,000 хүмүүс болон хүүхдүүд цугларан, инээд баясал, дуу хууртайгаар гудамж талбай шүүрдэн, сургуулиудыг цэвэрлэж, байшин барилга засварлаж, цэцэрлэгүүдийг тордож үйлчлэлийн ажилд оролцлоо. Сүмийн гишүүд бүх нийтэд тустай үйлчлэлд иргэдтэй хамтран оролцлоо.

Бело Хоризонте, Ресифе болон Бахиад 6000 гаруй сайн дурынхан халуун хумхаа өвчтэй хүмүүст туслалаа. Рио де Жанейро хотод сайн дурынхан улсын дунд сургууль болон цэцэрлэгүүдийг цэвэрлэв. Порто Алегре хотод 1500

сайн дурынхан сургуулиудыг цэвэрлэж мөн хар тамхины эсрэг лекцүүдэд оролцов.

Үйлчлэлийн өдрөөс хоёр сар гаруйн өмнө 500 гаруй сайн дурынхан хандивын хоол хүнс цуглуулан үүнийгээ 7-р сарын 30-нд Сан Хосе хотын 175 гачигдалтай өрхүүдэд тараан өглөө.

Блүменау хотын Сүмийн гишүүд 136 кг хоол хүнсийг *Casa de Apoio às Crianças Portadoras de Mielomeningocele e Neoplasia* (Нуруу нугасны гэмтэл ба хавдартай хүүхдүүдийн эмнэлэгт) хандивлалаа. Мөн сайн дурынхан хоол хүнс нөөцлөх энгийн аргуудын талаар байгуулгуудад заалаа.

“Хоол хүнсээ чийгэнд муутгахгүй, зооринд хэрхэн хадгалах аргыг сурлаа” гэж нийгмийн ажилтан Ж.Бакес Риоф хэллээ. ■

Редакторын тэмдэглэл:

lds.org/service/welfare-75th-anniversary вэб хуудсанд үйлчлэлийн өдрийн тухай туршлагаасаа хуваалц.

ШИНЭЧИЛ

2011оны 10-р сарын *Лиакхона* дээр тавигдсан 73-р хуудасны зургийг Меган Толман авав. ■

2012 оны Мючелийн сэдэв зарлагдлаа: “Босч мөн урагш гэрэлтүүл”

2012 оны Мючелийн сэдэв бол “Та нарын гэрэл үндэстнүүдийн хувьд жишиг байж болохын тулд босч мөн урагш гэрэлтүүл” (С ба Г 115:5).

1838 онд Миссурийн Фар Вестэд энэхүү илчлэлтийг Бошиглогч Иосеф Смитэд өгсөн бөгөөд үүнийг Сүмийн тэргүүлэх ажилтнуудад зориулж илчилжээ. Харин Мючелийн сэдвийн хувьд энэ нь 12-18 насны өсвөр үеийнхэнд болон бүх л Сүмийн гишүүдэд хамааралтай.

Энэхүү сэдвийг Мючелийн нээлт, ариун ёслолын цуглаанд уг хэлэх залуучуудын ярианы сэдэв болгож мөн зугаалга, залуучуудын чуулган, онцгой цугларалт зэрэг үйл ажиллагааны гол хэсэг байлгах хэрэгтэй. Мөн бүжиг, хөгжим, жүжиг болон бусад соёлын үйл ажиллагаанд гол санаа болгон хэрэглэж болно.

Сүмийн удирдагчид, орон нутгийн залуучуудын удирдагчид Мючелийн сэдвийг *Strength of Youth Media 2012: Arise and Shine Forth*, DVD-г үзүүлэн танилцуулахыг хүсч байна. Уг DVD-г 2011оны 11-р сард нэгжүүдэд илгээх болно.

Энэ DVD-г чуулгын цуглаанууд, хичээлүүдэд, залуучуудын чуулга болон залуучуудын бусад үйл ажиллагаануудад ирэх жилийн турш ашиглаж болно. Энэ DVD нь кантонез, англи, франц, герман, итали, япон, солонгос, мандарин, португали, орос болон испани хэл дээр гарна.

Нэмэлт материалууд *Лиакхона* болон *New Era* сэтгүүл дээр гарах бөгөөд 2012 оны эхээр LDS.org вэб хуудсанд тавигдана. ■



Сан Салвадор ариун сүм нь дэлхий дээр үйл ажиллагаагаа явуулж буй 135 дахь, Төв Америкийн 4 дэх ариун сүм болж байна.

Дэлхий дахины цуглааны байруудад интернет тавьж эхэллээ

Сүм дэлхий даяарх цуглааны байруудын 85-н хувьд нь өндөр хурдтай, утасгүй интернет тавихаар төлөвлөж байна.

Гишүүд цуглааны байрнаас Сүмийн ажил эрхлэлт ба гэр бүлийн түүхийн ажлын вэб хуудас руу орж; Сүмийн удирдагч нар бүртгэл хөтөлж, номлолд явах хүсэлтийг илгээж, удирдагчдын шууд дамжуулах сургалтанд оролцож; багш нар интернет дээр тавьсан Сүмийн мэдээллийг өөрсдийн хичээлдээ ашиглах боломжтой болно.

Сүм Зүүн Африкийн өлсгөлөнд нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэв

Зүүн Африкт болж байгаа ганд нэрвэгдсэн, яаралтай тусламж үзүүлэх шаардлагтай 11,5 сая хүнд Сүм хэд хэдэн байгууллагатай хамтран ажиллаж, өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүст хоол хүнс, эм тариа, ариун цэврийн хэрэгсэл болон хоргодох байрны тусламжийг үзүүлж байна.

Тэдэнд туслахыг хүссэн гишүүд хүмүүнлэгийн санд хандив өргөж болно.

Шинэ номлогчийн талбар дээрх сургалт нь НБТ-н сургалтын үргэлжлэл юм

2011 оны 8-р сард номлогч нарыг бэлтгэх төвөөс дөнгөж гарсан номлогч нар 12 долоо хоногийн нэмэлт сургалтыг хийхээр болсон.

Провогийн НБТ-н захирал Ричард Хейтон “талбар дээрх сургалт бол шинэ зүйл биш харин НБТ-н сургалтын үргэлжлэл юм” хэмээн хэллээ.

“Эхний 12 долоо хоног гарын авлага нь сургагч болон шинэ номлогчийг эхний 12 долоо хоногт хамгийн их хэрэг болох *Миний сайн мэдээг номло* ном руу хандуулдаг. Энэ бол аль болох хурдан Их Эзэний сайн үйлчлэгч болоход туслах . . . газрын зураг юм” гэх тэрээр хэллээ.

Номлолын ерөнхийлөгчид шинэ номлогч нарт зориулсан талбар дээрх сургалтын материалуудыг ашиглаж эхэллээ. Энэхүү материалд сургалтын гурван баримт бичиг мөн шинэ хамтрагчдын сурах видео бичлэгүүд багтсан. ■

news.lds.org-оос эдгээр болон өөр олон мэдээг уншаарай.

Сан Салвадор ариун сүмийг онцгойлон адислав

2011 оны 8-р сарын 21-ний ням гарагт Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөх Ерөнхийлөгч Хенри Б.Айринг Сан Салвадор ариун сүмийг онцгойлон адислалаа. Энэ ариун сүм нь дэлхийн 135 дахь харин Төв Америкийн 4 дэх ариун сүм боллоо.

8-р сарын 20-ны бямба гарагт болсон уг орны баялаг түүхийг дуу болон бүжгээр үзүүлсэн урлагийн тоглолтонд 16000 орчим хүн оролцов.

Create.LDS.org гишүүдийг аудио файлаа оруулахыг уриалж байна.

Мормон радио суваг болон Сүмийн бусад мэдээллийн хэрэгслээр ашиглахад зориулж дуу хөгжим болон бусад аудио файлуудаа create.lds.org илгээхийг Сүмийн гишүүдэд уриалж байна. Гишүүд энэхүү урилгын талаар дэлгэрэнгүй мэдээллийг news.lds.org-оос (“create.lds.org” гэж хайгаарай) уншиж болно. Мөн өөрсдийн файлаа create.lds.org хаягаар нэмж оруулаарай.

2012 оны Хуваалцах цагийн төлөвлөгөө онлайн дээр тавигдлаа

Хүүхдийн Хэсгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлөөс 2012 оны Хуваалцах цагийн сэдвийг “Зөвийг сонго” гэж зарлалаа. Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчид LDS.org-н **Serving in the Church** хэсгийн **“Primary”** гэсэн хэсгээс төлөвлөгөөг үзэж болно.

Урьд нь бид 7-р сард нэгжүүдэд арав арван хувь төлөвлөгөөг илгээдэг байсан. Харин одоо онлайнаас авах боломжтой болсон тул 7 сард илгээхээ больж, жил тутмын сургалтын төлөвлөгөөний захиалгатай хамт бүх нэгжүүдэд гурав гурван хувийг илгээж байх боллоо. ■

Хүчтэй туслагч

Би Лиахона сэтгүүлийг үргэлж захиалдаг байсан ч идэвхгүй байх үедээ сэтгүүлээ тогтмол уншдаггүй байлаа. Нэг өдөр би шүүгээгээ цэвэрлэж байгаад уг сэтгүүлийн хэдэн маш хуучин дугааруудыг олсон юм. Тэдгээрийг эргүүлж байтал нэг түүх миний анхаарлыг татлаа. Энэ түүх хэдэн жил Сүмдээ идэвхгүй байсан эгчийн тухай байлаа. Тэр буцаж очихыг хүсдэггүй байв. Гэвч сүнсээр удирдуулсан бишоп нь түүнд дуудлага өгч тэр эгч муу зуршлуудаасаа салж, сүмдээ эргэн иржээ. Энэ түүх надад их хүчтэйгээр нөлөөлсөн бөгөөд буцаад идэвхтэй болох анхны алхам маань болсон юм. Үүнээс хойш олон жил өнгөрсөн ч Лиахона манай гэрийнхний хувьд хүчтэй туслагч маань хэвээр байна. Энэ сэтгүүлийн зөвлөгөө, удирдамж, гэрчлэлүүд нь бидэнд өдөр бүр тусладаг.

Моема Лима Саллес Бродел, Бразил

Хүүхдүүд болон насанд хүрэгсдэд зориулсан түүхүүд

Би бяцхан хүүтэй бөгөөд Лиахона сэтгүүлийн хүүхдэд зориулсан түүхүүдээс орой болгон хүүдээ унтахаас нь өмнө уншиж өгдөг юм. Сэтгүүлийн түүхүүдээс унших нь надад ч гэсэн адислал болдог. Би эндээс Есүс Христ, Бошиглогч Иосеф Смит, итгэл бишрэл, залбирал болон бусад олон зүйлсийн талаар сурдаг. Сэтгүүлээ үргэлж сайн уншиж байгаарай!

Силвиа Руйз де Миноз, Эквадор

Санал зөвлөмжөө liahona@ldschurch.org хаягаар илгээн үү. Ирүүлсэн материалуудаас нэмж хасан, тодруулахын тулд хянан засварласж болно. ■

Энэ дугаарт гэр бүлийн үдэшт ашиглахуйц өгүүлэл, үйл ажиллагаанууд байгаа болно. Зарим жишээг доор харуулав.



“Бидний өдөр тутмын адислалд Бурханы гар оролцогийг таниж мэдэх,”

хуу 24: Их Эзэний залбирлыг уншиж (Матай 6:9–13) мөн “өдөр тутмын минь талхыг энэ өдөр бидэнд өгөөч” гэдэг нь юу гэсэн утгатай вэ гэж гэр бүлийн гишүүдээсээ асуу. Үүний дараа “өдөр тутмын талх” гэсэн сэдэвтэй Ахлагч Кристофферсоны өгүүлэлийн эхний хэсгийг дүгнэн ярилц. Есүс Христ бол Амьдралын Талх гэдэг гэрчлэлээ хуваалц.

“Жеорж Алберт Смит: Тэрээр Өөрийн заасан сургаалийн дагуу амьдарсан”

хуу 32: “Хэрэв бидэнд Есүс Христийн сайн мэдээний тухай гэрчлэл үнэхээр байвал, энэ нь бидний амьдрал дээр харагдах болно” гэдэгт Ерөнхийлөгч Жеорж Алберт Смит итгэдэг байв. Энэхүү өгүүллийн талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилц. Мөн та бусадтай хэрхэн сайхан харьцах талаар Ерөнхийлөгч Смитийн жишээнээс юу сурсан болохыг нь тэднээс асууж болно. Яаж бусдад илүү сайхан сэтгэлээр хандах вэ? гэж асуу.

“Дээшээ хар,” хуу 42: Ахлагч Кукд залуу номлогч байхад нь тохиолдсон явдлын тухай

хуваалц. Тэгээд уг өгүүллийн талаар дүгнэн ярилц. Яавал бусад хүмүүс бус харин Тэнгэрлэг Эцэг юу гэж бодох бол гэдэгт илүү анхаарч болох вэ? гэж гэр бүлийн гишүүдээсээ асуу. Та 1 Семеул 16:7-г уншин ярилцлагаа өндөрлөж болно.

“Гэрээнүүдийг сахих,” хуу 48: Танай гэр бүлийн хэн нэг нь номлолд үйлчлэхээр бэлтгэж байгаа бол Ахлагч Холландын өгүүллийг уншиж, чухал санаануудыг нь тэмдэглэн авч болно. “Энэ ажлыг хийх түлхүүр бол гэрээнүүдээ сахих явдал юм” хэмээн хэлснийг нь онцлон хэл. Гэрээнүүд гэж чухам юу болох талаар ярилцаж, хүүхдүүд гэрээнүүдийг яаж хийж болох вэ гэж асуу.

“Тэр тэнд байгаа” хуу 69: “A Child’s Prayer”-г дуул. (Children’s Songbook, 12). Вискон эгчийн залбиралын тухай түүхийг уншиж, хувийн залбирлынхаа тухай жишээнээс хуваалцахыг гэр бүлийн гишүүдээсээ хүс. “Залбирсны үр дүнд тайвшралыг хүлээн авсан үеэ санаж байна уу?” гэж та асууж болно. Залбирлын тухай гэрчлэлээр ярилцлагаа өндөрлө. ■

Хөгжилтэй үйл ажиллагаа болон Мөнхийн сургаал

Өсвөр насандаа би гэр бүлийн үдэшдээ дургүйхэн оролцдог байлаа. Өөр зүйл хийж байсан нь дээр юм шиг надад санагддаг байв.

Нэгэн даваа гарагийн үдэш ээж маань хоолны ширээгээ арчаад дээр нь интоорын жижигхэн бялуу тавилаа. Ширээн дээр нэг ч сэрээ байсангүй! Гар болон сэрээ хэрэглэхгүйгээр бялуу идэх тэмцээн зохиох гэж буйгаа ээж маань тайлбарлалаа. Ялагч нь “бардамнан онгирох” эрхтэй болно гэж ээж маань хэлэв.

Бид ч чадлаараа хурдан идэцгээв. Удалгүй бид ширээг болон өөрсдийн нүүрээ интоорын бялуугаар будсан байв. Бүр үсээ хүртэл бялуу болгосон байлаа. Би тэмцээнд хэн ялсныг санадаггүй ч учир зүггүй хөхрөлдөж, гэр бүлийнхэнтэйгээ их л аз жаргалтай байснаа санадаг. Тэр үедээ сайн ойлгоогүй ч аюулгүй гэрт амьдарч мөн биднийг харж хандан, хайрладаг хүмүүстэй байсандаа одоо би их талархдаг юм.

Тэр үдэш бид дуу дуулж, хичээл заасан. Мөн ээж маань бялуугаа хийж, цэвэрлэгээ хийх гэж олон цаг зарцуулсан гэдгийг би мэднэ. Гэр бүл чухал гэдгийг надад ойлгуулж өгсөн энэ үйл ажиллагаанд би талархаж явдаг. ■

Хеадер Моклер Тушер, АНУ Калифорни

МЭРГЭЖИЛТНЭЭС СУРАЛЦСАН НЬ

Жорж К.Робинзон

Мэс засалчийн хувьд мэргэжлийн ур чадвараа хэрхэн эзэмшсэнийг надаас олон хүн асуудаг. Хүн мэс засал хэрхэн хийх тухай хичээл заалгасны дараа яаж хийдгийг харж аваад, тэгээд л мэс засал хийхэд бэлэн болдог гэж зарим хүмүүс боддог. Мэргэжил, ур чадвар эзэмших талаар: хар, хий тэгээд заа гэсэн нэгэн егөөдөлтэй үг байдаг. Гэвч амьдрал дээр огт ийм байдаггүй.

Би мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тэвчээртэй, чадварлаг олон эмч нарын удирдлагаар олж авсан юм. Эхний үед тэдний мөрөн дээгүүр хардаг байснаа дараа нь ойртож очин мэс засал яаж хийдгийг хардаг байсан. Бүтэн жил ажигласны дараа мэс засалчийн “баруун гарын туслах” болоход тусалсан жижиг сажиг даалгавруудыг надад өгдөг болсон юм.

Дараа нь дахиад нэг жил мэс засалчийн ширээний нөгөө талд зогсож, энгийн мэс засал хийхэд түүний баруун гарын туслах болж ажиллав. Түүнээс хойш дахиад нэг, хоёр жил өнгөрсний дараа илүү нарийн төвөгтэй мэс заслуудад түүний баруун гарын туслах байхыг надад зөвшөөрсөн юм. Дараа нь туршлагатай мэс засалч миний баруун гарын туслахаар ажиллах үед би ивэрхийг засах мэтийн хамгийн энгийн мэс ажилбаруудыг гүйцэтгэдэг байлаа.

Анагаах ухааны сургууль дүүргэснээс хойш долоон жил дагалдан суралцсаны сүүлчийн жил нь туршлагатай мэс засалч миний баруун гарын туслахаар ажилласан үед нарийн төвөгтэй мэс заслуудыг хийхийг надад зөвшөөрсөн юм. Хамгийн агуу багш нар юуг яаж хийх хэрэгтэйг энгийн бөгөөд тодорхой арга замаар—мөн л тийм дагалдан суралцах үйл явцаар дамжуулан сурснаа надад харуулсан учраас тэд мэс заслыг гарамгай сайн хийж чаддагийг би ойлгосон билээ.

Суралцах үйл явц дуусч бие даан мэс



Мэс заслын оюутан байх үед надаас илүү ур чадвартай хэн нэгэн миний дэргэд үргэлж байдаг байлаа. Бурханы хүүхэд учраас надад ч гэсэн ийм ур чадвар эзэмших боломж бий.

засал хийдэг болох хүртэл миний баруун гарын туслах байсан мэс заслын авьяаслаг мэргэжилтнүүдийн гайхалтай удирдлагын ач тусыг би бүрэн дүүрэн дүрслэх аргагүй юм. Гэвч эдүгээ 30 жилийн дараа, надад тэвчээртэйгээр зааж, харуулж, засч залруулдаг байсан тэдний ур чадварыг өдөр бүр ашиглах явцдаа би багш нараа оюун ухаандаа дурсан санадаг билээ.

Сайн мэдээний зарчмуудад суралцах нь үүнээс ялгаагүй юм. Бид гарамгай тэвчээртэй нэгэн Багшийн туршлагаас шат шатаар заалгадаг билээ. Бид Түүнд найдан, үлгэр жишээг нь дагаж, удирдамж хүсэхэд Тэнгэр-

лэг Эцэг маань Ариун Сүнс, амьд бошиглогчдын үгс, судрууд болон хайраа харуулан үйлчилдэг бусад хүмүүсээр дамжуулан биднийг удирдамжаар адисалдаг. Зүйрлүүлбэл, бид итгэлээ бэхжүүлэхийн хэрээр Залуурч бидний замыг бартаагүй болгож, хэрэгтэй залруулга өгч, асуултуудад хариулан, үүнд зохистой байхын хэрээр бидэнд улам илүү их итгэл найдвар хүлээлгэн бидний дэргэд байдаг.

Мэс заслын зарим оюутан бие дааж ажиллан, юмсыг өөрийнхөөрөө хийхийг хүсдэг. Үүн лүгээ адил бид заримдаа Залуурчийнхаа тусламжгүйгээр ажиллах гэж оролддог. Гэвч би мэс засалчаар ажилласан олон жилийн турш, тэр байтугай одоо ч гэсэн, ялангуяа хүний амь хутганы ирэн дээр дэнжигнэж байгаа эгзэгтэй үед өөрөөсөө илүү туршлага, мэдлэгтэй баруун гарын туслахынхаа ур чадварыг үргэлж үгүйлэн санадаг билээ.

Сайн мэдээн дэх бидний өсөлт хөгжилт мөнх бус байдлын өмнөх амьдралд эхэлж, эдүгээ энэ дэлхийд үргэлжилж байгаа бөгөөд мөнх бус амьдрал төгссөний дараа ч урт удаан хугацаанд үргэлжлэх нь эргэлзээгүй юм. Гэвч бидний туршлагын бүх үе шатанд Аврагч бидний өмнө явж, амжилтанд хүрэхэд шаардлагатай ур чадваруудыг харуулдаг. Мөн Тэрбээр Өөртөө болон Өөрийнхөө мэдлэг туршлагад найдвар тавихад бүх хүмүүсийг урьдаг билээ. ■



Дэлхийн гэрэл, Ховард Лайон

“Болгоогтун, би бол хууль, мөн гэрэл. Надад хандагтун, мөн эцсээ хүртэл тэвчигтүн, мөн та нар амьдрах болно; учир нь эцсээ хүртэл тэвчсэн түүнд би мөнх амьдрал өгөх болно.

Болгоогтун, би та нарт зарлигууд өгсөн билээ; тиймийн тул зарлигуудыг минь дага. Мөн энэ бол хууль хийгээд бошиглогчид, учир нь тэд үнэхээр миний тухай гэрчилсэн юм” (3 Нифай 15:9–10).



Энэ жил бид Мормоны Номыг хувиараа, гэр бүлээрээ түүнчлэн Ням гарагийн хичээлээр судалснаар энэхүү эртний цэдэг нь “хүсүүштэй, бүр бид үр хүүхдүүддээ Их Эзэний зарлигуудыг сахиулан өвлүүлэхүйц агуу эрхэм болохыг” (1 Нифай 5:21) Лихайн адил мэдэх болно. 14-р хуудсан дахь “Мормоны Номонд дуртай болоход нь хүүхдүүдэд хэрхэн туслах вэ,” 16-р хуудсан дахь “Мормоны Номноос хариуг олох нь” хэсгүүдийг үз.